



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



JAPAN GOV
THE GOVERNMENT OF JAPAN



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Save the Children

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



**“ОРОН НУТГИЙН ӨСВӨР
ҮЕИЙНХЭНД ХУВЬ ХҮНИЙ УР
ЧАДВАР, ЭНТРЕПРЕНЕРШИП
БОЛОВСРОЛ ОЛГОХ” ТӨСӨЛ
(2019-2025)**

**ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2025 он

СУДЛААЧДЫН БАГ

Энэхүү тайланг боловсруулахад дараах судлаачдын баг хамтран ажиллав. Үүнд: МЭС ХХК-ийн Гүйцэтгэх захирал Л. Золбаатар, lamjav@mec.mn; Өгөгдлийн шинжээч, МУИС-ийн багш Б. Энх-Амгалан, benkh25@gmail.com; Өгөгдлийн шинжээч, МУИС-ийн багш Б. Хишигням, khishignyam@num.edu.mn; Төслийн үндэсний психометрикийн зөвлөх, МУИС-ийн багш Х. Сайнсанаа, sainsanaa.kh@num.edu.mn; МЭК ХХК-ийн Судлаач П. Төрмөнх, purevsambuu@mec.mn; МЭК ХХК-ийн Судлаач Б. Оюунчимэг, om@mec.mn; Орчуулагч Б. Амарзаяа, amarzayabayasgalan@gmail.com; болон Судалгааны багийн ахлагч, МУИС-ийн багш Д. Бадамдаш, badamdash@num.edu.mn.

© Save the Children International 2025.

Та энэхүү бүтээлийг Хүүхдийг Ивээх Сангийн Олон улсын Эвсэлийг эзэмшигч нь хэмээн заасан тохиолдолд ямар ч зорилгоор хуулах, түгээх, татаж авах болон бусад хэлбэрээр чөлөөтэй ашиглах боломжтой.

Хариуцлагаас татгалзах: Энэхүү эцсийн үр дүнгийн судалгааны тайланг Дэлхийн Банкны менежменттэйгээр хэрэгжүүлж буй “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний үр чадвар, энтрепренершип боловсрол олгох” (2019- 2025) төслийн хүрээнд бэлтгэв. Уг төслийг Япон Улсын Засгийн газар Японы Нийгмийн Хөгжлийн Сангаар дамжуулан санхүүжүүлэв. Тайланд тусгагдсан үзэл баримтлал нь зөвхөн зохиогчдынх бөгөөд Хүүхдийг Ивээх Сангийн гишүүн байгууллага болон Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын бодлогын байр суурийг, түүнчлэн Дэлхийн Банк эсвэл хандивлагчийн байр суурийг илэрхийлэхгүй, мөн төлөөлөхгүй болно. Энэхүү нийтлэл дэх мэдээлэл нь тайланг боловсруулах үеийн мэдээлэлд үндэслэсэн болно.

ТАЛАРХАЛ

Энэхүү эцсийн үр дүнгийн үнэлгээний судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд үнэтэй зөвлөгөө, тууштай дэмжлэг, тасралтгүй хамтын ажиллагаагаар ханган ажилласан Монгол дахь Японы Хүүхдийг Ивээх Сангийн төслийн баг хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье. Хүүхэд бүрийн амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах эрхэм зорилготойгоор ажиллаж буй тэдний хичээл зүтгэл, бидний хамтын зорилгын төлөөх түншлэл нь уг судалгааны ажлыг амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Төслийн багийн гишүүдийн мэдлэг, туршлага нь манай судалгааны багийн ажлын явц болон үр дүнд үнэтэй хувь нэмэр оруулсан юм.

ГАРЧИГ

8

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

9

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

12

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

13

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

17

Бүлэг 1.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ҮНДЭСЛЭЛ



1.1. Төслийн тухай	17
1.2. Эцсийн үр дүнгийн үнэлгээний зорилго	19
1.3. Онолын хүрээ	20
1.4. Арга зүй	22
1.5. Судалгааны хязгаарлалт	23
1.6. Түүврийн статистик болон түүвэрлэлт	24
1.7. Судалгааны газар зүйн хамрах хүрээ	27
1.8. Мэдээлэл цуглуулах явцад тулгарсан саад бэрхшээл	28
1.9. Судалгааны ёс зүй	28

30

Бүлэг 2.

ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ



2.1. ESEL Мэдлэг	30
2.2. ESEL Үр чадвар	33
2.3. ESEL Сэтгэлгээ	40
2.4. Амьдралын хүсэл эрмэлзлэл	46

59

Бүлэг 3.

ANCHORING VIGNETTES ТОХИРУУЛГА



3.1. Anchoring Vignettes аргын хүчин төгөлдөр байдал	61
3.2. Anchoring Vignettes ашиглан өөрийн үнэлгээг засварлах	63
3.3. Тодорхойлох статистик	69
3.4. Хүчин төгөлдөр байдлын тест (Найдварт чанар, Хүчин зүйлийн шинжилгээ, Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ)	72

79

Бүлэг 4.

ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ



- 4.1. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт 79
- 4.2. ESEL үр чадварын дүн шинжилгээ (AV ашигласан өөрийн үнэлгээний оноо) 83
- 4.3. Регрессийн шинжилгээ 85
- 4.4. Өгөгдлийн шинжилгээний дүгнэлт 88

91

ДҮГНЭЛТ



- 5.1. Үндсэн болон хяналтын бүлгийн харьцуулалтын дүгнэлт 91
- 5.2. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалтын дүгнэлт 92
- 5.3. Тоон болон чанарын судалгааны тойм 92
- 5.4. Хөтөлбөрийг сайжруулах санал 93

94

САНАЛ, ЗӨВЛӨМЖ



- 6.1. Бодлогын санал, зөвлөмж 94
- 6.2. Цаашдын судалгааны чиглэл 95

96

ХАВСРАЛТ

- Хавсралт А: Хүүхэд, залууст зориулсан асуулга 96
- Хавсралт Б. Багш нарт зориулсан асуулга 119
- Хавсралт В: Судалгаанд хамрагдаагүй оролцогчдын тайлбар 129

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

AV/AVs	Anchoring Vignette/Anchoring Vignettes
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ДБ	Дэлхийн Банк
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ESEL	Энтерпренершипд суурилсан хувь хүний ур чадвар
МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв
НТБТ	Насан Туршийн Боловсролын Төв
ССЭ	Сургуульд суурилсан энтерпрайз
СБС	Сургагч багшийн сургалт
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ЭХХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЯНХС	Японы Нийгмийн Хөгжлийн Сан
ХИС	Японы Хүүхдийг Ивээх Сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 4. ESEL мэдлэг бүлгийн статусаар	31
Хүснэгт 5. ESEL мэдлэгийг эзэмших амжилтын түвшин	32
Хүснэгт 6. Өөрийгөө танин мэдэх үр чадвар	34
Хүснэгт 7. Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар	35
Хүснэгт 8. Харилцааны үр чадвар	37
Хүснэгт 9. Багаар ажиллах үр чадвар	38
Хүснэгт 10. Тунгаан бодох үр чадвар	39
Хүснэгт 11. Өсөн дэвших сэтгэлгээ	41
Хүснэгт 12. Энтерпренерийн сэтгэлгээ	42
Хүснэгт 13. Суурь судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар	43
Хүснэгт 14. Суурь судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар (Суурь болон Эцсийн)	44
Хүснэгт 15. Эцсийн судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар	44
Хүснэгт 16. Судалгааны үр дүнгийн дундаж утгын харьцуулалт	45
Хүснэгт 17. Бусдын төлөө ажиллахаас илүүтэйгээр өөрийнхөө төлөө ажиллах нь хүүхэд, залуусын хувьд хэр чухал эсэх (Суурь болон Эцсийн)	46
Хүснэгт 18. Өөрийнхөө хувийн бизнесийг эрхлэх/компания ажиллуулах нь хүүхэд, залуусын хувьд хэр ач холбогдолтой эсэх	47
Хүснэгт 19. Өөрийнхөө хувийн бизнесийг эрхлэх/компания ажиллуулах нь хүүхэд, залуусын хувьд хэр ач холбогдолтой эсэх (Суурь болон эцсийн)	47
Хүснэгт 20. Хүүхэд, залуусын сайн сайхан зүйлд итгэж буй хандлагын түвшин	48
Хүснэгт 21. Хүүхэд, залуусын сайн сайхан зүйлд итгэж буй хандлагын түвшин (Нийт)	48
Хүснэгт 22. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин	48
Хүснэгт 23. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Нийт)	49
Хүснэгт 24. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Үндсэн)	49
Хүснэгт 25. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Хяналт)	49
Хүснэгт 26. Завгүй байхын ач холбогдлын түвшин	50
Хүснэгт 27. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Нийт)	50
Хүснэгт 28. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Үндсэн)	50
Хүснэгт 29. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Хяналт)	51
Хүснэгт 30. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар	51
Хүснэгт 31. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусыг сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Нийт)	52
Хүснэгт 32. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Үндсэн)	52
Хүснэгт 33. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Хяналт)	53
Хүснэгт 34. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх	53

Хүснэгт 35. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх. (Нийт)	54
Хүснэгт 36. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх (Үндсэн)	54
Хүснэгт 37. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх (Хяналт)	54
Хүснэгт 38. Нийгэм, эдийн засгийн байдал 5 жилийн дараа сайжрах эсэх	55
Хүснэгт 39. Нийгэм, эдийн засгийн байдал сайжирах эсэх (Нийт)	55
Хүснэгт 40. Нийгэм, эдийн засгийн байдал сайжирах эсэхийг хэрхэн үнэлж буй талаар (Үндсэн)	55
Хүснэгт 41. Нийгэм, эдийн засгийн байдал сайжирах эсэхийг хэрхэн үнэлж буй талаар (Хяналт)	56
Хүснэгт 42. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ?	56
Хүснэгт 43. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Нийт)	57
Хүснэгт 44. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Үндсэн)	57
Хүснэгт 45. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Хяналт)	57
Хүснэгт 46. Урт хугацаандаа шаргуу ажиллах нь илүү сайхан амьдралруу хөтөлнө.	58
Хүснэгт 47. AV аргын найдварт чанар	61
Хүснэгт 48. Өөрийн үнэлгээ болон vignette үнэлгээний тодорхойлох статистик	62
Хүснэгт 49. Өөрийн үнэлгээний оноог AV арга ашиглан засварлах дүрмүүд	64
Хүснэгт 50. ESEL үр чадварын өөрийн үнэлгээ болон засварласан онооны хамаарал	64
Хүснэгт 51. ESEL сэтгэлгээний өөрийн үнэлгээ болон засварласан онооны хамаарал	65
Хүснэгт 52. Өөрийн үнэлгээ болон AV засварласан оноо хүйсээр	65
Хүснэгт 53. AV засварласан оноо, сургуулийн хэлбэрээр	66
Хүснэгт 54. AV засварласан оноо, Эрэгтэй асран хамгаалагчийн оролцоогоор	67
Хүснэгт 55. AV засварласан оноо, Эмэгтэй асран хамгаалагчийн оролцоогоор	67
Хүснэгт 56. AV засварласан оноо, бүлгээр	68
Хүснэгт 57. Аймаг болон бүлэг	70
Хүснэгт 58. Сургалтын статус болон аймаг	71
Хүснэгт 59. Эцэг эхийн боловсрол, хувиар	71
Хүснэгт 60. Кронбах Альфа найдварт чанарын статистик	72
Хүснэгт 61. Хүчин зүйлийн шинжилгээ	72
Хүснэгт 62. Энтрепренершипийн суурь ойлголт	73
Хүснэгт 63. Энтрепренершипийн суурь ойлголтын бүрдэл хэсэг	74
Хүснэгт 64. Бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэгийн бүрдэл хэсэг	76
Хүснэгт 65. Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгслийн бүрэлдэхүүн хэсэг	77
Хүснэгт 66. Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээний үр дүн	77
Хүснэгт 67. Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хүчин зүйлийн шинжилгээний үр дүн	78

Хүснэгт 68. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (ESEL мэдлэг)	80
Хүснэгт 69. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (ESEL үр чадвар ба сэтгэлгээ)	81
Хүснэгт 70. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (Амьдралын хүсэл эрмэлзлэл)	82
Хүснэгт 71. ESEL үр чадвар болон сэтгэлгээний AV тохируулгатай онооны үр дүн, бүлгээр	84
Хүснэгт 72. Регрессийн тооцоолол болон загварын хураангуй	86
Хүснэгт 73. Регрессийн шинжилгээ, ANOVA	87
Хүснэгт 74. Регрессийн шинжилгээ, Коэффициентүүд	87

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны газар зүйн хамрах хүрээ	27
Зураг 2. Бусдын төлөө ажиллахаас илүүтэйгээр өөрийнхөө төлөө ажиллах нь хүүхэд, залуусын хувьд хэр чухал эсэх	46
Зураг 3. Оролцогчдын нас	69
Зураг 4. Оролцогчдын оршин суугаа байршил	70
Зураг 5. Оролцогчдын засаг захиргаа	70
Зураг 6. Скри график, Эргүүлэлтийн матриц (Энтрепренершипийн суурь ойлголт)	75
Зураг 7. Скри график, Эргүүлэлтийн матриц (Бизнес төлөвлөлт ба Санхүүгийн мэдлэг)	75
Зураг 8. Скри график, Эргүүлэлтийн матриц (Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгсэл)	76
Зураг 9. ESEL мэдлэгийн дундаж оноо, хүйсээр	80
Зураг 10. ESEL мэдлэгийн дундаж оноо, насаар	80
Зураг 11. ESEL үр чадвар ба сэтгэлгээ, хүйсээр	82
Зураг 12. Амьдралын хүсэл эрмэлзлэл, хүйсээр	83
Зураг 13. Харилцааны үр чадвар болон тунгаан бодох үр чадвар, хүйсээр	84

ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Эцсийн үр дүнгийн судалгааны гол зорилго нь “Энтерпренершипд суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийн зорилтот үр шим хүртэгсдэд үзүүлсэн ахиц дэвшил, үр нөлөөг үнэлэхэд оршино. Тодруулбал, уг үнэлгээ нь ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдсан зорилтот хүүхэд, залуусын энтерпренершипийн мэдлэг, хувь хүний үр чадвар, сэтгэлгээ хэр хөгжиж, сайжирсан талаар судлав. Үнэлгээг ESEL сургалтын хөтөлбөр нь хүүхэд, залуусын үр чадварыг хөгжүүлэхэд хэрхэн, хэр зэрэг хувь нэмэр оруулсан бэ гэсэн гол чиглүүлэх асуултын хүрээнд хийж гүйцэтгэв.

Уг үнэлгээний үр дүнг төсөл хэрэгжүүлэгчид, хандивлагчид, бодлого хэрэгжүүлэгч агентлагууд, бодлого боловсруулагчид үнэлж, цаашдын үйл ажиллагаандаа тусгах боломжтой.

Үүний тулд МЭК ХХК тоон болон чанарын судалгааг хийж, үндсэн болон хяналтын бүлгүүдийн суурь болон эцсийн үр дүнд шинжилгээ хийн харьцуулсан.

Тоон судалгаанд дараах хоёр бүлгийг хамруулсан: (i) суурь судалгаанд хамрагдсан (ESEL сургалт 1, 3-т хамрагдсан болон сургалтад хамрагдаагүй буюу хяналтын бүлгийн хүүхдүүд) болон ESEL сургалт 4-т хамрагдсан хүүхэд, залуусыг оролцуулан нийт 1,979 оролцогч; түүнчлэн (ii) судалгаанд хамрагдсан сурагчдын анги удирдсан багшаар ажилладаг 397 багшийг хамруулав. Судалгааны зорилтот түүврийн хэмжээ нь 2,012 байсан боловч судалгаанд оролцохоор жагсаалтад байсан хүүхэд, залуусаас зарим нь оролцох боломжгүй байсны улмаас бид зорилтот түүврийн 98% буюу 1,979 оролцогчдыг хамруулсан.

Чанарын судалгаа нь дараах хоёр дэд асуултад хариулахыг зорьсон:

1. ESEL-ийн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэхэд нөлөөлж буй гол хүчин зүйлс юу вэ?
2. Та ESEL сургалтын хөтөлбөрөөр сурсан зүйлсээ сургууль/ажил, амьдралдаа хэрхэн ашиглаж байна вэ?

Нийт 192 хүүхэд, залуус болон 86 ESEL сургалтын чиглүүлэгч багш/зөвлөх Фокус бүлгийн ярилцлагад (ФБЯ) оролцсон.

Түүврийн стратегийг Японы Хүүхдийг Ивээх Сангийн (ЯХИС) төслийн баг болон Дэлхийн Банкны зөвлөх, мэргэжилтнүүд гаргасан ба судалгааг хэрэгжүүлэгч байгууллага болох МЕК ХХК тухайн арга зүйг ашиглан судалгааг гүйцэтгэсэн.

Төслийн **өөрчлөлтийн онол** нь төслийн гол үйл ажиллагаа болох ESEL сургалтын хөтөлбөр, Пич уралдаан болон бичил төслийн хэрэгжилт нь зорилтот бүлэгт хамаарагдаж буй хүүхэд, залуусын

Энтерпренершипийн мэдлэг, хувь хүний ур чадвар, сэтгэлгээг сайжруулна гэж үзжээ. Энэхүү олж авсан мэдлэг, ур чадвар нь орон нутгийн хүүхэд, залуусын цаашдын ажил амьдрал, бизнес эрхлэх үйл ажиллагаа болон илүү сайхан амьдрахад нь ихээхэн нөлөөлнө гэж тодорхойлжээ.

Гол үр дүн

ESEL мэдлэг: Үндсэн болон хяналтын бүлгийг хооронд нь харьцуулахад үндсэн бүлэг суурь үнэлгээнээс эцсийн үнэлгээ хооронд 2.47 хувийн ахиц гаргасан нь харагдсан ба энэ нь хөтөлбөрийн эерэг нөлөөг бататгасан үзүүлэлт юм.

ESEL ур чадвар ба сэтгэлгээ: Ур чадвар, сэтгэлгээний үнэлгээний хувьд судалгааны үр дүнг кодлосон ба бага оноо нь илүү сайн үр дүнг илэрхийлнэ. Тиймээс дурдсан 8 хэсгийн (Өөрийгөө танин мэдэх, Нийгэм, соёлыг танин мэдэх ур чадвар, Бүтээлч байдал ба инноваци, Харилцааны ур чадвар, Багаар ажиллах ур чадвар, Тунгаан бодох ур чадвар гэсэн 8 ур чадвар болон 2 сэтгэлгээ болох Өсөн дэвших сэтгэлгээ, Энтерпренерийн сэтгэлгээ) үр дүнгээс харахад хяналтын болон үндсэн бүлгийн ялгаа тодорхой харагдаж байгаа ба энтерпренерийн сэтгэлгээ 1.84 гэх хамгийн бага оноотой буюу хамгийн сайн үзүүлэлттэй байсан бол Харилцааны ур чадвар 2.23 оноотойгоор хамгийн өндөр дундаж оноотой буюу хамгийн тааруу үзүүлэлттэй байсан юм. Суурь судалгааны үнэлгээтэй харьцуулахад Харилцааны ур чадвар, Тунгаан бодох ур чадвар, Өсөн дэвших сэтгэлгээ болон Энтерпренерийн сэтгэлгээ сайжирсан байв.

Илүү сайтар, бодитой үнэлгээг хийхийн тулд судалгааны баг Anchoring Vignettes (AV)¹ (Өгүүлэмж бүхий асуулга) арга ашиглан тохируулга хийсэн. Энэхүү арга нь оролцогчдод зохиомол дүрүүдийг танилцуулж, тэдний хариултыг харьцуулах замаар өөрийн үнэлгээнд нийтлэг тохиолддог алдаа, гажуудлыг бууруулдаг. Мөн судалгаанд оролцогчдын ойлголтыг сайжруулж, нийгмийн хүлээлтэд нийцсэн хариу өгөх хандлагыг бууруулснаар өгөгдлийн бодит байдал, найдварт чанарыг нэмэгдүүлдэг.

Түүнчлэн Кронбах Альфа тест (Cronbach-Alpha) болон Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн (ҮБХ) шинжилгээг ашиглан судалгааны найдвартай, хүчин төгөлдөр байдлыг шалгасан. Эдгээр статистик шинжилгээний үр дүнгээс харахад ESEL мэдлэг, ур чадвар болон сэтгэлгээг тодорхойлохыг зорьсон тоон судалгаа найдварт байдлын шалгуурт нийцэж байна гэж дүгнэж болно. Гэсэн хэдий ч Амьдралын хүсэл эрмэлзлэлийн талаарх асуулга судалгаанд оролцогчдод төдийлөн ойлгомжтой биш байсан нь тогтоогдсон.

- Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээгээр асуултуудыг 11 бүлэгт хуваасан ба эдгээр нь анхдагч вариацийн 61% буюу хангалттай хувийг агуулж байна.
- Бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэгтэй холбоотой асуултууд 4 бүлэгт хуваагдсан ба эдгээр нь өгөгдлийн 58 хувийг агуулж байна.

¹ Anchoring Vignette(s) аргыг Монгол хэл дээр хамгийн оновчит утгаар Өгүүлэмж бүхий асуулга хэмээн орчуулж болох ч энэхүү судалгааны тайланд Англи нэршлээр нь буюу Anchoring Vignette хэмээн оруулсан болно.

- Мөн нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон дижитал хэрэгслийн асуултуудыг 4 бүлэгт хуваасан ба энэ нь анхдагч вариацийн 61 хувийг агуулж байна.

Кронбах Альфа болон Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээний үр дүнгээр ESEL үр чадвар болон сэтгэлгээний асуулгын тоон өгөгдлийн найдварт чанар хангалттай байна. Мөн Энтрепренершип болон Амьдралын хүсэл эрмэлзлэл хэсгийн тоон өгөгдлийн найдварт чанарыг хангалттай гэж үзэж болно.

Илүү нарийвчилсан шинжилгээ хийхийн тулд суурь болон эцийн судалгаанд хамрагдсан оролцогчдын өгөгдлийг ашиглан кохорт буюу сургалтын ээлж² бүрээр дэд шинжилгээг хийж, хариултыг мөн Anchoring Vignettes аргачлалаар тохируулсан. Судалгаанд 13-19 насны нийт 785 хүүхэд, залуус хамрагдсан (дундаж нас = 15.7) ба үүнээс 39.4 хувь (309) нь эрэгтэй, 60.6 хувь (476) нь эмэгтэй байв.

Хүн ам зүйн мэдээлэл:

- Эмэгтэй оролцогчид болон 16-19 насны судалгаанд оролцогчдын дунд ESEL мэдлэг өндөр байв.
- Сургалтад хамрагдсаны дараа ESEL үр чадвар болон Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хүйсийн ялгаа багассан.

AV тохируулга хийхэд Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, Харилцааны үр чадвар болон Өсөн дэвших сэтгэлгээний хувьд үндсэн бүлэг хяналтын бүлгээс илүү өндөр үзүүлэлттэй байв.

Регрессийн шинжилгээ:

Үр чадвар болон сэтгэлгээний хөгжилд соёлын бүлэг, оршин суугаа газар, ESEL сургалтын статус, амьдралын хүсэл эрмэлзлэл, эцэг эхийн боловсрол, нас, хүйс нөлөөлдөг эсэхийг тодорхойлохын тулд регрессийн шинжилгээ хийсэн.

Регрессийн шинжилгээгээр 3 хүчин зүйл нөлөөлдөг болох нь харагдсан:

$$\text{ESEL чадвар, сэтгэлгээ} = 1.802 \cdot \text{ESEL мэдлэг} + 0.398 \cdot \text{Амьдралын хүсэл эрмэлзлэл} - 0.021 \cdot \text{нас}$$

Тайлбар:

- ESEL-ийн мэдлэг өндөр байх болон нас ахих тусам Үр чадвар, сэтгэлгээний оноо илүү сайн (багассан) байх хандлагатай байна.
- Сонирхолтой нь, Амьдралын хүсэл эрмэлзлэл өндөр байх нь Үр чадвар, сэтгэлгээний үр дүн муу байгаатай хамааралтай байв. Энэ нь тэмүүлэл өндөртэй хүүхэд, залуус өөрсдийн үр чадварт илүү өндөр шаардлага тавьж, өөрсдийгөө шүүмжилж, үр чадвар болон сэтгэлгээгээ доогуур үнэлдэг байх магадлалтайг харуулж байна.

² ESEL training cohort буюу ESEL сургалтын ээлж гэдэг нь төслийн хүрээнд зохион байгуулагдсан нийт 7 удаагийн ESEL сургалт тус бүрийг хэлнэ. Энэхүү судалгаанд ESEL сургалтын ээлж 1, 3 болон 4-т хамрагдсан хүүхэд, залуус оролцсон болно.

Ерөнхийдөө үндсэн бүлэг нь хяналтын бүлгээс ESEL мэдлэгийн хувьд мэдэгдэхүйц өндөр үзүүлэлттэй байв. Гэсэн хэдий ч эцсийн үнэлгээгээр Амьдралын хүсэл эрмэлзлэл болон ESEL ур чадвар/сэтгэлгээний онооны хувьд бүлгүүдийн хооронд онцгой ялгаа ажиглагдаагүй.

Чанарын судалгааны үр дүн:

Фокус бүлгийн ярилцлагад оролцогчид тус сургалтын хөтөлбөр нь зан байдалд эерэг нөлөө үзүүлсэн гэдгийг хэлсэн ба тухайлбал, багаар ажиллах ур чадвар, харилцааны ур чадвар, цагийн менежмент, хариуцлагатай байх болон манлайлах ур чадварт нь ахиц гарсан байна. Эмэгтэй оролцогчдод ялангуяа мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдав. Мөн оролцогчид сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сонсох чадвар болон энтрепренерийн ур чадвар сайжирсан гэж дурдсан.

Эхэндээ багаар ажиллахад үзэл бодлын зөрүүгээс шалтгаалсан саад бэрхшээлүүд тулгарсан ч оролцогчид эдгээр бэрхшээлийг чадварлагаар даван туулж, нэгдмэл байдал болон хамтын ажиллагаагаа сайжруулсан.

Фокус бүлгийн ярилцлага нь зөвхөн үндсэн бүлгийн оролцогчдыг хамруулсан тул батлах хандлагын гажуудалтай (confirmation bias) байж болох ч нийт оролцогчдын 98%-ийг хамруулсан тоон судалгааны үр дүн нь чанарын судалгааны гол үр дүнг давхар баталж байна.



Бүлэг 1.

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ҮНДЭСЛЭЛ

1.1. Төслийн тухай

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь “Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” (2019-2025) төслийг Ховд, Завхан, Өвөрхангай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгийн 29 суманд 5.5 жилийн хугацаатай хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл нь Японы Нийгмийн хөгжлийн сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилттэйгээр, Дэлхийн банкны менежментийн хүрээнд хэрэгжиж байна. Монгол Улсын хөдөө орон нутагт ажлын байр хомс, ур чадвар дутмаг байдгаас өсвөр үеийн хүүхэд, залуус ихээхэн бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс төсөл нь өнөөгийн хөдөлмөрийн зах зээлд хамгийн ихээр шаардагдаж буй хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсролыг өсвөр үеийн хүүхэд, залууст олгосноор тэдний сурлагын үр дүнг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтэд бэлдэх зорилготой.

“Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох” төсөл нь дээр дурдсан орон нутгийн 14-25 насны сургуулиас завсардах болон ажилгүйдэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, залуусын энтрепренер чиг баримжаатай хувь хүнийур чадварыгдээшлүүлэх зорилготой ба уг зорилтод хүрэхийн тулд сурлагын амжилтад нөлөөлдөг, мөн хөдөлмөрийн зах зээлд өндрөөр үнэлэгддэг хувь хүний ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн, сургуульд суурилсан, орон нутгийн оролцоотой “Энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх” (ESEL) сургалтын хөтөлбөрийг боловсруулан нэвтрүүлжээ.

Төсөл нь уг ESEL сургалтын хөтөлбөрт сургуульд суралцаж буй болон сургуулиас завсардсан өсвөр үеийн 8,000 хүүхэд, залуусыг хамруулах зорилготой ба үүгээр дамжуулан орон нутагт амьдарч буй өсвөр үеийнхэний дунд идэвхигүй байдал үүсгэхэд хүргэдэг хөдөлмөрийн зах зээлийн хязгаарлагдмал боломж болон уламжлалт мал аж ахуй, цалин хөлсгүй хөдөлмөр, хувиараа хөдөлмөр эрхлэлт давамгайлсан албан бус хөдөлмөрийн салбараас үүдэлтэй энтрепренер болон хувь хүний ур чадварын хэрэгцээг хангах ажээ.

Төсөл нь орон нутгийн зорилтот бүлгийн хүүхэд, залуусын ESEL-ийн мэдлэг, ур чадвар, сэтгэлгээний хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна:

- **I бүрэлдэхүүн хэсэг:** Зорилтот хүүхэд, залуучуудад зориулсан энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх шинэлэг, орон нутгийн онцлогт тохирсон, олон нийтийн оролцоотой хөтөлбөрийг боловсруулан нэвтрүүлэхэд чиглэнэ. Төслийн хэрэгжилтийн эхэн үед ESEL сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 594 багшийг ESEL-ийн чиглүүлэгч багш/зөвлөхөөр бэлтгэн сургасан. 2021 оны хавраас хэрэгжиж эхэлсэн тус хөтөлбөрийг нийт 7 удаа зохион байгуулж, 8,773 хүүхэд, залуусыг хамруулжээ. ESEL сургалтын хөтөлбөр нь эхэндээ танхимд суурилсан байсан боловч COVID-19 цар тахлын үед тулгарч буй сорилттой уялдуулан сургуулиас гадуурх өсвөр үеийнхэний сурах хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сард танхимын болон зайн сургалтыг хослуулсан шинэ хэлбэр болох хосолсон ESEL сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.
- **II бүрэлдэхүүн хэсэг:** Уг бүрэлдэхүүн хэсэг нь зорилтот бүлгийн хүүхэд, залуусыг ESEL сургалтын хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, ур чадвараа орон нутгийн зах зээлийн хэрэгцээ, бизнесийн боломжийг хангахад ашиглан туршлага хуримтлуулах механизмыг бий болгох зорилготой. Үүний тулд Пич (Pitch) арга хэмжээг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудад санхүүгийн дэмжлэг авах бизнесийн санаагаа танилцуулах боломжийг олгосон. Төслийн хүрээнд 3,000 гаруй хүүхэд, залуучуудыг хамруулсан нийт найман (8) удаагийн Пич арга хэмжээг зохион байгуулжээ. Пич уралдаанд бизнесийн санаагаа танилцуулсан хүүхэд, залуусын багуудаас талаас илүү хувь нь бичил тэтгэлэг авч, төслөө хэрэгжүүлж байна. Түүнчлэн бүрэлдэхүүн хэсэг II-ын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулиудад байгаа боломжит нөөцийг ашиглах, оролцогч сурагчдын ESEL-ийн мэдлэг,

ур чадвар, сэтгэлгээг бататгахад дэмжлэг үзүүлэх Сургуульд суурилсан энтерпрайз (ССЭ) санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

- **III бүрэлдэхүүн хэсэг:** Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь нотолгоонд суурилсан нөлөөлөл, олон нийтэд чиглэсэн кампанит ажил явуулах замаар энтрепренершип боловсролыг дэмжих бодлогын орчныг сайжруулах зорилготой. Мөн олон нийтийн оролцоонд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ) болон төслийн менежментийн дэмжлэг нь уг бүрэлдэхүүн хэсэгт хамаардаг. ESEL сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн өмнөх нөхцөл байдлыг тодорхойлох, цаашдын төслийн үнэлгээнд нотлох баримт бэлтгэх зорилгоор уг бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд суурь судалгааг хоёр удаа хийжээ.

1.2. Үр дүнгийн үнэлгээний зорилго

Эцсийн үр дүнгийн судалгааны гол зорилго нь ESEL сургалтын хөтөлбөрийн зорилтот үр шим хүртэгсдэд үзүүлсэн ахиц дэвшил, үр нөлөөг хэмжих юм. Өөрөөр хэлбэл эцсийн үнэлгээ нь зорилтот хүүхэд, залуучуудын дунд энтрепренершипийн мэдлэг, хувь хүний үр чадварын (ESEL) ахицыг ESEL сургалтын хөтөлбөртэй холбон үнэлнэ.

Эцсийн үр дүнгийн үнэлгээний судалгаа нь **ESEL сургалтын хөтөлбөр зорилтот хүүхэд, залуучуудын үр чадварыг хөгжүүлэх үр дүнг сайжруулахад хэрхэн, хэр зэрэг хувь нэмэр оруулсан бэ** гэдгийг хэмжих юм. Тус үнэлгээний үр дүнг төсөл хэрэгжүүлэгчид, хандивлагчид, бодлого хэрэгжүүлэгч агентлагууд, бодлого боловсруулагчдад үнэлэлт, дүгнэлт хийн цаашдын үйл ажиллагаандаа тусгахад ашиглах боломжтой.

Эцсийн ахиц дэвшил, үр нөлөөг үнэлэхийн тулд MEK судалгааны компанитай чанарын болон тоон судалгаа зохион байгуулж, дүн шинжилгээ хийх гэрээ байгуулсан.

Тоон судалгаа нь судалгааны үндсэн буюу гол чиглүүлэх асуултын дагуу хоёр бүлгийг хамруулсан:

I. Нийт 1,979 хүүхэд, залуус:

- Суурь судалгаанд хамрагдсан оролцогчид (ESEL сургалт 1, 3 сургалтад хамрагдсан болон сургалтад хамрагдаагүй, хяналтын бүлгийн хүүхдүүд)
- ESEL сургалт 4-т хамрагдсан оролцогчид

II. Судалгаанд оролцогчдын анги удирдсан 397 багш.

Судалгааны зорилтот түүвэр нь 2,012 байсан боловч жагсаалтад хамрагдагсдын 33 нь судалгаанд хамрагдах боломжгүй байсны улмаас нийт 1,979 хүн буюу зорилтот түүврийн 98%-ийг судалгаанд хамруулсан.

Чанарын судалгаа нь дараах хоёр дэд асуултыг хэмжих зорилготой:

1. ESEL-ийн мэдлэг, ур чадварыг сайжруулахад нөлөөлж буй гол хүчин зүйлс юу вэ?
2. Хүүхэд, залуус ESEL сургалтын хөтөлбөрөөр сурсан мэдлэг, ур чадвараа сургууль/ажил болон өдөр тутмын амьдралдаа хэрхэн ашиглаж байна вэ?

Чанарын судалгааны хүрээнд дараах 2 бүлэгтэй **Фокус бүлгийн ярилцлага (ФБЯ)** хийсэн:

1. Зорилтот 29 сумын зөвхөн ESEL сургалтад хамрагдсан эсвэл тус сургалтад хамрагдсан болон бичил тэтгэлэг авсан хүүхэд, залуучууд
2. ESEL-ийн сургалтыг чиглүүлэн явуулсан ESEL сургалтын багш/зөвлөх

Нийт 192 хүүхэд, залуус, 86 ESEL сургалтын багш/зөвлөх ФБЯ-д оролцсон.

1.3. Онолын хүрээ

Төсөл нь сургуульд суралцаж буй болон сургуулиас гадуурх 8,000 хүүхэд, залуусын энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх зорилготой. Эдгээр ур чадвар нь сурлагын амжилтыг дээшлүүлэхийн зэрэгцээ ажил эрхлэх ур чадварг ахиулж болон урт хугацааны хөдөлмөрийн зах зээлд бий болох үр дүнг сайжруулна.

Энэхүү төслийг үндэслэсэн онол нь хоёр үндсэн үйл ажиллагааны үр нөлөөг чухалчилдаг:

1. I бүрэлдэхүүн - ESEL сургалтын хөтөлбөр:

Зорилтот хүүхэд, залуучуудад зориулсан энтрепренершипд суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх шинэлэг, орон нутгийн онцлогт тохирсон, олон нийтийн оролцоотой хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн. Төслийн хэрэгжилтийн эхэн үед ESEL сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж, 594 багшийг ESEL-ийн чиглүүлэгч багш/зөвлөхөөр бэлтгэсэн. 2021 оны хавраас хэрэгжиж эхэлсэн тус хөтөлбөрийг нийт 7 удаа зохион байгуулж, 8,773 хүүхэд, залуусыг хамруулжээ. ESEL сургалтын хөтөлбөр нь эхэндээ танхимд суурилсан байсан ч COVID-19 цар тахлын үед тулгарч буй сорилттой уялдуулан сургуулиас гадуурх өсвөр үеийнхэний сурах хэрэгцээнд нийцүүлэх зорилгоор 2022 оны 10 дугаар сард танхимын болон зайн сургалтыг хослуулсан шинэ хэлбэр болох хосолсон ESEL сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн.

2. II бүрэлдэхүүн – Пич уралдаан болон ССЭ-ын үйл ажиллагаагаар дамжуулан мэдлэг, ур чадвараа бэхжүүлэх:

Төсөл нь зорилтот бүлгийн хүүхэд, залуусыг ESEL сургалтын хөтөлбөрөөс олж авсан мэдлэг, ур чадвараа орон нутгийн зах зээлийн хэрэгцээ, бизнесийн боломжийг хангахад ашиглан туршлага хуримтлуулах механизмыг бий болгосон. Энэ хүрээнд Пич арга хэмжээг

орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудад санхүүгийн дэмжлэг авах бизнесийн санаагаа танилцуулах боломжийг олгосон. Төслийн хүрээнд 3,000 гаруй хүүхэд, залуучуудыг хамруулсан ба нийт найман (8) удаагийн Пич арга хэмжээг зохион байгуулжээ. Пич уралдаанаар бизнесийн санаагаа танилцуулсан хүүхэд, залуусын талаас илүү хувь нь бичил тэтгэлэг авч, төслөө хэрэгжүүлээд байна. Түүнчлэн Ерөнхий боловсролын сургуулиудад байгаа боломжит нөөцийг ашиглах, оролцогч сурагчдын ESEL-ийн мэдлэг, ур чадвар, сэтгэлгээг бататгахад дэмжлэг үзүүлэх Сургуульд суурилсан энтерпрайз (ССЭ) санаачлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.

Үйл ажиллагаа

- **I бүрэлдэхүүн:** 2021 оны хавраас эхлэн хэрэгжүүлсэн ESEL сургалтын хөтөлбөрийн чиглүүлэгч багш/зөвлөхөөр 594 багшийг бэлтгэж, нийт 7 удаагийн сургалтад 8,773 хүүхэд, залуус хамруулсан.
- **II бүрэлдэхүүн:** Дээрх сургалтад хамрагдсан хүүхэд, залууст зориулан өөрийн бизнес санаагаа танилцуулах, хэрэгжүүлэх боломжоор хангах бичил тэтгэлгийн Пич уралдааныг 8 удаа зохион байгуулж, төслийн хүрээнд 3,000 гаруй хүүхэд залуусыг хамруулжээ.

Гарах үр дүн

Төслийн өөрчлөлтийн онолоор багийн ажиллагаа, Пич арга хэмжээ, бичил төслийн хэрэгжилтийг хослуулсан ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдах нь хөдөлмөрийн зах зээлийн боломж хомс, залуучуудын идэвхигүй байдал өндөртэй төслийн зорилтот орон нутгийн хүүхэд, залуусын энтрепренершипийн мэдлэг, хувь хүний ур чадвар, сэтгэлгээ хөгжүүлнэ гэж үзсэн.

Эдгээр хүлээгдэж буй үр дүнг дараах хэсгүүдээр хэмжинэ:


- o ESEL ур чадвар ба сэтгэлгээ
- o Амьдралын хүсэл эрмэлзлэл
- o Ерөнхий ESEL мэдлэг

Үр дүн, нөлөө

Төслийн орон нутгуудад энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварыг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлыг арилгах замаар тус төсөл нь зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын сурлага, хөдөлмөр эрхлэлтийн амжилтад хүрэх арга хэрэгслээр хангахыг зорьж байна.

Энэхүү төсөл нь Монголын хөдөө орон нутгийн зорилтот бүлгийн хүүхэд, залуучуудын амьдралыг сайжруулах чухал алхам юм. Энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварыг дэмжих замаар эдийн засгийн хувьд хамгийн бэрхшээлтэй нийгэмд амьдарч буй хүүхэд, залуучуудын бие даасан байдал, өөртөө итгэх итгэл болон боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулна.

Үүнийг дараах бүдүүвчээр дүрслэн харуулав.



1.4. Арга зүй

Эцсийн үр дүнгийн судалгааны асуулгыг боловсруулахдаа суурь судалгаанд ашигласан ижил асуултуудаас гадна Хүүхдийг Ивээх Сангийн төслийн баг, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн саналын дагуу нэмэлт асуултууд оруулсан. Мөн Төслийн Үндэсний психометрикийн зөвлөх Х. Сайнсанаа болон олон улсын зөвлөхүүдийн боловсруулсан AV (Anchoring vignettes) асуултуудын дагуу үнэлгээг илүү нарийвчлах шинэ асуулгыг боловсруулсан. Эдгээр асуултууд нь энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадвар, сэтгэлгээг хэмжихэд чиглэсэн. Судалгааны асуулгын шинэчилэн сайжруулсан хувилбарын үр дүнтэй байдал болон ойлгомжтой байдлыг үнэлэх зорилгоор туршилт судалгааг зохион байгуулж, уг туршилт судалгааны үр дүнд асуулгын эцсийн хувилбарыг баталгаажуулан, таван үндсэн

хэсэгт хуваасан. Үүнд:

- о Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл
- о Энтрепренершипд суурилсан хувь хүний мэдлэг, ур чадвар
- о Амьдралын хүсэл эрмэлзлэл
- о AV асуултууд
- о ESEL сургалтын хөтөлбөрийн түршлага, агуулгын уялдаа холбоо

Судалгааны хэрэглэгдэхүүнийг ESEL сургалтын хөтөлбөрийн үндсэн агуулга, зорилгод нийцүүлэн сайтар анхааран боловсруулсан ба сургалтад хамрагдсан хүүхэд, залуучуудын эзэмших ёстой мэдлэг, ур чадварыг тодорхойлоход чиглэсэн.

Anchoring Vignettes-ийн хэрэглээ

Хувь хүний ур чадварыг үнэлэх ихэнх судалгаанууд асуулга, өөрийн үнэлгээ зэрэг аргуудад тулгуурладаг. Гэвч эдгээр арга нь “хариултын гажуудал” бий болгох өндөр магадлалтай ба оролцогчид нийгмийн хүлээлтэд нийцсэн хариулт сонгох эсвэл туйлын хариулт сонгох хандлагатай байдгаас шалтгаалдаг. Ийм алдаа гажуудал нь судалгааны найдварт чанар, хүчин төгөлдөр байдлыг сулруулах эрсдэлтэй.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Кинг болон түүнтэй хамрагч судлаачдын 2004 онд танилцуулсан Anchoring Vignettes (AV) аргыг судалгааны баг ашиглав. AV нь судалгааны асуулгад ялгаатай, далд шинж чанартай, зохиомол дүрүүдийг дүрсэлсэн богино өгүүлэмж бүхий асуултууд оруулан оролцогчдоор тухайн дүрүүдийг өөрсдийгөө үнэлсэнтэй адил шкалын дагуу үнэлүүлдэг. Нэмж дурдахад AV аргыг судалгаанд оролцогчдын оролцоо болон асуулгын ойлголтын түвшинг үнэлэхэд ашиглаж болно.

1.5. Судалгааны хязгаарлалт

Хүүхдийг Ивээх Сангийн төслийн багтай хамтран судалгааны баг боломжит оролцогчдын жагсаалтыг суурь судалгааны мэдээлэлд тулгуурлан гаргасан. Дунд ангийн сурагчдын хувьд ихэнх нь өөрийн оршин суугаа сумандаа байсан. Гэвч зарим сурагчид аймгийн төв эсвэл Улаанбаатар хотын өөр сургууль руу шилжсэн тохиолдлууд байлаа. Мөн зарим ахлах ангийн сурагчид гадаад хэлний сургалтад хамрагдахын тулд сургуулиасаа чөлөө авч Улаанбаатар хот руу явсан байв.

Жагсаалтад байсан залуучуудтай холбоо тогтооход хүндрэлтэй байлаа. Ихэнх нь хөдөө мал маллаж байгаа эсвэл Улаанбаатар хотод болон уул уурхайн компанид ажиллахаар явсан байв. Судалгааны мэдээллийн санд байсан утасны дугаарууд нь өөрчлөгдсөн тул тэдэнтэй шууд холбогдох боломж хязгаарлагдмал байсан. Хөдөө мал маллаж буй залуусын хувьд утас нь сүлжээгүй байх тохиолдол их. Ссудалгааны удирдамжийн дагуу бид судалгаанд орлуулан хамруулах оролцогчид буюу нөөц оролцогчдын жагсаалыг ашигласан ч мөн ихэнх

нь өөр суманд амьдарч байсан эсвэл утас нь холбогдох боломжгүй байсан. Түүнчлэн зарим нь өөр аймаг руу ажил эрхлэх эсвэл өөр орон нутгийн хүнтэй гэрлэн тухайн газар нутаг руу нүүсэн байв.

Тиймээс талбарын судлаачид жагсаалтад багтсан оролцогчидтой холбогдон ганцаарчилсан уулзалт эсвэл утсаар ярилцлага хийн судалгаанд хамруулахыг хичээсэн. Үүний үр дүнд бид анхны зорилтот 2,012 оролцогчоос 1,979-ийг нь судалгаанд хамруулж чадсан. Зорилтот түүврийн 98%-ийг хамруулсан тул судалгааны баг болон өгөгдөл боловсруулах шинжээчид түүврийн төлөөлөл, цуглуулсан мэдээлэл нь цаашдын судалгаа, шинжилгээнд хангалттай гэж дүгнэв.

1.6. Түүврийн статистик болон түүвэрлэлт

Дараах хоёр бүлгийг тоон судалгаанд хамруулсан: (i) суурь судалгаанд хамрагдсан (ESEL 1³ болон 3⁴ дахь сургалтад хамрагдсан) болон (ii) ESEL 4 дэхь сургалтад⁵ хамрагдсан нийт 2,000 хүүхэд, залуус, тэдний ангийн багш нар.

Судалгааны тасалдалтыг бууруулах, үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор судалгааны баг 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс 3 дугаар сарын 1-ний хооронд хүүхэд, залуучууд, тэдний багш нартай холбоо тогтоож утасны дугаарыг нь баталгаажуулах, судалгааны үеэр оролцогчид байх эсэхийг тодруулах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 оны 3 дугаар сар гэхэд утсаар холбогдсоны үр дүнд судалгаанд хамрагдах нийт оролцогчдын 62%-тай холбогдож тэдний байршил болон судалгаанд оролцох боломжийг тодруулсан. Энэ нь судалгааг үр дүнтэй, алдагдлыг хамгийн бага түвшинд барих боломжийг бий болгосон.

Судалгааны түүврийн стратегийг ХИС-гийн төслийн баг болон ДБ-ны мэргэжилтнүүд боловсруулсан. Энэхүү түүврийн стратегийг хэрэгжүүлэх ажлыг гэрээт судалгааны компани болох МЭК ХХК-д даалгаж, төслийн оролцогч талуудын тодорхойлсон түүврийн хүрээг чанд мөрдөж ажилласан (Дэлгэрэнгүй түүврийн бүтэцтэй танилцахыг хүсвэл Хүснэгт 1-ийг харна уу).

Судалгааны баг түүврийн үлдсэн 38%-тай утасны дугаар ашиглалтад байхгүй, сүлжээгүй байсан, дугаар нь өөр хүнд шилжсэн гэх шалтгаанаар холбогдох оролдлого хийсэн ч амжилтгүй болсон. Энэ нь ХИС болон МЭК ХХК-ийн боловсруулсан ажлын даалгаварт тодорхойлсон 95%-ийн хариултын түвшинд хүрэхгүй байх эрсдэлтэй байсан гэсэн үг юм.

³ 400 судалгаанд оролцогч

⁴ 1,000 судалгаанд оролцогч

⁵ 600 судалгаанд оролцогч

Хүснэгт 1. Судалгааны түүвэр, сумаар

Бүх бүлгүүд сумаар																
#	Аймаг	Сум	Бүлэг 4			Бүлэг 1			Бүлэг 3			Нийт дүн				
			Үндсэн	Нөөц	Нийт	Үндсэн	Нөөц	Нийт	Үндсэн	Нөөц	Нийт	Үндсэн	Нөөц	Нийт		
1	Говь-сүмбэр	1	1	Сүмбэр	60	13	73	27	6	33	40	0	40	127	19	146
		2	2	Шивээговь	20	4	24	23	7	30	40	0	40	83	11	94
				Нийт	80	17	97	50	13	63	80	0	80	210	30	240
2	Ховд	3	1	Алтай	14	3	17	12	6	18	40	0	40	66	9	75
		4	2	Булган	44	10	54	13	2	15	38	0	38	95	12	107
		5	3	Жаргалант ⁶	12	3	15	0	0	0	0	0	0	12	3	15
		6	4	Зэрэг	14	4	18	19	6	25	36	0	36	69	10	79
		7	5	Манхан	14	3	17	6	1	7	40	0	40	60	4	64
		8	6	Мөст	14	4	18	17	3	20	40	0	40	71	7	78
		9	7	Үенч	14	3	17	18	9	27	40	0	40	72	12	84
				Нийт	126	30	156	85	27	112	234	0	234	445	57	502
					12	3	15	0	0	0	0	0	0	12	3	15
3	Сүхбаатар	11	2	Баяндэлгэр	20	4	24	5	1	6	37	0	37	62	5	67
		12	3	Мөнххаан	35	7	42	15	3	18	40	0	40	90	10	100
		13	4	Онгон	21	4	25	7	2	9	40	0	40	68	6	74
		14	5	Эрдэнэцагаан	20	4	24	16	4	20	40	0	40	76	8	84
				Нийт	108	22	130	43	10	53	157	0	157	308	32	340
4	Өвөрхангай	15	1	Арвайхээр ⁸	14	2	16	0	0	0	0	0	0	14	2	16
		16	2	Гучих-Ус	0	0	0	15	4	19	28	0	28	43	4	47
		17	3	Бат-Өлзий	29	8	37	19	8	27	40	0	40	88	16	104
		18	4	Богд	25	6	31	15	4	19	40	0	40	80	10	90
		19	5	Сант	7	2	9	16	1	17	39	0	39	62	3	65
		20	6	Уянга	35	10	45	23	4	27	40	0	40	98	14	112
		21	7	Хархорин	38	10	48	27	7	34	80	0	80	145	17	162
		22	8	Хужирт	14	4	18	19	4	23	40	0	40	73	8	81
		Нийт	162	42	204	134	32	166	307	0	307	603	74	677		
5	Завхан	23	1	Баянтэс	14	3	17	22	4	26	40	0	40	76	7	83
		24	2	Их-Уул	20	5	25	14	3	17	40	0	40	74	8	82
		25	3	Тосонцэнгэл	45	10	55	24	3	27	40	0	40	109	13	122
		26	4	Тэлмэн	15	4	19	14	6	20	40	0	40	69	10	79
		27	5	Тэс	14	3	17	10	6	16	40	0	40	64	9	73
		28	6	Түдэвтэй	8	2	10	4	3	7	30	0	30	42	5	47
		29	7	Улиастай ⁹	12	3	15	0	0	0	0	0	0	12	3	15
				Нийт	128	30	158	88	25	113	230	0	230	446	55	501
НИЙТ				604	141	745	400	107	507	1008	0	1008	2012	248	2260	

Оролцогчдын дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт В-ээс /Оролцогчдын жагсаалт болон оролцоогүй хүмүүсийн тайлбар/ харна уу.

Гэсэн хэдий ч биечлэн уулзах болон хариу дуудлага хийх зэрэг багийн шаргуу хүчин чармайлтын үр дүнд талбарын судлаачид нийт зорилтот түүвэр болох 2,012 хүүхэд, залуусаас 1,979-ийг буюу 98%-ийг нь хамруулж чадсан.

Эцсийн судалгааны дүгнэлтэд түүврийн тархалтыг дараах байдлаар нэгтгэн харуулав:

Хүснэгт 2. Түүврийн хэрэгжилтийн тойм

Түүврийн гол үзүүлэлт	Оролцогчдын тоо	Хувь
Нөөц жагсаалтаас санал асуулгад хамрагдсан	90	
Судалгаанд оролцогчид	1979	98%
Судалгааны анхны зорилтот түүвэр	2012	100%
Зорилтот түүврээс хасагдсан	33	2%

Судалгаанд хамрагдах анги удирдсан багш нарын түүврийн хэмжээг хүүхэд, залуучуудын түүвэр эцэслэгдсэний дараа тодорхойлсон. Анги удирдсан багш нарын түүврийн хэмжээг тухайн сумын хүүхдийн тоо болон тэдний одоо суралцаж буй эсвэл өмнө нь суралцаж байсан ангийн багш нарын тоог харгалзан тогтоосон. Энэ нь судалгаанд хамрагдаж буй сурагчид, залуучуудтай холбоотой ангийн багш нарын төлөөллийг үнэн зөв илэрхийлэхэд түсэлсэн.

Чанарын судалгааны түүвэрлэлт

Чанарын судалгааны хувьд судалгаа хийгдэж буй сум бүрт 2 **Фокус бүлгийн ярилцлага** (ФБЯ) зохион байгуулсан. Үүнд:

- 29 зорилтот сумын зөвхөн ESEL сургалтад хамрагдсан түүнчлэн ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдаад бичил тэтгэлгийн санхүүжилт авсан **хүүхэд, залуучууд**. ФБЯ-д оролцох хүүхэд, залуучуудыг тоон судалгааны оролцогчидтой ижил бүлгүүдээс (ESEL 1, ESEL 3, ESEL 4 сургалтад хамрагдсан) сонгосон.
- ESEL сургалтыг чиглүүлсэн явуулсан багш/зөвлөхүүд.

Сум бүрт хүүхэд, залуучуудыг хамруулсан 1, багш/зөвлөхүүдийг хамруулсан 1, нийт 2 ФБЯ-ыг зохион байгуулахаар төлөвлөсөн ба ингэснээр чанарын судалгааны өгөгдөл нь төлөөллийн шинж чанартай болохыг баталгаажуулж төсөлд оролцсон сурагчид болон багш нарын үзэл бодол, санааг тус бүрээс нь авах боломжийг олгосон.

⁶ Аймгийн төв

⁷ Аймгийн төв

⁸ Аймгийн төв

⁹ Аймгийн төв

1.7. Судалгааны газар зүйн хамрах хүрээ

Эцсийн үр дүнгийн үнэлгээний чанарын болон тоон судалгаа нь төслийн зорилтот 5 аймгийн 29 суманд хийгдсэн. Уг хамрах хүрээ нь төслийн үр нөлөөг хөдөө орон нутаг, хот суурин газрын янз бүрийн хэсэгт үнэлэх боломжийг олгосон. Газар зүйн хамрах хүрээний задаргааг доор оруулав:

- **Сүхбаатар аймаг:** Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан болон Баруун-Урт сум
- **Говьсүмбэр аймаг:** Сүмбэр, Шивээговь сум
- **Өвөрхангай аймаг:** Бат-Өлзий, Богд, Гучин-Ус, Хархорин, Хужирт, Сант, Уянга, Арвайхээр сум
- **Ховд аймаг:** Алтай, Булган, Манхан, Мөст, Үенч, Зэрэг, Жаргалант сум
- **Завхан аймаг:** Баянтэс, Их-Уул, Тэлмэн, Тэс, Түдэвтэй, Тосонцэнгэл, Улиастай сум

Уг үнэлгээ нь төслийн зорилтот үр шим хүртэгсдэд үзүүлэх үр нөлөөг үнэлж, ESEL сургалтын хөтөлбөртэй холбоотой хүүхэд, залуучуудын энтрепренершипийн мэдлэг болон хувь хүний үр чадвар, сэтгэлгээнд гарсан ахицыг үнэлэх зорилготой байв.

Зураг 1. Судалгааны газарзүйн хамрах хүрээ



1.8. Мэдээлэл цуглуулах явцад тулгарсан саад бэрхшээл

Эцсийн судалгааг хэрэгжүүлэх аргыг туршилт судалгаанаас авсан сургамжид үндэслэн боловсруулав. Тоон судалгааны хувьд сургуулиудын анги танхимын багтаамж хязгаарлагдмал учир судалгааны багийн зүгээс тусгай анги танхимаар хангах боломжгүй байсан. Зарим тохиолдолд судалгааг сургуулийн нийгмийн ажилтан болон сургалтын менежерийн өрөөг ашиглан явуулсан нь хүүхдээс судалгаа авахад хүндрэлтэй нөхцлийг бий болгож байв. Учир нь нийгмийн ажилтан, сургалтын менежертэй уулзах хүсэлтэй багш, эцэг эхчүүд ойр ойрхон хаалга онгойлгож судалгаанд оролцогсдын анхаарлыг сарниулж байсан. Гэхдээ энэ нь харьцангуй бага нөлөөтэй байсан ба судлаач асуултыг давтан хэлэх эсвэл тухайн хэсгийг дахин тайлбарлах шаардлагатай болсноор судалгааны хугацаа уртсахад хүргэсэн.

Дунд боловсрол эзэмшсэн ч мэргэжлийн сургууль болон их дээд сургуульд суралцаагүй 14-25 насны залуучуудыг олоход хүндрэлтэй байв. Учир нь залуусын ихэнх нь хөдөө орон нутаг эсвэл Улаанбаатар хот руу ажил эрхлэхээр шилжин суурьшдаг. Мөн багш нарын өгсөн утасны дугаар нь дийлэнхдээ ашиглалтад байхгүй эсвэл буруу байсан. Гэсэн хэдий ч эдгээр сорилтуудыг үл харгалзан түүвэрлэлтийн стратеги, нөөц жагсаалтын 248 оролцогчид бидэнд зорилтот түүврийн 98%-д хүрэх боломжийг олгосон.

Фокус бүлгийн ярилцлагын хувьд сурагчид болон багш нарт тавьсан асуултууд нь ихэвчлэн хэт төвөгтэй эсвэл тодорхойгүй байсан нь оролцогчдыг ядрааж, урамгүй болоход нь нөлөөлж байсан. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд асуултуудыг өөрчилсөн боловч оролцогчдод энэ нь хүндрэлтэй хэвээр байв.

Санал асуулгын бүх хуудсыг Улаанбаатар хотод хэвлэж, төслийн салбар оффисуудаар дамжуулан тараасан нь ложистикийн саатлыг бууруулахад тусалсан.

1.9. Судалгааны ёс зүй

МЭК-д бид хүүхдийн эрх, хүйсийн тэгш эрх, цөөнхийн бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон үндэс угсаа, шашны янз бүрийн гарал үүслийг хүндэтгэсэн ёс зүйтэй мэдээлэл цуглуулах үүрэгтэй байдаг. Бидний арга барил хэд хэдэн үндсэн процесст суурилдаг.

Бид мэдээлэлд суурилсан зөвшөөрлийн үйл явцаас эхэлдэг буюу оролцогч бүр, хүүхдүүд ч мөн адил судалгааны зорилго болон өөрсдийн эрхийг мэдэж байгаа эсэхийг баталгаажуулдаг. Зөвшөөрлийн материалууд нь энгийн, ойлгомжтой хэлийг ашиглан боловсруулагдсан

бөгөөд шаардлагатай бол нутгийн аялгыг тусгаж өгдөг. Хүүхдүүдийн хувьд бид эцэг эх эсвэл асран хамгаалагчдын зөвшөөрлийг авч, насны онцлогт тохирсон, сонирхол татахуйц тайлбаруудыг ашигладаг.

Хүүхдийн эрхийг хамгаалахын тулд манай судалгаанууд нь хүүхдүүдийн хэрэгцээнд тохирсон, сонирхол татахуйц байдлаар боловсруулагдсан байдаг ба энэ нь хүүхдүүдэд нийцэх интерактив хэсгүүдийг ашиглах, судалгааны үйл явцыг тааламжтай, утга учиртай болгоход чиглэдэг.

Хүйсийн тэгш байдлыг хангахын тулд бид бүх хүйсийн баримжааг илэрхийлсэн үг хэллэгийг ашиглан, өрөөсгөл ойлголтоос зайлсхийн судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулдаг. Төрөл бүрийн үзэл бодлоо илэрхийлэх таатай орчныг бүрдүүлэхийн тулд бид тусад нь фокус бүлгийн ярилцлагыг зохион байгуулдаг.

Цөөнхийн бүлгүүдийн хувьд бид судалгааны дизайны үе шатанд соёлын мэдрэмжтэй, нийцтэй байдлыг хангах зорилгоор орон нутгийн удирдлагуудтай хамтран ажилладаг ба асуултуудаа хэвшмэл ойлголтоос зайлсхийсэн, нийтийг хамарсан уур амьсгал бий болгох үүднээс сайтар анхааран боловсруулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байх нь чухал тул бид төрөл бүрийн хэрэгцээг хангахын тулд тохируулга хийдэг. Үүнд том шрифт эсвэл аудио формат зэргийг санал болгох, түүнчлэн судалгааны орчинг биетээр ашиглахад хүртээмжтэй, тохиромжтой байхаар зохион байгуулдаг.

Бид үндэс угсаа болон шашны мэдрэмжтэй байдлыг эрхэмлэж судлаачдаа соёлын мэдлэг олгох сургалтад хамруулдаг. Энэхүү сургалт нь тэднийг судалгааны явцад төвийг сахисан үг хэллэг ашиглан, эмзэг сэдвүүдэд хүндэтгэлтэй хандахыг ойлгуулдаг.

Манай мэдээлэл цуглуулах хэрэгслүүд олон төрлийн байр суурийг судлахын тулд олон сонголтот, нээлттэй сонголт зэргийг багтаасан янз бүрийн асуултын форматыг агуулдаг. Туршилт судалгаа нь судалгааг бүрэн эхлүүлэхээс өмнө үүсч болох алдааг тодорхойлж, шийдвэрлэх боломжийг олгодог.

Эцэст нь бид тасралтгүй сайжруулалт хийхийн тулд судалгаанд оролцогчдод санал асуулгын явцын талаар өөрийн санал бодлоо хуваалцах механизмыг бий болгон ашигладаг. Ёс зүйн хяналтын зөвлөл нь манай үйл ажиллагааг хянаж, ёс зүйн стандартуудыг баримтлах үүднээс тогтмол аудит хийдэг.

Эдгээр цогц үйл явцаар дамжуулан МЭК ХХК нь мэдээлэл, өгөгдөл цуглуулахдаа бүх оролцогчдын эрхэм чанар, эрхийг хүндэтгэж, хүртээмжтэй, ёс зүйтэй судалгааны орчинг бий болгохыг эрмэлздэг.



Бүлэг 2.

ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. ESEL Мэдлэг

Судалгаанд оролцогч хүүхэд, залуусын 8.8% нь өмнө нь бизнесийн холбогдолтой хичээлийг өмнө нь судалж байсан гэж хариулсан (Хүснэгт 3). 2 бүлгийн хувьд ялгаа бараг байгаагүй буюу үндсэн бүлгийн 9%, хяналтын бүлгийн 8% нь бизнесийн чиглэлийн хичээлд өмнө нь хамрагдаж байжээ.

Хүснэгт 3. Хүүхэд өмнө нь бизнесийн холбогдолтой хичээл судалж байсан эсэх (Суурь, Эцсийн)

Бизнесийн хичээл	Хяналт				Үндсэн			
	Суурь		Эцсийн		Суурь		Эцсийн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тийм	41	12%	29	8%	69	11%	48	9%
Үгүй	291	88%	312	92%	570	89%	489	91%
Нийт	332	100%	341	100%	639	100%	537	100%

Судалгааны асуулгад ESEL-ийн мэдлэгийг үнэлэх 16 асуулт багтсан ба үүнд энтрепренершипийн тухай суурь ойлголт (7 асуулт), бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэг (5 асуулт), нөөцийг үр ашигтай хуваарилах, дижитал хэрэгсэл (4 асуулт) тус тус багтсан болно. Зөв хариулт бүр 1 оноо бөгөөд хамгийн дээд тал нь 26 оноо авах боломжтой. Хүснэгт 4-т оролцогчдын нийт оноог харуулсан байна. Дунджаар оролцогчид 6 асуултад зөв хариулсан ба дийлэнх нь 5-9 оноо авчээ. Үндсэн бүлгийн дундаж оноо хяналтын бүлгийн дундаж онооноос бага зэрэг өндөр байсан ч ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

Хүснэгт 4. ESEL мэдлэг бүлгийн статусаар

Үндсэн болон хяналтын бүлгийн харьцуулалт	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Тодорхой нэг газрыг удирддаг хүнийг хэлнэ.	13	4%	22	4%	35	4%
Ур чадварт суралцахын тулд хэн нэгэн хүний удирдлага доор ажилладаг хүнийг хэлнэ.	84	24%	130	24%	214	24%
Нэг ба түүнээс дээш тооны бизнесийг зохион байгуулж, үйл ажиллагаа явуулдаг хүнийг хэлнэ.	137	40%	232	43%	369	42%
Хариулт Б болон В	77	23%	133	25%	210	24%
Дээрхийн аль нь ч биш	3	1%	12	2%	15	2%
Мэдэхгүй	27	8%	8	2%	35	4%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Сурагчдын дийлэнх (42%) нь “Энтрепренер гэж хэн бэ?” гэх асуултад “Нэг ба түүнээс дээш тооны бизнесийг зохион байгуулж, үйл ажиллагаа явуулдаг хүнийг хэлнэ” гэж зөв тодорхойлсон байна. Хяналтын ба үндсэн бүлгүүдийн хариулт бага зэргийн ялгаатай байсан. Сурагчдын сонгосон өөр нэг түгээмэл тодорхойлолт нь “Ур чадварт суралцахын тулд хэн нэгэн хүний удирдлага доор ажилладаг хүнийг хэлнэ” (24%) байсан бол үүнтэй ижил хувь нь Б болон В гэж хариулсан байна. Эдгээр үр дүн нь бүлгүүдийн хооронд ялгаа бага байгааг харуулж байна.

ESEL-ийн мэдлэгийн үнэлгээний үр дүнг Хүснэгт 5-д нэгтгэн харууллаа.

Хүснэгт 5. ESEL мэдлэгийг эзэмших амжилтын түвшин

№	Асуулт	Хяналт	Үндсэн	Нийт
1. Энтрепренершипийн тухай суурь ойлголт				
1.1	Аль нь нутгийнхаа иргэдэд үнэ цэнийг бүтээж буй үйл ажиллагаа вэ?	38%	43%	41%
1.2	Аль нь амжилттай энтрепренерийн шинж чанар вэ?	34%	37%	36%
1.3	Аль нь энтрепренер хүний үүрэг вэ?	28%	32%	30%
1.4	Энэ зураг дээр ямар төрлийн бизнесийг харуулж байна вэ?	88%	94%	92%
1.5	Аль нь таны бизнест эрсдэл болох вэ?	45%	48%	47%
1.6	Хэрэв та рестораны эзэн бол таны өрсөлдөгч хэн бэ?	78%	81%	80%
2. Бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэг				
2.1	Бизнес төлөвлөгөө гэж юу вэ?	44%	39%	41%
2.2	Танд яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ?	32%	30%	31%
2.3	Засгийн газарт орлогоос төлдөг мөнгө аль нь вэ?	55%	58%	57%
2.4	Бизнесийн үйл ажиллагаандаа санхүүгийн бүртгэлээ үнэн зөв бүртгэхийн давуу талууд юу вэ?	61%	64%	63%
3. Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон дижитал хэрэгсэл				
3.1	Доорх нөөцөөс танд аль нь цайны газар ажиллуулахад хэрэг болох вэ?	36%	41%	39%
3.2	Аль нь олон нийтийн хангагдаагүй хэрэгцээг судлах үр дүнтэй арга вэ?	21%	27%	25%
3.3	Зардлын тооцооллыг хийхэд хамгийн тохиромжтой програм аль нь вэ?	26%	29%	27%
3.4	Фэйсбүүк, Инстаграм, Тик Ток зэрэг олон нийтийн сүлжээг та бизнестээ ашиглах нь ямар давуу талуудтай вэ?	82%	86%	84%

Үр дүнд шинжилгээ хийхэд нийт 16 асуултаас 9 асуултад судалгаанд оролцогчдын 50-иас дээш хувь нь зөв хариулсан бол 5 асуултын зөв хариулт 50 хувиас бага байна. “Танд яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ?” гэх асуултын зөв хариултын хувь 22.9 буюу хамгийн бага байсан. Харин “Зураг дээр ямар төрлийн бизнесийг харуулж байна вэ?” гэдэг асуултад хамгийн олон буюу нийт сурагчдын 90.8% нь зөв хариулсан байна.

Хяналтын ба үндсэн бүлгүүдийн ялгааг суурь үнэлгээтэй харьцуулан харахад үндсэн бүлэг дунджаар 2.47%-иар илүү сайжирсан байсан нь зорилтот бүлгийн эерэг үр дүнг харуулж байна.

Энэхүү хэсэгт бид үндсэн болон хяналтын бүлгийн эцсийн судалгааны ESEL мэдлэгийн гол үр дүнг тоймлон авч үзсэн.

2.2. ESEL Үр чадвар

Судалгаанд хүүхэд, залууст энтрепренершип болон хувь хүний үр чадвартай холбоотой бодомжийг өгсөн ба “огт үгүй эсвэл ховорхон”, “бага зэрэг эсвэл заримдаа”, “нилээд их эсвэл олон удаа” болон “маш их эсвэл бараг л үргэлж” гэсэн 4 хариултаас сонгоно. Мэдээллийг боловсруулахын тулд эдгээр хариултуудыг дараах байдлаар кодлосон: “Маш их эсвэл бараг л үргэлж” = 1, “Нилээд их эсвэл олон удаа” = 2, “Бага зэрэг эсвэл заримдаа” = 3, “Огт үгүй эсвэл ховорхон” = 4. **Тиймээс бага оноо нь сайн үр дүнг илтгэнэ.**

Санал асуулгаар өөрийгөө танин мэдэх, нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар, бүтээлч байдал ба инноваци, харилцааны үр чадвар, багаар ажиллах үр чадвар, тунгаан бодох үр чадвар, өсөн дэвших болон энтрепренерийн сэтгэлгээ зэрэг ESEL-тэй холбоотой 6 үр чадвар, 2 сэтгэлгээг үнэлсэн. Эдгээр үр чадварын хэмжүүрүүдээс хамгийн бага үзүүлэлттэй байсан бүтээлч байдал ба инновацийн үр чадварыг статистикийн хувьд ач холбогдолгүй гэж үзсэн тул дүн шинжилгээг энэхүү тайланд оруулаагүй болно.

Өөрийгөө танин мэдэх

Өөрийгөө танин мэдэх чадварыг дараах бодомжуудаар үнэлэв:

1. Гунигтай үедээ би өөрийн сэтгэл санаагаа хэрхэн сэргээхээ мэддэг.
2. Би өөрийгөө хэрхэн тайвшруулах аргаа мэддэг.
3. Би ярихаасаа өмнө юу гэж хэлэхээ сайтар боддог.
4. Би хүмүүсээс сөрөг сэтгэгдэл хүлээж авсан ч хичээсээр байдаг.
5. Би аливаа зүйлийг цагийг нь тулгалгүйгээр тэр дор нь хийдэг.

Эдгээр таван асуултын хувьд сурагчдын дийлэх нь “Нилээд их эсвэл олон удаа” гэх хариултыг сонгосон ба үүний дараа “Бага зэрэг эсвэл заримдаа” гэсэн хариултыг сонгосон бол “Огт үгүй эсвэл ховорхон”

гэсэн хариултыг хамгийн бага сонгосон байна. Хяналтын болон үндсэн бүлгийн хооронд бага зэргийн ялгаа ажиглагдсан. Дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 6-д харуулав.

Хүснэгт 6. Өөрийгөө танин мэдэх үр чадвар

Өөрийгөө танин мэдэх үр чадварын үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гунигтай үедээ би өөрийн сэтгэл санаагаа хэрхэн сэргээхээ мэддэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	86	25%	142	26%	228	26%
	Нилээд их эсвэл олон удаа	135	40%	222	41%	357	41%
	Бага зэрэг эсвэл заримдаа	109	32%	158	30%	267	30%
	Огт үгүй эсвэл ховорхон	11	3%	15	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би өөрийгөө хэрхэн тайвшруулах аргаа мэддэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	109	32%	184	34%	293	33%
	Нилээд их эсвэл олон удаа	136	40%	207	39%	343	39%
	Бага зэрэг эсвэл заримдаа	90	26%	136	25%	226	26%
	Огт үгүй эсвэл ховорхон	6	2%	10	2%	16	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би ярихаасаа өмнө юу гэж хэлэхээ сайтар боддог.	Маш их эсвэл бараг л үргэлж	82	24%	144	27%	226	26%
	Нилээд их эсвэл олон удаа	142	42%	205	38%	347	39%
	Бага зэрэг эсвэл заримдаа	102	30%	176	33%	278	32%
	Огт үгүй эсвэл ховорхон	15	4%	12	2%	27	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би хүмүүсээс сөрөг сэтгэгдэл хүлээж авсан ч хичээсээр байдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	91	27%	139	26%	230	26%
	Нилээд их эсвэл олон удаа	148	43%	213	40%	361	41%
	Бага зэрэг эсвэл заримдаа	92	27%	169	31%	261	30%
	Огт үгүй эсвэл ховорхон	10	3%	16	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би аливаа зүйлийг цагийг нь тулгалгүйгээр тэр дор нь хийдэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	55	16%	83	16%	138	16%
	Нилээд их эсвэл олон удаа	128	37%	209	39%	337	38%
	Бага зэрэг эсвэл заримдаа	152	45%	228	42%	380	43%
	Огт үгүй эсвэл ховорхон	6	2%	17	3%	23	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 7. Нийгэм, соёлыг танин мэдэх ур чадвар

Нийгэм, соёлыг танин мэдэх ур чадварын үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би надаас өөр үзэл бодолтой хүмүүсээс суралцдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	50	15%	74	14%	124	14%
	Нилээд их эсвэл олон удаа	170	50%	225	42%	395	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	118	34%	223	41%	341	39%
	Огт үгүй эсвэл ховорхон	3	1%	15	3%	18	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би хэн нэгний сэтгэл нь шархалсан байвал тэдний юу мэдэрч байгааг ойлгодог.	Маш их эсвэл бараг л үргэлж	63	18%	98	19%	161	18%
	Нилээд их эсвэл олон удаа	149	44%	244	45%	393	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	120	35%	178	33%	298	34%
	Огт үгүй эсвэл ховорхон	9	3%	17	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би бусдын амжилтыг магтдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	127	37%	216	40%	343	39%
	Нилээд их эсвэл олон удаа	169	50%	250	47%	419	48%
	Бага зэрэг эсвэл заримдаа	42	12%	69	13%	111	13%
	Огт үгүй эсвэл ховорхон	3	1%	2	0.4%	5	0.6%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би хэн нэгэн надтай санал нийлэхгүй байсан ч тэдний үзэл бодлыг хүндэтгэдэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	80	23%	127	24%	207	23%
	Нилээд их эсвэл олон удаа	138	40%	198	37%	335	38%
	Бага зэрэг эсвэл заримдаа	113	33%	197	37%	310	35%
	Огт үгүй эсвэл ховорхон	11	3%	15	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би бусдыг эвгүй байдалд оруулахгүйгээр өөрийнхөө төлөө зогсож чаддаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	78	23%	127	24%	205	23%
	Нилээд их эсвэл олон удаа	170	50%	262	49%	432	49%
	Бага зэрэг эсвэл заримдаа	92	27%	141	26%	233	27%
	Огт үгүй эсвэл ховорхон	1	0.3%	7	1%	8	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Нийгэм, соёлыг танин мэдэх ур чадвар

Нийгэм, соёлыг танин мэдэх ур чадварыг дараах бодомжуудаар үнэлэв:

1. Би надаас өөр үзэл бодолтой хүмүүсээс суралцдаг.
2. Би хэн нэгний сэтгэл нь шархалсан байвал тэдний юу мэдэрч байгааг ойлгодог.
3. Би бусдын амжилтыг магтдаг.
4. Би хэн нэгэн надтай санал нийлэхгүй байсан ч тэдний үзэл бодлыг хүндэтгэдэг.
5. Би бусдыг эвгүй байдалд оруулахгүйгээр өөрийнхөө төлөө зогсож чаддаг.

Эдгээр асуултын хувьд тогтвортой үзүүлэлт харагдсан: Судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Нилээд их эсвэл олон удаа” гэсэн хариултыг сонгосон. Сонирхолтой нь эхний асуултын хувьд Хяналтын бүлэг нь Үндсэн бүлэгтэй харьцуулахад “Нилээд их эсвэл олон удаа” гэх хариултыг 5 хувиар илүү сонгосон байна. Бусад асуултууд мөн үүнтэй адил үр дүнтэй байв. Дэлгэрэнгүй үр дүнг дээрх Хүснэгт 7-д харуулав.

Харилцааны ур чадвар

Дараах бодомжуудаар харилцааны ур чадварыг үнэлэв:

1. Би надаас өөр үзэл бодолтой хүмүүсийг анхааралтай сонсдог.
2. Би найздаа уурласан үедээ тэдэнд ямар мэдрэмж төрж байгаагаа хэлж чаддаг.
3. Би хүмүүсийг ятгах чадвар сайтай.
4. Би бусад хүнтэй цэгцтэй, үр дүнтэйгээр харилцах чадвартай.
5. Би хүмүүстэй маргалдахаас зайлсхийхдээ сайн.

Эдгээр 5 асуултын гурав нь харьцангуй тогтвортой үзүүлэлттэй байсан. Оролцогчид 2, 3 болон 5 дугаар асуултуудад ихэвчлэн “Огт үгүй эсвэл ховор” гэж хариулсан бол 1 болон 4 дүгээр асуултын хувьд “Нилээд их эсвэл олон удаа” гэсэн хариултыг дийлэнх нь сонгосон байна. Ерөнхийдөө бүлгүүдийн хоорондын ялгаа энэ хэсэгт хамгийн бага байсан. Дэлгэрэнгүй үр дүнг дараах Хүснэгт 8-д харуулав.

Хүснэгт 8. Харилцааны ур чадвар

Харилцааны ур чадварын үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би надаас өөр үзэл бодолтой хүмүүсийг анхааралтай сонсдог.	Маш их эсвэл бараг л үргэлж	132	38%	222	41%	354	40%
	Нилээд их эсвэл олон удаа	163	48%	250	47%	413	47%
	Бага зэрэг эсвэл заримдаа	44	13%	63	12%	107	12%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	1%	2	0.4%	4	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би найздаа уурласан үедээ тэдэнд ямар мэдрэмж төрж байгаагаа хэлж чаддаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	78	23%	113	21%	191	22%
	Нилээд их эсвэл олон удаа	111	33%	190	35%	301	34%
	Бага зэрэг эсвэл заримдаа	114	33%	191	36%	305	35%
	Огт үгүй эсвэл ховорхон	38	11%	43	8%	81	9%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би хүмүүсийг ятгах чадвар сайтай.	Маш их эсвэл бараг л үргэлж	71	21%	118	22%	189	22%
	Нилээд их эсвэл олон удаа	128	37%	177	33%	305	35%
	Бага зэрэг эсвэл заримдаа	118	35%	211	39%	329	37%
	Огт үгүй эсвэл ховорхон	24	7%	31	6%	55	6%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би бусад хүнтэй цэгцтэй, үр дүнтэйгээр харилцах чадвартай.	Маш их эсвэл бараг л үргэлж	58	17%	97	18%	155	17%
	Нилээд их эсвэл олон удаа	184	54%	280	52%	464	53%
	Бага зэрэг эсвэл заримдаа	97	28%	157	29%	254	29%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	1%	3	1%	5	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би хүмүүстэй маргалдахаас зайлсхийхдээ сайн.	Маш их эсвэл бараг л үргэлж	110	32%	176	33%	286	33%
	Бага зэрэг эсвэл заримдаа	117	34%	191	35%	308	35%
	Бага зэрэг эсвэл заримдаа	99	29%	156	29%	255	29%
	Огт үгүй эсвэл ховорхон	15	5%	14	3%	29	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Багаар ажиллах ур чадвар

Дараах бодомжуудаар багаар ажиллах ур чадварыг үнэлэв:

1. Шаардлагатай тохиолдолд би тусламж, дэмжлэг өгч бас авч чадна.
2. Би шинэ санаа, санаачилга өрнөж байгаа ярианд оролцох дуртай.

3. Би ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд тухайн зорилгоо жижиг алхмуудад хуваадаг.
4. Би бусадтай ажиллаж байхдаа санал, хүсэлт өгөх болон хүлээн авах тал дээр нээлттэй байдаг.
5. Би бусадтай санал зөрөлдвөл түүнийгээ шийдвэрлэж чаддаг.

Судалгаанд оролцогчдын 45-аас дээш хувь нь 2 дугаар асуултаас бусад асуултад “Нилээд их эсвэл олон удаа” гэх хариултыг сонгосон ба бүлгүүдийн хооронд тодорхой ялгаа ажиглагдаагүй. Дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 9-д харуулав.

Хүснэгт 9. Багаар ажиллах үр чадвар

Багаар ажиллах үр чадварын үзүүлэлт		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Шаардлагатай тохиолдолд би тусламж, дэмжлэг өгч бас авч чадна.	Маш их эсвэл бараг л үргэлж	110	32%	200	37%	310	35%
	Нилээд их эсвэл олон удаа	181	53%	265	49%	446	51%
	Бага зэрэг эсвэл заримдаа	49	14%	72	13%	121	14%
	Огт үгүй эсвэл ховорхон	1	0.3%	0	0%	1	0.1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би шинэ санаа, санаачилга өрнөж байгаа ярианд оролцох дуртай.	Маш их эсвэл бараг л үргэлж	147	43%	226	42%	373	42%
	Нилээд их эсвэл олон удаа	129	38%	201	37%	330	38%
	Бага зэрэг эсвэл заримдаа	56	16%	93	18%	149	17%
	Огт үгүй эсвэл ховорхон	9	3%	17	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би ямар нэгэн зорилгод хүрэхийн тулд тухайн зорилгоо жижиг алхмуудад хуваадаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	93	27%	135	25%	228	26%
	Нилээд их эсвэл олон удаа	154	45%	242	45%	396	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	82	24%	145	27%	227	26%
	Огт үгүй эсвэл ховорхон	12	4%	15	3%	27	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би бусадтай ажиллаж байхдаа санал, хүсэлт өгөх болон хүлээн авах тал дээр нээлттэй байдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	90	26%	157	29%	247	28%
	Нилээд их эсвэл олон удаа	155	46%	241	45%	396	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	85	25%	129	24%	214	25%
	Огт үгүй эсвэл ховорхон	11	3%	10	2%	21	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би бусадтай санал зөрөлдвөл түүнийгээ шийдвэрлэж чаддаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	78	23%	124	23%	202	23%
	Нилээд их эсвэл олон удаа	154	45%	254	47%	408	46%
	Бага зэрэг эсвэл заримдаа	102	30%	148	28%	250	29%
	Огт үгүй эсвэл ховорхон	7	2%	11	2%	18	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Тунгаан бодох ур чадвар

Дараах бодомжуудаар тунгаан бодох ур чадварыг үнэлэв:

1. Би шийдвэр гаргахаасаа өмнө эхлээд юу болж болох талаар боддог.
2. Би асуудлыг шийдвэрлэх өөр өөр арга замыг эрэлхийлдэг.
3. Би дүрэм зөрчих гэж байгаа найздаа “Үгүй” гэж хэлдэг.
4. Би өөрийн болон бусдын үйлдэл, нөхцөл байдлыг тунгааж, дүн шинжилгээ хийдэг.
5. Би янз бүрийн олон эх үүсвэрээс мэдээлэл олж авч, сонголт хийж, авсан мэдээллээ боловсруулах чадвартай.

Оролцогчдын 47-оос дээш хувь нь “Нилээд их эсвэл олон удаа” гэх хариултыг 3 дугаар асуултаас бусад асуултад сонгож байсан бол 3 дугаар асуултын хариулт нь жигд байсан ба “Огт үгүй эсвэл ховор” гэх хариулт үл ялиг илүү байв. Бүлгүүдийн хооронд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаагүй. Дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 10-д харуулав.

Хүснэгт 10. Тунгаан бодох ур чадвар

Тунгаан бодох ур чадварын үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би шийдвэр гаргахаасаа өмнө эхлээд юу болж болох талаар боддог.	Маш их эсвэл бараг л үргэлж	115	34%	150	28%	265	30%
	Нилээд их эсвэл олон удаа	146	43%	266	49%	412	47%
	Бага зэрэг эсвэл заримдаа	72	21%	117	22%	189	22%
	Огт үгүй эсвэл ховорхон	8	2%	4	1%	12	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би асуудлыг шийдвэрлэх өөр өөр арга замыг эрэлхийлдэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	68	20%	127	24%	195	22%
	Нилээд их эсвэл олон удаа	187	55%	267	50%	454	52%
	Бага зэрэг эсвэл заримдаа	83	24%	135	25%	218	25%
	Огт үгүй эсвэл ховорхон	3	1%	8	1%	11	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би дүрэм зөрчих гэж байгаа найздаа “Үгүй” гэж хэлдэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	130	38%	196	36%	326	37%
	Нилээд их эсвэл олон удаа	147	43%	223	42%	370	42%
	Бага зэрэг эсвэл заримдаа	62	18%	107	20%	169	19%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	1%	11	2%	13	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би өөрийн болон бусдын үйлдэл, нөхцөл байдлыг тунгааж, дүн шинжилгээ хийдэг	Маш их эсвэл бараг л үргэлж	55	16%	106	20%	161	18%
	Нилээд их эсвэл олон удаа	168	49%	244	45%	412	47%
	Бага зэрэг эсвэл заримдаа	106	31%	173	32%	279	32%
	Огт үгүй эсвэл ховорхон	12	4%	14	3%	26	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би янз бүрийн олон эх үүсвэрээс мэдээлэл олж авч, сонголт хийж, авсан мэдээллээ боловсруулах чадвартай.	Маш их эсвэл бараг л үргэлж	78	23%	124	23%	202	23%
	Нилээд их эсвэл олон удаа	155	45%	241	45%	396	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	105	31%	159	30%	264	30%
	Огт үгүй эсвэл ховорхон	3	1%	13	2%	16	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

ESEL Сэтгэлгээ

Өсөн дэвших сэтгэлгээ

Доорх бодомжуудаар өсөн дэвших сэтгэлгээг үнэлэв:

1. Би саад бэрхшээл, анхаарал сарниулах зүйлтэй учирвал амархан бууж өгдөггүй.
2. Би эхэлсэн ажлаа дуусгадаг.
3. Миний хувьд алдаа нь сурах боломж байдаг.
4. Би амьдралыг тасралтгүй сурах үйл явц гэж үздэг.
5. Би зааж байгаа үр чадваруудыг маш сайн эзэмшиж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг.
6. Би ямар нэгэн шинэ зүйл сурч байхдаа зогсонги байдалд орсон тохиолдолд, шинэ арга замаар дахин оролдож үздэг.

Өмнөх үр дүнгүүдээс ялгаатай нь дээрх 6 асуултад оролцогчдын олонхи нь “Маш их эсвэл бараг л үргэлж” гэж хариулсан байна. Жишээ нь 45-аас дээш хувь нь 2,3, болон 4 дүгээр асуултуудад тус хариултыг сонгосон бол 1, 5, 6 дугаар асуултуудад ихэнх нь “Нилээд их эсвэл олон удаа” гэж хариулжээ. Дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 11-д харуулав.

Хүснэгт 11. Өсөн дэвших сэтгэлгээ

Өсөн дэвших сэтгэлгээний үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би саад бэрхшээл, анхаарал сарниулах зүйлтэй учирвал амархан бууж өгдөггүй.	Маш их эсвэл бараг л үргэлж	74	22%	133	25%	207	24%
	Нилээд их эсвэл олон удаа	178	52%	269	50%	447	51%
	Бага зэрэг эсвэл заримдаа	87	25%	130	24%	217	24%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	1%	5	1%	7	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би эхэлсэн ажлаа дуусгадаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	149	44%	232	43%	381	44%
	Нилээд их эсвэл олон удаа	160	47%	235	44%	395	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	30	9%	69	13%	99	11%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	0.5%	1	0.2%	3	0.3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Миний хувьд алдаа нь сурах боломж байдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	164	48%	243	45%	407	46%
	Нилээд их эсвэл олон удаа	146	43%	234	44%	380	43%
	Бага зэрэг эсвэл заримдаа	26	8%	59	11%	85	10%
	Огт үгүй эсвэл ховорхон	5	1%	1	0.2%	6	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би амьдралыг тасралтгүй сурах үйл явц гэж үздэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	186	55%	265	49%	451	51%
	Нилээд их эсвэл олон удаа	99	29%	187	35%	286	33%
	Бага зэрэг эсвэл заримдаа	52	15%	78	15%	130	15%
	Огт үгүй эсвэл ховорхон	4	1%	7	1%	11	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би зааж байгаа ур чадваруудыг маш сайн эзэмшиж чадна гэдэгтээ итгэлтэй байдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	130	38%	195	36%	325	37%
	Нилээд их эсвэл олон удаа	160	47%	234	44%	394	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	49	14%	104	19%	153	17%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	1%	4	1%	6	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би ямар нэгэн шинэ зүйл сурч байхдаа зогсонги байдалд орсон тохиолдолд, шинэ арга замаар дахин оролдож үздэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	67	19%	128	24%	195	22%
	Нилээд их эсвэл олон удаа	192	56%	264	49%	456	52%
	Бага зэрэг эсвэл заримдаа	77	23%	134	25%	211	24%
	Огт үгүй эсвэл ховорхон	5	2%	11	2%	16	2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Энтерпренерийн сэтгэлгээ

Дараах бодомжуудаар энтерпренерийн сэтгэлгээг үнэлэв:

- 1. Би шинэ зүйл сурах дуртай.
- 2. Би ямар нэгэн зүйлийг хийхдээ үргэлж “би хэрхэн үүнийг өөрөөр хийж болох вэ” гэж өөрөөсөө асуудаг.
- 3. Би аливаа зүйлийг хийхдээ өмнөхөөсөө илүү сайнаар хийхийг хичээдэг.
- 4. Би аливаа ажлыг эхлэхийн өмнө төлөвлөж, зорилго тавьдаг.
- 5. Би амьдралд амжилт гаргахын тулд заримдаа эрсдэлтэй шийдвэр гаргаж, эрсдэл хийх хэрэгтэй гэж үздэг.

Эдгээр таван асуултын хувьд оролцогчдын 77% нь 1-р асуултад “Маш их эсвэл бараг л үргэлж” гэж хариулсан нь тэд шинэ зүйл сурах туйлын хүсэлтэй байгааг илтгэж байна. Түүнчлэн 3-р асуултад оролцогчдын 57.4% нь мөн тухайн хариултыг сонгожээ. Бусад асуултын хариу нь харьцангуй тогтвортой байсан ч “огт үгүй эсвэл ховор” гэх хариултыг тодорхой хувь нь сонгожээ. Дэлгэрэнгүй үр дүнг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. Энтерпренерийн сэтгэлгээ

Энтерпренерийн сэтгэлгээний үзүүлэлтүүд		Хяналт		Үндсэн		Нийт	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Би шинэ зүйл сурах дуртай.	Маш их эсвэл бараг л үргэлж	261	77%	413	77%	674	77%
	Нилээд их эсвэл олон удаа	67	20%	111	21%	178	20%
	Бага зэрэг эсвэл заримдаа	11	3%	13	2%	24	3%
	Огт үгүй эсвэл ховорхон	2	0.4%	0	0%	2	0.2%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би ямар нэгэн зүйлийг хийхдээ үргэлж “би хэрхэн үүнийг өөрөөр хийж болох вэ” гэж өөрөөсөө асуудаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	89	26%	118	22%	207	24%
	Нилээд их эсвэл олон удаа	169	50%	292	54%	461	52%
	Бага зэрэг эсвэл заримдаа	76	22%	122	23%	198	23%
	Огт үгүй эсвэл ховорхон	7	2%	5	1%	12	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би аливаа зүйлийг хийхдээ өмнөхөөсөө илүү сайнаар хийхийг хичээдэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	199	58%	295	55%	494	56%
	Нилээд их эсвэл олон удаа	118	35%	203	38%	321	37%
	Бага зэрэг эсвэл заримдаа	21	6%	38	7%	59	7%
	Огт үгүй эсвэл ховорхон	3	1%	1	0.2%	4	0.5%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би аливаа ажлыг эхлэхийн өмнө төлөвлөж, зорилго тавьдаг.	Маш их эсвэл бараг л үргэлж	104	30%	161	30%	265	30%
	Нилээд их эсвэл олон удаа	153	45%	237	44%	390	45%
	Бага зэрэг эсвэл заримдаа	80	24%	131	24%	211	24%
	Огт үгүй эсвэл ховорхон	4	1%	8	1%	12	1%
	Нийт	341	100%	537	100%	878	100%
Би амьдралд амжилт гаргахын тулд заримдаа эрсдэлтэй шийдвэр гаргаж, эрсдэл хийх хэрэгтэй гэж үздэг.	Маш их эсвэл бараг л үргэлж	108	32%	171	32%	279	32%
	Нилээд их эсвэл олон удаа	138	41%	221	41%	359	41%
	Бага зэрэг эсвэл заримдаа	83	24%	128	24%	211	24%
	Огт үгүй эсвэл ховорхон	12	3%	17	3%	29	3%
	Нийт	341	100%	537	100%	878	100%

Бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн дундаж оноо 2 орчим буюу 2-оос арай өндөр эсвэл арай бага байсан нь ихэнх сурагчид “Нилээд их эсвэл олон удаа” гэх хариултыг сонгосон болохыг харуулж байна. Бүх бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд үндсэн бүлэг хяналтын бүлгээс арай өндөр оноо авсан ч, эдгээр ялгаа нь статистикийн хувьд ач холбогдолгүй байв. Энэ нь ESEL сургалтын хөтөлбөр нь зорилтот хүүхэд, залуусын үр чадварыг хөгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн болохыг илтгэж байна.

Өмнөх суурь судалгаанд оролцсон сурагчдын хувьд ESEL оноог сургалтын статус (сургалтад хамрагдсан эсэх) дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн. Судалгааны асуулга нь 8 хэсгээс бүрдсэн ба тус бүр 5 асуулттай, 4 хариултын хувилбартай. Хариултын хувилбар нь дараах үнэлгээний шкалтай: “Маш их эсвэл бараг л үргэлж” – 1 (хамгийн сайн), “Нилээд их эсвэл олон удаа” -2, “Бага зэрэг эсвэл заримдаа – 3”, “Огт үгүй эсвэл ховорхон” – 4 (хамгийн муу). **Иймээс ESEL онооны дундаж нь бага байх тусам тухайн бүлэг илүү сайн үр дүн үзүүлсэн гэдгийг илтгэнэ.**

Хүснэгт 13. Суурь судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Нийт		Үндсэн		Хяналт	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Өөрийгөө танин мэдэх	985	2.17	596	2.18	389	2.16
Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар	985	2.02	600	2.03	385	2.02
Бүтээлч байдал ба инноваци	990	2.18	604	2.19	386	2.18
Харилцааны үр чадвар	983	2.23	599	2.23	384	2.23
Багаар ажиллах үр чадвар	979	2.07	596	2.08	383	2.05
Тунгаан бодох үр чадвар	975	2.14	596	2.15	379	2.11
Өсөн дэвших сэтгэлгээ	964	1.91	588	1.92	376	1.9
Энтрепренерийн сэтгэлгээ	968	1.84	590	1.84	378	1.83

Эх сурвалж: Суурь судалгааны тайлан 2023 он.

Судалгааны кодчилолын дагуу оноо бага байх тусам сайн үр дүнг илтгэнэ. 8 хэсгийн үр дүнгээс үндсэн болон хяналтын бүлгүүдийн хооронд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. “Энтрепренерийн сэтгэлгээ” хэсэг 1.84 буюу хамгийн сайн үзүүлэлттэй байсан бол “Харилцааны үр чадвар” хэсэг 2.23 гэх хамгийн өндөр дундаж оноотой буюу харьцангуй тааруу үзүүлэлттэй байсан.

Хүснэгт 14-т суурь болон эцсийн судалгааны дэд түүврийн харьцуулалтыг харуулж байна. Суурь судалгаатай харьцуулахад Харилцааны үр чадвар, Тунгаан бодох үр чадвар, Өсөн дэвших болон Энтрепренерийн сэтгэлгээ гэсэн хэсгүүдэд ахиц ажиглагдсан.

Хүснэгт 14. Суурь судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар (Суурь болон Эцсийн)

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Нийт				Үндсэн				Хяналт			
	Суурь		Эцсийн		Суурь		Эцсийн		Суурь		Эцсийн	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Өөрийгөө танин мэдэх	985	2.17	878	2.13	596	2.24	537	2.18	389	2.16	341	2.05
Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар	985	2.02	878	1.96	600	2.03	537	2.05	385	2.02	341	1.91
Бүтээлч байдал ба инноваци	990	2.18	878	2.18	604	2.19	537	2.16	386	2.18	341	2.19
Харилцааны үр чадвар	983	2.23	878	2.12	599	2.23	537	2.11	384	2.23	341	2.13
Багаар ажиллах үр чадвар	979	2.07	878	2.01	596	2.04	537	1.93	383	2.05	341	1.98
Тунгаан бодох үр чадвар	975	2.14	878	2.05	596	2.15	537	2.04	379	2.11	341	2.07
Өсөн дэвших сэтгэлгээ	964	1.91	878	1.82	588	1.92	537	1.81	376	1.9	341	1.83
Энтрепренерийн сэтгэлгээ	968	1.84	878	1.78	590	1.84	537	1.77	378	1.83	341	1.79

Хүснэгт 15. Эцсийн судалгаа: ESEL оноо, бүлгийн статусаар

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Нийт		Үндсэн		Хяналт	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Өөрийгөө танин мэдэх	878	2.13	537	2.18	341	2.05
Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар	878	1.96	537	2.05	341	1.91
Бүтээлч байдал ба инноваци	878	2.18	537	2.16	341	2.19
Харилцааны үр чадвар	878	2.12	537	2.11	341	2.13
Багаар ажиллах үр чадвар	878	2.01	537	1.93	341	1.98
Тунгаан бодох үр чадвар	878	2.05	537	2.04	341	2.07
Өсөн дэвших сэтгэлгээ	878	1.82	537	1.81	341	1.83
Энтрепренерийн сэтгэлгээ	878	1.78	537	1.77	341	1.79

Эх сурвалж: Өгөгдлийн шинжээчийн тооцоолол

Суурь судалгааны хувьд Хяналтын бүлгийн дундаж үзүүлэлт Үндсэн бүлгээс доогуур байсан. Харин эцсийн судалгаагаар эсрэгээрээ буюу Үндсэн бүлгийн дундаж үзүүлэлт Хяналтын бүлгийн дунджаас бага байна. Энэ нь нийт үр дүн сайжирсныг харуулж байна.

Нарийвчилсан дүн шинжилгээгээр Үндсэн бүлгийн хувьд Энтрепренерийн сэтгэлгээ хэсэг хамгийн бага дундаж оноотой (1.73) хэвээр байна. Харин Харилцааны үр чадвар хэсэг хамгийн өндөр дундаж оноотой (2.10) байгаа нь хамгийн тааруу үзүүлэлтийг илтгэж байна.

Суурь болон эцсийн судалгааны дундаж утгуудыг харьцуулснаар үнэлгээний үзүүлэлтүүд хэрхэн өөрчлөгдөж, хөгжиж байгааг харуулсан чухал мэдээллийг харууллаа.

Хүснэгт 16. Судалгааны үр дүнгийн дундаж утгын харьцуулалт

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Суурь судалгаа		Эцсийн судалгаа		t test шинжилгээ		
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Mean dif	t	P-value
Өөрийгөө танин мэдэх	985	2.17	1979	2.09	-0.0823	-7.78***	0.000
Нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар	985	2.02	1979	1.87	-0.1518	-15.29***	0.000
Бүтээлч байдал ба инноваци	990	2.18	1979	2.07	-0.1104	-10.37***	0.000
Харилцааны үр чадвар	983	2.23	1979	2.10	-0.1344	-12.76***	0.000
Багаар ажиллах үр чадвар	979	2.07	1979	1.94	-0.1337	-12.29***	0.000
Тунгаан бодох үр чадвар	975	2.14	1979	2.01	-0.1318	-12.37***	0.000
Өсөн дэвших сэтгэлгээ	964	1.91	1979	1.79	-0.1203	-12.12***	0.000
Энтрепренерийн сэтгэлгээ	968	1.84	1979	1.73	-0.1071	-11.06***	0.000

Эх сурвалж: Өгөгдлийн шинжээчийн тооцоолол

Жич: *** 1% статистик ач холбогдолтой, ** 5% статистик ач холбогдолтой, * 10% статистик ач холбогдолтой.

Суурь судалгааны хувьд Хяналтын бүлгийн дундаж үзүүлэлт Үндсэн бүлгээс доогуур байсан. Харин эцсийн судалгаагаар эсрэгээрээ буюу Үндсэн бүлгийн дундаж үзүүлэлт Хяналтын бүлгийн дунджаас бага байна. Энэ нь нийт үр дүн сайжирсныг харуулж байна.

Нарийвчилсан дүн шинжилгээгээр Үндсэн бүлгийн хувьд Энтрепренерийн сэтгэлгээ хэсэг хамгийн бага дундаж оноотой (1.73) хэвээр байна. Харин Харилцааны үр чадвар хэсэг хамгийн өндөр дундаж оноотой (2.10) байгаа нь хамгийн тааруу үзүүлэлтийг илтгэж байна.

Эцсийн судалгааны үр дүн эерэг, илэрхий ахиц гарсныг харуулж байна. Энэхүү хэсэгт бид ESEL-ийн үр чадвар, сэтгэлгээний гол үр дүнг 8 шалгуур үзүүлэлтийн дагуу суурь болон эцсийн судалгааны үр дүн мөн үндсэн болон хяналтын бүлгүүдийн үр дүнг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.


2.4. Амьдралын хүсэл эрмэлзлэл

Энэхүү эцсийн судалгаагаар хүүхэд, залуусын зорьж буй зорилго, боломж, өөрийн чадварт итгэх байдлыг судалсан. Судалгааны асуулгад оролцогчид тодорхой өгүүлбэрүүдийг уншин, тухайн өгүүлбэртэй хэр зэрэг санал нийлж байгааг илэрхийлэх болон түүний ач холбогдлыг үнэлэх хэд хэдэн асуултууд багтсан.

Зорьсон зорилго ба боломжууд

Уг хэсэгт хүүхдүүд хувиараа хөдөлмөр эрхлэх болон хэн нэгний доор ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож буйг судалсан. Үр дүнгээс харахад бараг бүх оролцогч уг асуудлыг чухал гэж үзсэн ба ач холбогдлын түвшин нь ялгаатай байсныг Хүснэгт 17-д харуулсан болно.

Зураг 2. Бусдын төлөө ажиллахаас илүүтэйгээр өөрийнхөө төлөө ажиллах нь хүүхэд, залуусын хувьд хэр чухал эсэх



Хүснэгт 17. Бусдын төлөө ажиллахаас илүүтэйгээр өөрийнхөө төлөө ажиллах нь хүүхэд, залуусын хувьд хэр чухал эсэх (Суурь болон Эцсийн)

Хариултын хэлбэрүүд	Хяналт				Үндсэн			
	Суурь		Эцсийн		Суурь		Эцсийн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Надад хамаагүй	12	3%	10	3%	21	4%	18	3%
Хамаатай, гэхдээ нэг их чухал биш	187	48%	180	53%	292	48%	280	52%
Надад маш их хамаатай	192	49%	151	44%	293	48%	239	45%
Нийт	391	100%	341	100%	606	100%	537	100%

Үр дүнгээс харахад оролцогчдын хувьд зөвлөх багшийн дэмжлэг болон бусад суралцагчидтай хамтран ажиллах нь ганцаараа хичээллэхээс илүү үр дүнтэй, ач холбогдол өндөртэй байжээ. Гэхдээ суурь болон эцсийн судалгааны үр дүнд ялгаа ажиглагдаагүй.

Хүснэгт 18-д үзүүлсэнчлэн, судалгаанд оролцогчдын ихэнх нь өөрийн бизнес, компаниа байгуулан ажиллах нь маш чухал гэж үзсэн байна. Уг бат бэх энтрепренерийн сэтгэлгээ нь бие даасан байдал, шинэлэг санааг эрэлхийлэх хүсэл эрмэлзлэлийг илэрхийлж байгаа бөгөөд энэ нь цаашдын эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

Судалгаанд оролцогчдын 78 орчим хувь нь хувийн бизнесээ эхлүүлэхийн ач холбогдлыг онцолсон нь “Бизнес эрхлэх, Жижиг бизнес эрхлэх, Манлайлал” (ESEL) чиглэлийн боловсролыг дэмжих, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхой харуулж байна.

Хүснэгт 18. Өөрийнхөө хувийн бизнесийг эрхлэх/компаниа ажиллуулах нь хүүхэд, залуусын хувьд хэр ач холбогдолтой эсэх.

Хариултын хэлбэрүүд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Надад хамаагүй	11	3%	10	2%	21	2%
Хамаатай, гэхдээ нэг их чухал биш	58	17%	113	21%	171	20%
Надад маш их хамаатай	272	80%	414	77%	686	78%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 19. Өөрийнхөө хувийн бизнесийг эрхлэх/компаниа ажиллуулах нь хүүхэд, залуусын хувьд хэр ач холбогдолтой эсэх (Суурь болон эцсийн)

Хариултын хэлбэрүүд	Хяналт				Үндсэн			
	Суурь		Эцсийн		Суурь		Эцсийн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Надад хамаагүй	14	4%	11	3%	19	3%	10	2%
Хамаатай, гэхдээ нэг их чухал биш	83	21%	58	17%	143	23%	113	21%
Надад маш их хамаатай	294	75%	272	80%	447	73%	414	77%
Нийт	391	100%	341	100%	606	100%	537	100%

Хүснэгт 20-д харуулсанчлан судалгаанд хамрагдагсдын 83-аас дээш хувь нь ирээдүйнхээ талаар эерэг бодол, үзэлтэй байгаагаа илэрхийлсэн. Энэ нь хүүхэд, залуус өөрсдийн боломж, чадавхид итгэх итгэл, найдвар хүчтэй байгааг харуулж байна. Суурь болон эцсийн судалгааны үр дүнг харьцуулахад ялгаа ажиглагдаагүй.

Хүснэгт 20. Хүүхэд, залуусын сайн сайхан зүйлд итгэж буй хандлагын түвшин

Хариултууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их санал нийлж байна	89	26%	116	22%	205	23%
Санал нэг байна	199	58%	317	59%	516	59%
Мэдэхгүй	34	10%	47	9%	81	9%
Санал нийлэхгүй байна	19	6%	48	9%	67	8%
Санал огт нийлэхгүй байна	0	0%	9	2%	9	1%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 21. Хүүхэд, залуусын сайн сайхан зүйлд итгэж буй хандлагын түвшин (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	27%	23%
Санал нэг байна	55%	59%
Мэдэхгүй	12%	9%
Санал нийлэхгүй байна	5%	8%
Санал огт нийлэхгүй байна	1%	1%
Нийт	100%	100%

Судалгаанд оролцсон хүүхэд, залуусын дийлэнх нь ирээдүйн талаар өөдрөг үзэл, хандлагатай байгаа нь харагдаж байна. Өөдрөг үзэл нь хүчтэй хөдөлгөгч хүч бөгөөд сорилтуудыг даван туулах, тууштай байж зорилгодоо хүрэхэд тусалдаг. Хүүхэд, залуус өөрсдийгөө амжилтад хүрэх чадвартай гэж итгэдэг нь таатай үр дүн юм.

Хүснэгт 22. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин

Хариултууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их санал нийлж байна	224	66%	358	67%	582	66%
Санал нэг байна	100	29%	150	28%	250	29%
Мэдэхгүй	11	3%	18	3%	29	3%
Санал нийлэхгүй байна	6	2%	9	2%	15	2%
Санал огт нийлэхгүй байна	0	0%	2	0.4%	2	0.2%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 23-аас харахад суурь болон эцсийн судалгааны үр дүнд ялгаа ажиглагдаагүй. Гэхдээ үндсэн бүлгийн 2 судалгааг харьцуулж үзэхэд “Маш их санал нийлж байна” гэж хариулсан хүүхэд, залуусын хувь 66 болж бага зэрэг нэмэгдсэн байна (суурь судалгаанд 58% байсан). Харин хяналтын бүлгийн суурь болон эцсийн судалгааны хувьд мэдэгдэхүйц өөрчлөлт ажиглагдаагүй.

Хүснэгт 23. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	58%	66%
Санал нэг байна	36%	29%
Мэдэхгүй	4%	3%
Санал нийлэхгүй байна	2%	2%
Санал огт нийлэхгүй байна	0%	0.2%
Нийт	100%	100%

Хүснэгт 24. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	55%	67%
Санал нэг байна	38%	28%
Мэдэхгүй	5%	3%
Санал нийлэхгүй байна	2%	2%
Санал огт нийлэхгүй байна	0%	0.4%
Нийт	100%	100%

Хүснэгт 25. Хүүхэд, залуусын ирээдүйд хандах өөдрөг хандлагын түвшин (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	62%	66%
Санал нэг байна	33%	29%
Мэдэхгүй	4%	3%
Санал нийлэхгүй байна	1%	2%
Санал огт нийлэхгүй байна	0%	0.4%
Нийт	100%	100%

Хүснэгт 26-д үзүүлсэнчлэн судалгаанд оролцогчдын дийлэнх нь өөрсдийгөө завгүй байлгах нь чухал гэж үзсэн байна. Гэхдээ тэдний 8% орчим нь өөрийгөө завгүй байлгах нь чухал биш гэжээ. Энэ нь хүүхэд, залуус идэвхтэй, оролцоотой байх болон өөрсдийгөө завгүй байлгахын ач холбогдлыг хэрхэн ойлгодогт ялгаа байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 26. Завгүй байхын ач холбогдлын түвшин

Хариултууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их санал нийлж байна	113	33%	150	28%	263	30%
Санал нэг байна	168	50%	287	54%	455	52%
Мэдэхгүй	32	9%	56	10%	55	10%
Санал нийлэхгүй байна	27	8%	44	8%	71	8%
Санал огт нийлэхгүй байна	1	0.3%	0	0.0%	1	0.1%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 27. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	24%	30%
Санал нэг байна	51%	52%
Мэдэхгүй	15%	10%
Санал нийлэхгүй байна	9%	8%
Санал огт нийлэхгүй байна	1%	0.1%
Нийт	100%	100%

Хүснэгт 28. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	22%	28%
Санал нэг байна	53%	54%
Мэдэхгүй	15%	10%
Санал нийлэхгүй байна	9%	8%
Санал огт нийлэхгүй байна	1%	0.1%
Нийт	100%	100%

Хүснэгт 29. Завгүй байхын ач холбогдлын түвшин (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	27%	28%
Санал нэг байна	47%	54%
Мэдэхгүй	14%	10%
Санал нийлэхгүй байна	10%	8%
Санал огт нийлэхгүй байна	2%	0.4%
Нийт	100%	100%

Судалгааны үр дүнгээс харахад сурагчдын дийлэнх нь (58%) сургуулиа төгссөний дараа дээд боловсрол эзэмшихээр төлөвлөж байгаа гэсэн бөгөөд үндсэн болон хяналтын бүлгийн хооронд бага зэргийн ялгаа ажиглагдсан (Хүснэгт 30-д харуулав). Нэмж хэлэхэд сурагчдын 22.1% нь мэргэжлийн боловсрол эзэмшихээр төлөвлөж байгаа бол 10% нь өөрийн бизнесээ эхлүүлэхээр зорьж байгаа. Харин 7.1% нь ажил хайхаар төлөвлөж байгаа аж.

Хүснэгт 30. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар

Сургууль төгссөний дараах боломжууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Дээд боловсрол	195	57%	317	59%	512	58%
Мэргэжлийн боловсрол	71	21%	125	23%	196	22%
Жил өнжих буюу завсарлах	3	1%	4	1%	7	1%
Ажилтай болох	24	7%	36	7%	60	7%
Өөрийн бизнесийг эхлүүлэх	41	12%	47	9%	88	10%
Малчин болох	1	0.3%	1	0.2%	2	0.2%
Өөрийн гэр бүлтэй болох	2	1%	1	0.2%	3	0.3%
Би ЕБС эсвэл МСҮТ/Коллежид суралцдаггүй	0	0%	2	0.4%	2	0.2%
Бусад	4	1%	4	1%	9	1%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Суурь судалгаатай харьцуулахад дээд боловсрол эзэмшихийг хүсэж байгаа хүүхэд, залуусын хувь 50%-иас 58% болж бага зэрэг өссөн байна. Уг өсөлт нь үндсэн бүлэгт (49%-иас 59%) илүү тод ажиглагдсан бол хяналтын бүлгийн суурь болон эцсийн судалгааны хооронд багахан ялгаа ажиглагдсан (Хүснэгт 31-д харуулав).

Хүснэгт 31. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Дээд боловсрол	50%	58%
Мэргэжлийн боловсрол	25%	22%
Жил өнжих буюу завсарлах	1%	1%
Ажилтай болох	12%	7%
Өөрийн бизнесийг эхлүүлэх	8%	10%
Малчин болох	1%	0.2%
Өөрийн гэр бүлтэй болох	1%	0.3%
Би ЕБС эсвэл МСҮТ/Коллежид суралцдаггүй	0%	0.2%
Бусад	1%	1%
Ажиглаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 32. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Дээд боловсрол	49%	59%
Мэргэжлийн боловсрол	26%	23%
Жил өнжих буюу завсарлах	1%	1%
Ажилтай болох	11%	7%
Өөрийн бизнесийг эхлүүлэх	8%	9%
Малчин болох	2%	0.2%
Өөрийн гэр бүлтэй болох	1%	0.2%
Би ЕБС эсвэл МСҮТ/Коллежид суралцдаггүй	0%	0.4%
Бусад	1%	1%
Ажиглаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 33. Сургууль төгссөний дараа хүүхэд, залуусын сонгох боломжит замууд, бүлгийн статусаар (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Дээд боловсрол	51%	57%
Мэргэжлийн боловсрол	23%	21%
Жил өнжих буюу завсарлах	1%	1%
Ажилтай болох	12%	7%
Өөрийн бизнесийг эхлүүлэх	8%	12%
Малчин болох	2%	0.3%
Өөрийн гэр бүлтэй болох	0%	1%
Би ЕБС эсвэл МСҮТ/Коллежид суралцдаггүй	0%	0%
Бусад	1%	1%
Ажиглаагүй	2%	0%
Нийт	100%	100%

Өөрийн чадварт итгэх байдал

Судалгаанд оролцогчдоос “Маш их хөдөлмөрлөх нь чухал” эсэхийг тодруулахад 95% нь санал нийлж байна болон бүрэн санал нийлж байна гэж хариулсан. Үндсэн болон хяналтын бүлгийн хариулт нь бараг ялгаагүй байсан ба амжилтанд хүрэхэд хичээл зүтгэлтэй, шаргуу ажиллахын ач холбогдлыг оролцогчдын дийлэнх нь чухалчилж байгааг харуулж байна (Хүснэгт 34-т харуулав).

Хүснэгт 34. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх)

Хариултууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их санал нийлж байна	214	63%	326	61%	540	62%
Санал нэг байна	110	32%	174	32%	284	32%
Мэдэхгүй	7	2%	17	3%	24	3%
Санал нийлэхгүй байна	7	2%	20	4%	27	3%
Санал огт нийлэхгүй байна	3	1%	0	0%	3	0.3%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Суурь болон эцсийн судалгааны үр дүнг харьцуулан харахад суурь судалгаанд 54%-тай байсан үзүүлэлт эцсийн судалгаанд 62%-тай болж өссөн нь цаг хугацааны явцад хичээл зүтгэлтэй, шаргуу ажиллахын ач холбогдлыг хүүхдүүд илүү ихээр хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 35. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	54%	62%
Санал нэг байна	41%	32%
Мэдэхгүй	4%	3%
Санал нийлэхгүй байна	1%	3%
Санал огт нийлэхгүй байна	0%	0.3%
Нийт	100%	100%

Хүснэгт 36. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	53%	61%
Санал нэг байна	42%	32%
Мэдэхгүй	4%	3%
Санал нийлэхгүй байна	1%	4%
Санал огт нийлэхгүй байна	0%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 37. Амьдралд шаргуу, хичээл зүтгэлтэй ажиллахын ач холбогдлыг хэрхэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгаа эсэх (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их санал нийлж байна	56%	63%
Санал нэг байна	38%	32%
Мэдэхгүй	4%	2%
Санал нийлэхгүй байна	2%	2%
Санал огт нийлэхгүй байна	0%	1%
Нийт	100%	100%

Судалгаагаар оролцогчдоос 5 жилийн дараа нийгмийн болон эдийн засгийн нөхцөл байдал хэр сайжирсан байх эсэхийг асуухад “Бага зэрэг сайжирсан байна” гэж оролцогчдын 45% буюу олонх нь хариулсан бол “Бараг л адилхан байна” гэж 31% нь хариулжээ (Хүснэгт 38 болон 39-д харуулав). Энэ нь судалгаанд оролцсон хүүхэд, залуусын тодорхой хэсэг нь нийгмийн болон эдийн засгийн нөхцөл байдал бага зэрэг сайжирсан байна гэж үзэж байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 38. Нийгэм, эдийн засгийн байдал 5 жилийн дараа сайжиргах эсэх

Хариултууд	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их сайжирна	55	16%	76	14%	131	15%
Сайжирна	148	44%	251	47%	399	45%
Мэдэхгүй	103	30%	172	32%	275	31%
Сайжрахгүй	31	9%	27	5%	58	7%
Огт сайжрахгүй	4	1%	11	2%	15	2%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Хүснэгт 39. Нийгэм, эдийн засгийн байдал сайжиргах эсэх (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	21%	15%
Сайжирна	50%	45%
Мэдэхгүй	23%	31%
Сайжрахгүй	4%	7%
Огт сайжрахгүй	1%	2%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 40. Нийгэм, эдийн засгийн байдал сайжиргах эсэхийг хэрхэн үнэлж буй талаар (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	21%	14%
Сайжирна	52%	47%
Мэдэхгүй	22%	32%
Сайжрахгүй	4%	5%
Огт сайжрахгүй	1%	2%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 41. Нийгэм, эдийн засгийн байдал сайжрах эсэхийг хэрхэн үнэлж буй талаар (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	22%	16%
Сайжирна	47%	44%
Мэдэхгүй	24%	30%
Сайжрахгүй	5%	9%
Огт сайжрахгүй	1%	1%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Судалгаанд оролцогчдоос “Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ?” гэж асуухад 61% нь энэ байдал сайжирна гэж хариулсан бол 33% нь энэ байдал хэвэндээ байна гэж хариулсан (Хүснэгт 42-т харуулав). Үндсэн болон хяналтын бүлгийн үр дүн ойролцоо байсан ба илүү муу болно гэсэн хариултыг сонгосон хүүхэд, залуусын хувь нь мэдэгдэхүйц ялгаагүй байсан. Энэхүү судалгаанд оролцогчдын олонх нь улс орныхоо ирээдүйн нийгэм болон эдийн засгийн нөхцөл байдалд өөдрөг хандлагатай байна. Суурь болон эцсийн судалгааны үр дүнд ялгаа ажиглагдаагүй.

Хүснэгт 42. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ?

Нийгэм эдийн засгийн нөхцөл байдлын талаарх үзэл бодол	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Маш их сайжирна	54	16%	83	16%	137	16%
Сайжирна	155	45%	238	44%	393	45%
Мэдэхгүй	112	33%	177	33%	289	33%
Сайжрахгүй	17	5%	37	7%	54	6%
Огт сайжрахгүй	3	1%	2	0.4%	5	0.5%
Нийт	341	100%	1638	100%	1979	100%

Хүснэгт 43. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Нийт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	22%	16%
Сайжирна	47%	45%
Мэдэхгүй	27%	33%
Сайжрахгүй	2%	6%
Огт сайжрахгүй	1%	0.5%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 44. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Үндсэн)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	21%	16%
Сайжирна	47%	44%
Мэдэхгүй	28%	33%
Сайжрахгүй	2%	7%
Огт сайжрахгүй	1%	0.4%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 45. Эцэг эхтэйгээ харьцуулвал, таны амьдарч байгаа өнөөгийн нийгэм эдийн засгийн байдал таныг тэдний насан дээр очиход хэр байна гэж бодож байна вэ? (Хяналт)

Хариултууд	Суурь	Эцсийн
	Хувь	Хувь
Маш их сайжирна	22%	16%
Сайжирна	48%	45%
Мэдэхгүй	25%	33%
Сайжрахгүй	3%	5%
Огт сайжрахгүй	1%	1%
Ажиглагдаагүй	1%	0%
Нийт	100%	100%

Хүснэгт 46. Урт хугацаандаа шаргуу ажиллах нь илүү сайхан амьдралруу хөтөлнө.

Сайхан амьдралын төлөө шаргуу хөдөлмөрлөх нь чухал эсэх	Хяналт		Үндсэн		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
0	0	0%	0	0%	0	0%
10	0	0%	0	0%	0	0%
20	1	0.3%	0	0%	1	0.1%
30	3	1%	2	0.4%	5	1%
40	1	0.3%	5	1%	6	1%
50	34	10%	44	8%	78	9%
60	22	6%	33	6%	55	6%
70	51	15%	67	13%	118	14%
80	86	25%	146	27%	232	26%
90	71	21%	98	18%	169	19%
100	72	21%	142	26%	214	24%
Нийт	341	100%	537	100%	878	100%

Судалгааны үр дүнгээс харахад үндсэн болон хяналтын бүлгүүдийн оролцогчид уг бодомжтой маш их санал нийлж байгаагаа илэрхийлсэн. Уг бодомжийг 0-100-ийн хооронд үнэлэхэд бүх бүлгийн дундаж оноо 81.5-аас их байсан ба бүлгүүдийн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй. Энэ нь бүх бүлгийн оролцогчид сайн сайхан амьдралын төлөө шаргуу хөдөлмөрлөхийг чухалчилж буйг харуулж байна.

Энэхүү хэсэгт Амьдралын хүсэл эрмэлзлэл болон Өөрийн чадварт итгэх байдал хэсгийн үзүүлэлтүүдийн гол үр дүнд дүн шинжилгээ хийж, үндсэн болон хяналтын бүлгүүд мөн суурь болон эцсийн судалгааны үр дүнг хооронд нь харьцуулж дүн шинжилгээ хийлээ.



Бүлэг 3.

ANCHORING VIGNETTES ТОХИРУУЛГА

Эцсийн үр дүнгийн судалгаанд AV аргыг ашигласан нь хэд хэдэн чухал зорилгыг агуулж байна. Нэгдүгээрт, хувь хүний үр чадварыг судлахад дийлэнхдээ ашигладаг уламжлалт өөрийн үнэлгээний аргын үед бий болдог хязгаарлагдмал байдал болон гажуудлыг бууруулах зорилготой. AV арга нь тодорхой шинж чанартай, зохиомол дүрүүдийн богино өгүүлэмжийг оролцогчдод өгснөөр тухайн үр чадварыг илүү нарийн, бодитойгоор үнэлэх боломжийг бий болгодог. Ингэснээр оролцогчид нийгмийн хүлээлтэд нийцсэн хариулт эсвэл туйлын хариулт өгөх байдлаас сэргийлж, судалгааны найдварт чанар, хүчин төгөлдөр байдлыг нэмэгдүүлдэг.

Түүнчлэн уг аргыг ашигласнаар судалгаанд оролцогчдын ойлголтын түвшинг үнэлэх боломжтой бөгөөд оролцогчид судалгааны асуултуудыг хэр зэрэг ойлгож, идэвхитэй хариулж байгааг тодорхойлох юм. Ерөнхийдөө AV аргыг эцсийн судалгаанд ашигласан нь тухайн судалгаанд хамрагдагсдын хувь хүний үр чадварыг илүү үнэн зөв, шударга, найдвартайгаар үнэлэх стратегийн ач холбогдолтой алхам болсон.

Туршилт судалгаа: Эцсийн судалгааны өмнө ESEL сургалтын хөтөлбөрийн зорилтот үр чадвар, сэтгэлгээг үнэлэхийн тулд шинээр боловсруулсан AV үзүүлэлтүүдийн найдварт чанарыг шалгах зорилгоор туршилтын судалгааг 2023 оны 3 дугаар сарын 1-нээс 4-ний хооронд төсөлд хамрагдаагүй аймаг болох Сэлэнгэ, Төв аймгийн дөрвөн суманд (Төв аймгийн Борнуур, Баянчандмань сум болон Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум) 13-26 насны 350 оролцогчийг хамруулан зохион байгуулсан. Уг судалгааны асуулгыг өөрчилж, ESEL-ийн үндсэн үр чадварууд (өөрийгөө танин мэдэх, нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар, харилцааны үр чадвар, бүтээлч байдал, тунгаан бодох үр чадвар) болон сэтгэлгээний (өсөн дэвших болон энтрепренер) хувьд тус бүрт их, дунд, бага гэсэн гурван түвшний AV үзүүлэлтийг багтаасан.

Туршилт судалгааны үр дүнд AV засвартай асуулга нь анхны (AV засваргүй) асуулгатай харьцуулахад илүү найдвартай болох нь тогтоогдсон. Иймд уг шинээр боловсруулсан AV засвартай асуулгыг эцсийн үнэлгээний судалгаанд ашиглахаар шийдвэрлэсэн. AV үзүүлэлтүүдийг оруулснаар оролцогчдын өөрийн үнэлгээнд суурилсан хувь хүний үр чадварын үнэлгээг илүү найдвартай, бодитой болгох зорилготой байв. Мөн AV арга нь өөрийн үнэлгээнд нөлөөлөх магадлалтай хүйсийн ялгаа зэрэг гажуудлыг багасгах боломжийг бий болгосон. Энэхүү стратегийн сайжруулалт нь судалгааны үр дүнг илүү бодитой, цогц байдлаар ойлгож, сургалтын хөтөлбөрийн үр нөлөөг илүү нарийн үнэлэх нөхцлийг бүрдүүлсэн юм.

AV боловсруулалт: Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан AV хэрэглэгдэхүүн шинээр зохиохоос илүүтэй өмнө нь үр дүнтэй ашиглагдаж байсан AV хэрэглэгдэхүүнийг чөлөөтэй ашиглах боломжтой эх сурвалжаас сонгон тохируулан ашиглах нь илүү зохистой шийдэл байв. Тодруулбал AV хэрэглэгдэхүүнийг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа ба Хөгжлийн Байгууллагын (ЭЗХАХБ) “Нийгэм, сэтгэл хөдлөлийн үр чадварын судалгаа” болон Youth Power Action-ийн “Залуучуудын зөөлөн үр чадварын үнэлгээний хэрэгсэл” гэх хоёр судалгаанаас сонгон ESEL-ийн суурь судалгааны өөрийн үнэлгээний аргатай уялдуулан боловсруулсан.

Шинэчилэн сайжруулсан үнэлгээнд нийгэм, сэтгэл хөдлөлийн үр чадвар болон сэтгэлгээ бүрт 3 түвшний AV жишээ агуулсан: өндөр түвшний жишээ (өндөр vignette), дунд түвшний жишээ (дунд vignette) болон бага түвшний жишээ (бага vignette). Эдгээр жишээг боловсруулсан зорилго нь өөр өөр сэдвүүдэд бий болох хариултын хэт хазайлтаас сэргийлэх юм. Судалгаанд оролцогчдын өөрийн үнэлгээг эдгээр зохиомол дүрүүдийн үнэлгээтэй харьцуулан шинжилсэн. Мөн оролцогчид нэг төрлийн хариулт хэт их өгөх эсвэл хялбарчлах байдал бий болгохоос сэргийлж AV жишээнүүдийг санамсаргүй дарааллаар хольж ашигласан.

Үүнээс гадна ESEL үр чадвар болон сэтгэлгээний талаар өөрийн үнэлгээний асуултуудыг AV жишээнээс өмнө үзүүлсэн нь хүсээгүй урьдчилсан нөлөөллөөс зайлсхийх зорилготой байв.

Зохиомол дүрүүдийн нэр: Судалгаанд оролцогчдод илүү ойлгомжтой байлгах үүднээс нийтлэг Монгол нэрүүдийг зохиомол дүрүүдэд оноосон. Гэхдээ хүйстэй холбоотой алдаа үүсэж болзошгүй гэж

үзсэн учир эдгээр нэрсийг “Сурагч А, Сурагч В, Сурагч С” гэх мэт хүйсийн илэрхийлэлгүй тэмдэглэгээгээр сольсон. Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн зөвлөснөөр AV жишээг оролцогчийн хүйсээр бүлэглэн эрэгтэй оролцогчдод нийтлэг Монгол эрэгтэй нэрсийг, эмэгтэй оролцогчдод нийтлэг Монгол эмэгтэй нэрсийг ашигласан. Уг өөрчлөлт нь судалгааны хариултад хүйстэй холбоотой алдааг багасгах зорилготой байв.

AV аргын найдварт чанар: AV аргын найдварт чанарыг үнэлэхдээ анхдагч болон AV засвартай асуулгын онооны нийцтэй байдлыг хэмжсэн ба Кронбах Альфа шинжилгээгээр тус коэффициент .695-аас .950 болж мэдэгдэхүйц өссөн байна (Хүснэгт 47-д харуулав). Энэхүү үр дүн нь AV арга нь нийгэм сэтгэл хөдлөлийн үр чадварын өөрийн үнэлгээний найдварт байдлыг мэдэгдэхүйц хэмжээгээр сайжруулах боломжтойг харуулж байна.

Хүснэгт 47. AV аргын найдварт чанар

	Хувьсагч бүрийн Кронбах Альфа коэффициент	
	Анхдагч хэмжүүр (өөрийн үнэлгээ)	Зассан хувилбарын хэмжүүр (AV засвартай)
ESEL 6 үр чадвар, 2 сэтгэлгээ	.695	.950

3.1. Anchoring Vignettes аргын хүчин төгөлдөр байдал

AV аргын хүчин төгөлдөр байдлыг тодорхойлоход дараах 2 хэмжүүр чухал юм:

- i. **Хариултын нийцэл:** Оролцогчийн өөрийгөө үнэлсэн үнэлгээ болон AV дүрийг үнэлсэн үнэлгээний ялгаа хооронд эерэг хамаарал байх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, оролцогч өөрийгөө үнэлэхдээ болон хийсвэр дүрүүдийг үнэлэхдээ ижил шалгуур ашиглах ёстой. Үүнийг шалгахдаа өөрийн үнэлгээ болон AV үнэлгээний хоорондын корреляцийг тооцоолно. Эерэг хамаарал илэрвэл тухайн оролцогч өөрийн үнэлгээ болон дүрүүдийн үнэлгээнд ижил шалгуур хэрэглэж байна гэж үзэж болох ба энэ нь AV аргын дотоод нийцэл болон хэмжүүрийн хүчин төгөлдөр байдлыг баталгаажуулна.
- ii. **Vignette тэнцэтгэл:** Уг таамаглал нь оролцогч бүр AV жишээг ижил дарааллаар ойлгож, тухайн чадварын түвшинг (өндөр, дунд, бага) ижил утгаар хүлээн авч байгаа эсэхийг шалгана. Хэрэв оролцогчид AV жишээг харилцан адилгүйгээр эрэмбэлж байвал AV аргын хүчин төгөлдөр байдал эргэлзээтэй гэсэн үг. Үүнийг шалгахдаа эхлээд Vignette-ийн эрэмбэлэлтийн алдааг шалгана. R програмын “anchor” багц ашиглан оролцогч бүрийн Vignette эрэмбэлэлтийн ялгааг илрүүлж болох ба

эрэмбэлэлтийн алдаа 10%-аас их байвал оролцогчдын дийлэнх нь Vignette-ийн урьдчилан тогтоосон дарааллыг өөрөөр хүлээн авч байна гэж үзнэ. Энэ нь AV аргын хүчин төгөлдөр байдалд сөргөөр нөлөөлнө.

Шинжилгээний үр дүн

- **Vignette эрэмбэлэлт:** R программын “anchor” багц ашиглан Vignette-ийн эрэмбэлэлтийг шалгасан ба хамгийн түгээмэл эрэмбэлэлт Vignette 1 < Vignette 2 < Vignette 3 байсан бөгөөд 876 оролцогч (81%) эдгээр Vignette-үүдийг төлөвлөсний дагуу эрэмбэлсэн. Энэ нь оролцогчдын зүгээс vignette-ийг ойлгоход асуудал байгаагүйг харуулж байна. Иймд vignette-ийн тэнцвэрт байдлын таамаглал батлагдаж байгаа ба оролцогчдын дийлэнх нь vignette-үүдийг тогтвортой, хүлээлтэд нийцсэн байдлаар үнэлсэн байна.
- **Vignette тэнцэтгэл:** Тэнцүү байдлын таамаглалыг гүнзгийрүүлэн судлахын тулд өөрийн үнэлгээ болон 3 төрлийн vignette-үүдийн дундаж утга болон стандарт хазайлтыг шалгаж үзсэн (Хүснэгт 48-д харуулав). Vignette-үүдийн дундаж утгууд нь дараах эрэмбийг баталж байна: Өндөр vignette нь дунд vignette-ээс өндөр үнэлгээтэй байсан бол дунд vignette бага vignette-ээс өндөр үнэлгээ авсан. Ийм тогтвортой эрэмбэлэлт нь vignette-үүдийн тэнцвэрт байдлын таамаглалыг баталж байгаа ба оролцогчид vignette-ийн хувьсагчуудыг ижил байдлаар хүлээн авч, ойлгож үнэлсэн болохыг илэрхийлж байна.

Хүснэгт 48. Өөрийн үнэлгээ болон vignette үнэлгээний тодорхойлох статистик

ESEL ур чадвар, сэтгэлгээ	Өөрийн үнэлгээ		Vignette 3 (Их)		Vignette 2 (Дунд)		Vignette 1 (Бага)	
	M	SD	M	SD	M	SD	M	SD
Өөрийгөө танин мэдэх	4.14	.84	4.11	.86	3.03	1.07	2.31	1.00
Нийгэм соёлыг танин мэдэх ур чадвар	4.11	.74	4.50	.66	2.54	.98	1.69	.87
Бүтээлч байдал ба инноваци	4.27	.61	4.39	.65	2.50	.94	2.04	.87
Харилцааны ур чадвар	3.96	.87	4.25	.69	2.44	.89	1.86	.81
Багаар ажилллах ур чадвар	4.03	.63	4.28	.68	2.77	.93	2.13	.89
Тунгаан бодох ур чадвар	3.96	.73	4.16	.75	3.38	.95	2.35	.93
Өсөн дэвших сэтгэлгээ	4.35	.63	4.30	.63	3.15	1.08	1.93	1.04
Энтрепренерийн сэтгэлгээ	3.89	.87	4.12	.63	3.15	.97	2.08	.91

Дүгнэлт

Vignette-үүдийн эрэмбэлэлт, өөрийн үнэлгээ болон vignette-үүдийн дундаж утга, стандарт хазайлтын дүн шинжилгээний үр дүнгээс харахад оролцогчдын хариултын тогтвортой байдал болон vignette-үүдийн тэнцвэрт байдал гэсэн хоёр гол таамаглал батлагдаж байна. Өөрийн үнэлгээ болон vignette үнэлгээний хоорондын эерэг хамаарал, мөн vignette-үүдийн тогтвортой эрэмбэлэлт нь AV арга энэхүү судалгааны нийгэм-сэтгэл хөдлөлийн үр чадварыг үнэлэхэд тохиромжтой, хүчин төгөлдөр арга болохыг харуулж байна. Түүнчлэн уг арга нь судалгааны үр дүнг илүү баталгаатай болгож, өөрийн үнэлгээний найдварт чанарыг нэмэгдүүлж, боломжит алдаа, гажуудлыг бууруулах ач холбогдолтой.

3.2. Anchoring Vignettes ашиглан өөрийн үнэлгээг засварлах

Оролцогчдын өөрийн үнэлгээний хариултыг AV аргаар засварлахын тулд параметрийн бус энгийн аргыг ашигласан. Уг арга нь оролцогч vignette-ийн хийсвэр дүрүүдийг хэрхэн үнэлж буйд суурилан өөрийн үнэлгээг тохируулж, боломжит алдааг арилгах, багасгах зорилготой юм. Уг засвар нь $2J+1$ гэж нэрлэгддэг дүрмийн дагуу хийгдэх бөгөөд J нь тухайн судалгаанд ашигласан vignette-ийн тоо юм. Уг судалгааны хүрээнд 3 vignette ашигласан:

- **Vignette 1:** Ур чадварын доод түвшин (үнэлж буй ур чадвар эсвэл сэтгэлгээний доод түвшинг илэрхийлнэ)
- **Vignette 2:** Ур чадварын дунд түвшин (үнэлж буй ур чадвар эсвэл сэтгэлгээний дунд түвшинг илэрхийлнэ)
- **Vignette 3:** Ур чадварын өндөр түвшин (үнэлж буй ур чадвар эсвэл сэтгэлгээний өндөр түвшинг илэрхийлнэ)

Өөрийн үнэлгээг засах алхамууд

1. **Өөрийгөө үнэлэх:** Судалгаанд оролцогчид эхлээд 5 оноотой Likert-ийн шкалаар тухайн ур чадвар болон сэтгэлгээг үнэлнэ.
2. **Vignette үнэлэх:** Судалгаанд оролцогчид дараа нь өөр өөр түвшний 3 vignette-ийг үнэлэх ба мөн Likert-ийн шкалыг ашиглана.
3. **Дүрмийн дагуу дахин үнэлэх:** Судалгаанд оролцогчдын өөрийн үнэлгээг vignette үнэлгээтэй харьцуулан тохируулж, засна. $2J + 1$ дүрэм нь оролцогчдын өөрийн үнэлгээ нь хийсвэр дүрийн үнэлгээтэй нийцэж байгаа эсэхийг шалгадаг ба эцсийн засварлагдсан оноо нь уг дахин үнэлэх аргын дагуу тооцоологдоно. Энэ нь оролцогчийн өөрийн үнэлгээнд хийсвэр дүр буюу бүсдын ур чадварыг хэрхэн үнэлсэнг харгалзан үзнэ гэсэн үг юм.

Хүснэгт 49. Өөрийн үнэлгээний оноог AV арга ашиглан засварлах дүрмүүд

Харьцангуй үнэлгээ	Засварласан оноо
Self < Vignette 1 < Vignette 2 < Vignette 3	1
Self = Vignette 1 < Vignette 2 < Vignette 3	2
Vignette 1 < Self < Vignette 2 < Vignette 3	3
Vignette 1 < Self = Vignette 2 < Vignette 3	4
Vignette 1 < Vignette 2 < Self < Vignette 3	5
Vignette 1 < Vignette 2 < Self = Vignette 3	6
Vignette 1 < Vignette 2 < Vignette 3 < Self	7

AV аргыг баталгаажуулахын тулд хариултуудын нийцлийг үнэлдэг ба оролцогчид өөрийгөө болон хийсвэр буюу зохиомжит дүрийг үнэлэхдээ ижил стандартыг ашигласан эсэхийг илэрхийлнэ. Өөрийн үнэлгээ болон дүрийн үнэлгээ хоорондын эерэг хамаарал нь тухайн оролцогч аль алинд нь тогтвортой, ижил босго ашигласан болохыг илтгэдэг.

Аргачлал:

Өөрийн үнэлгээ vs Vignette үнэлгээ: Өөрийн үнэлгээ болон хийсвэр дүрийн үнэлгээ хоорондын хамаарлыг тооцоолон оролцогч ижил стандарт ашиглаж байгаа эсэхийг шалгана.

Үр дүн:

Хүснэгт 50, 51-д өөрийн үнэлгээ болон хийсвэр дүрийн үнэлгээ хоорондын эерэг хамаарлыг харуулав. Хүчтэй хамаарал нь оролцогч ижил стандарт ашиглан үнэлгээ өгснийг илтгэх ба энэ нь өгөгдлийн найдварт чанарыг нэмэгдүүлдэг.

Хүснэгт 50. ESEL ур чадварын өөрийн үнэлгээ болон засварласан онооны хамаарал

Өөрийн үнэлгээний оноо	Vignette засвартай оноо					
	Өөрийгөө танин мэдэх	Нийгэм соёлыг танин мэдэх ур чадвар	Бүтээлч байдал, инноваци	Харилцааны ур чадвар	Багаар ажиллах ур чадвар	Тунгаан бодох ур чадвар
Өөрийгөө танин мэдэх	.406**					
Нийгэм соёлыг танин мэдэх ур чадвар		.525**				
Бүтээлч байдал ба инноваци			.537**			
Харилцааны ур чадвар				.592**		
Багаар ажиллах ур чадвар					.472**	
Тунгаан бодох ур чадвар						.518**

Note: *p<0.05; **p<0.01

Эерэг хамаарал нь AV арга нийгэм, сэтгэл хөдлөлийн буюу хувь хүний үр чадварын өөрийн үнэлгээний нийцтэй, хүчин төгөлдөр байдлыг сайжруулж байгааг илэрхийлнэ.

Хүснэгт 51. ESEL сэтгэлгээний өөрийн үнэлгээ болон засварласан онооны хамаарал

Өөрийн үнэлгээний оноо	Vignette засвартай оноо	
	Өсөн дэвших сэтгэлгээ	Энтрепренерийн сэтгэлгээ
Өсөн дэвших сэтгэлгээ	.543**	
Энтрепренерийн сэтгэлгээ		.651**

Суурь судалгааны үнэлгээнд нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, багаар ажиллах үр чадвар, тунгаан бодох үр чадвар, харилцааны үр чадвар болон бизнес сэтгэлгээний хувьд хүйсийн ялгаатай байдал ажиглагдсан. AV аргыг ашиглан тохируулга хийхэд эдгээр хүйсийн ялгаа арилсан ба нэг л үзүүлэлтэд ялгаа ажиглагдсан: Эмэгтэй сурагчид нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, энэрэх чадвар, бусдыг хүндлэх болон өөр өөр үзэл бодлыг ойлгон хүлээн авах чадварт илүү өндөр оноотой хэвээр байсан.

AV аргыг ашиглан хүйстэй холбоотой гажуудлуудыг үр дүнтэй зассан. Хүснэгт 52-т харуулснаар AV нь эрэгтэй, эмэгтэй сурагчдын өөрийгөө танин мэдэх, бүтээлч байдал, харилцааны үр чадварын өөрийн үнэлгээнд ажиглагдсан алдаануудыг арилгасан ба энэ нь ESEL үр чадвар болон сэтгэлгээг үнэлэх үнэн зөв, хариултын алдаагүй үнэлгээ хийх боломжийг олгосон.

Хүснэгт 52. Өөрийн үнэлгээ болон AV засварласан оноо хүйсээр

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Өөрийн үнэлгээний оноо					AV засвартай оноо				
	Эрэгтэй		Эмэгтэй		Р утга	Эрэгтэй		Эмэгтэй		Р утга
	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт		Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	
Өөрийгөө танин мэдэх	2.84	.50	2.85	.49	.388	6.01	.73	6.00	.74	.427
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	3.05	.43	3.18	.43	.001	5.62	.63	5.74	.64	.005
Бүтээлч байдал ба инноваци	2.89	.48	2.91	.44	.189	5.90	.65	5.87	.65	.250
Харилцааны үр чадвар	2.88	.47	2.92	.45	.062	5.77	.64	5.83	.63	.089
Багаар ажиллах үр чадвар	2.99	.48	3.08	.47	.005	5.78	.63	5.79	.58	.400
Тунгаан бодох үр чадвар	2.91	.49	3.01	.45	.001	5.80	.66	5.83	.67	.256
Өсөн дэвших сэтгэлгээ	3.16	.44	3.20	.41	.148	6.02	.68	6.04	.61	.393
Энтрепренерийн сэтгэлгээ	3.22	.43	3.27	.41	.050	5.91	.63	5.85	.62	.097

Сургуулийн хэлбэр болон өөрийгөө танин мэдэх, харилцааны ур чадвар болон энтрепренерийн сэтгэлгээ оноо хооронд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан ба ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) сурагчид өөрсдийгөө МСҮТ болон НТБТ-ийн сурагчдаас илүү өндрөөр үнэлсэн байна. Гэхдээ AV тохируулга хийсний дараа эдгээр ялгаа арилсан. Хүснэгт 53-д харуулав.

Хүснэгт 53. AV засварласан оноо, сургуулийн хэлбэрээр

AV засвартай оноо	ЕБС		МСҮТ		НТБТ		Р утга
	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	
Өөрийгөө танин мэдэх	6.00	1.85	5.91	.66	5.50	.70	.568
Нийгэм соёлыг танин мэдэх ур чадвар	5.69	.63	5.91	.51	6.00	1.41	.379
Бүтээлч байдал ба инноваци	5.88	.65	6.00	.73	5.87	.70	.353
Харилцааны ур чадвар	5.81	.63	5.91	.79	5.92	.70	.271
Багаар ажиллах ур чадвар	5.78	.60	6.08	.79	6.00	1.41	.212
Тунгаан бодох ур чадвар	5.82	.66	5.91	.66	6.1	.70	.317
Өсөн дэвших сэтгэлгээ	6.03	.63	6.08	.90	6.2	.70	.573
Энтрепренерийн сэтгэлгээ	5.87	.62	6.25	.62	6.12	.71	.043

Суурь судалгааны ESEL үнэлгээнд эрэгтэй асран хамгаалагчийн оролцооноос шалтгаалсан статистик ялгаа ажиглагдаагүй. Гэвч өөрийн үнэлгээг AV аргаар засварласны дараа өөрийгөө танин мэдэх, багаар ажиллах болон тунгаан бодох зэрэг ур чадварын хувьд статистик ялгаа ажиглагдсан. Эрэгтэй асран хамгаалагчтай сурагчид эдгээр ур чадваруудад өөрийгөө илүү өндрөөр үнэлж байсан нь Хүснэгт 54-өөс харагдаж байна.

Зөвхөн багаар ажиллах ур чадвар нь эцгийн эсвэл эрэгтэй асран хамгаалагчийн боловсролын түвшингээс шалтгаалан ялгаатай байсан. Жишээ нь, эцэг эсвэл эрэгтэй асран хамгаалагч нь боловсролгүй сурагчид багаар ажиллах ур чадвараа хамгийн багаар үнэлсэн байна. Харин эцгийн эсвэл эрэгтэй асран хамгаалагчийн мэргэжлээс шалтгаалсан ялгаатай байдал ур чадвар болон сэтгэлгээнд ажиглагдаагүй.

Хүснэгт 54. AV засварласан оноо, Эрэгтэй асран хамгаалагчийн оролцоогоор

AV засвартай оноо	Эрэгтэй асран хамгаалагч байгаа		Эрэгтэй асран хамгаалагч байхгүй		P value
	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	
Өөрийгөө танин мэдэх	6.01	.73	5.90	.68	.038
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	5.69	.64	5.66	.56	.173
Бүтээлч байдал ба инноваци	5.89	.69	5.82	.67	.494
Харилцааны үр чадвар	5.81	.63	5.82	.63	.176
Багаар ажилллах үр чадвар	5.98	.60	5.83	.65	.030
Тунгаан бодох үр чадвар	5.92	.66	5.79	.69	.017
Өсөн дэвших сэтгэлгээ	6.04	.63	6.03	.68	.498
Энтрепренерийн сэтгэлгээ	5.97	.63	5.88	.58	.357

Дээрхийн адилаар өөрийн үнэлгээний үр дүнгээс харахад эмэгтэй асран хамгаалагчийн оролцооноос шалтгаалсан ялгаатай байдал ажиглагдаагүй болов ч AV засвар хийсний дараа нийгэм, соёлыг танин мэдэх болон тунгаан бодох зэрэг үр чадварын үнэлгээний хувьд эмэгтэй асран хамгаалагчтай болон эмэгтэй асран хамгаалагчгүй сурагчдын хооронд ялгаатай байдал ажиглагдсан. Тохируулга хийсний дараа эмэгтэй асран хамгаалагчтай сурагчид дээрх үр чадваруудад өөрийгөө илүү өндрөөр үнэлэх хандлагатай байгаа нь харагдаж байна (Хүснэгт 55-д харуулав).

Хүснэгт 55. AV засварласан оноо, Эмэгтэй асран хамгаалагчийн оролцоогоор

AV засвартай оноо	Эмэгтэй асран хамгаалагч байгаа		Эмэгтэй асран хамгаалагч байхгүй		P value
	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	5.69	.64	5.11	.50	.029
Тунгаан бодох үр чадвар	5.82	.66	5.59	.72	.047

Хүснэгт 56-аас харахад зөвхөн өөрийн үнэлгээнд суурилсан суурь судалгааны үнэлгээгээр хяналтын болон үндсэн бүлгүүдийн хооронд ESEL үр чадвар болон сэтгэлгээний хувьд ямар нэг статистик ялгаа илрээгүй. Гэвч AV тохируулга хийсний дараа үндсэн бүлгийн сурагчид хяналтын бүлэгтэй харьцуулахад нийгэм, соёлыг танин мэдэх, багаар ажиллах, тунгаан бодох зэрэг үр чадваруудад илүү ахицтай байсан нь тодорхой болсон. Энэ нь уг төсөл оролцогчдын эдгээр чухал үр чадваруудад эергээр нөлөөлсөн ба үндсэн бүлгийн оролцогчдын асуудал шийдвэрлэх, дүн шинжилгээ хийх болон шийдвэр гаргах чадварууд ахицтай байсныг харуулж байна.

Хүснэгт 56. AV засварласан оноо, бүлгээр

AV засвартай оноо	Хяналтын бүлэг		Үндсэн бүлэг		Р утга
	Дундаж утга	Стандарт хазайлт	Дундаж утга	Стандарт хазайлт	
Өөрийгөө танин мэдэх	6.0	.74	6.00	.73	.465
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	5.70	.64	5.79	.63	.047
Бүтээлч байдал ба инноваци	5.93	.65	6.00	.67	.057
Харилцааны үр чадвар	5.80	.63	5.83	.63	.197
Багаар ажилллах үр чадвар	5.80	.60	5.99	.65	.050
Тунгаан бодох үр чадвар	5.52	.66	5.82	.69	.026
Өсөн дэвших сэтгэлгээ	6.04	.65	6.13	.68	.416
Энтрепренерийн сэтгэлгээ	5.76	.62	5.88	.62	.295

Эцэст нь дүгнэхэд AV засварласан оноо нь ESEL үр чадвар болон сэтгэлгээний үнэлгээнд хэд хэдэн чухал үзүүлэлтүүдийг ил болголоо. Vignette-ийн эрэмбэлэл нь тэнцвэрт байдлыг баталж, төрөл бүрийн нөхцлүүдийг харьцуулахад найдвартай байдлыг хангаж байна. Эхний шатны үнэлгээнд хүйсийн ялгаа нь нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, багаар ажиллах үр чадвар, тунгаан бодох үр чадвар, харилцааны үр чадвар болон энтрепренерийн сэтгэлгээнд ажиглагдсан. Гэвч AV аргаар оноог засварласнаар эдгээр хазайлтыг багасгаж, эмэгтэй сурагчид нийгэм, соёлыг танин мэдэх үр чадварт илүү өндөр үнэлгээтэй байсан нь тэдний нийгмийн мэдрэмж, хүндлэл өндөр байгааг илтгэж байна.

Сургуулийн төрлийн хувьд суурь үнэлгээний үр дүнгээр ялгаатай байдал ажиглагдаж байсан ч AV засварын дараа эдгээр ялгаа арилсан нь уг арга сургалтын орчноос хамааралгүй шударга үнэлэхэд тохиромжтой гэдэг нь харагдсан.

Эрэгтэй асран хамгаалагчийн оролцооноос шалтгаалсан ялгаа суурь үнэлгээнд ажиглагдаагүй ч, AV онооны дараа өөрийгөө танин мэдэх, багаар ажиллах үр чадвар, тунгаан бодох үр чадвар зэрэгт ялгаа бий болсон бөгөөд эрэгтэй асран хамгаалагчтай сурагчид өөрийгөө илүү өндрөөр үнэлсэн байв. Харин эцэг, эрэгтэй асран хамгаалагчийн боловсролын түвшин нь зөвхөн багаар ажиллах үр чадвар дээр ялгаа харуулсан ба боловсролгүй эцэг/эрэгтэй асран хамгаалагчтай сурагчид хамгийн бага оноотой байсан. Эцэг/эрэгтэй асран хамгаалагчийн ажил мэргэжил нь ESEL үр чадварт нөлөөлөөгүй байна. Эмэгтэй асран хамгаалагчийн хувьд суурь үнэлгээний оноонд ялгаа ажиглагдаагүй боловч AV засварын дараа нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, тунгаан бодох үр чадвар зэрэгт ялгаа гарч, эмэгтэй асран хамгаалагчтай сурагчид илүү өндрөөр үнэлдэг болох нь харагдсан.

Хяналтын болон үндсэн бүлгүүдийн өөрийн үнэлгээгээр ерөнхий ялгаа ажиглагдаагүй ч үндсэн бүлэг нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, багаар ажиллах үр чадвар болон тунгаан бодох үр чадварын

хувьд тодорхой ахицтай байсан нь хөтөлбөрийн эерэг нөлөөг баталж байна. Ерөнхийдөө эдгээр үр дүн нь AV аргаар тохируулга хийх нь ESEL үр чадвар болон сэтгэлгээний үнэлгээг илүү бодитой, хариултын алдаанаас ангид болгодгийг харуулж байна.

Энэхүү хэсэгт бид AV арга ашиглан тохируулга хийх аргачлалын зорилго, ач холбогдол болон дүн шинжилгээний сонирхолтой үзүүлэлтүүд, мөн хариултуудыг хэрхэн засварласан талаарх арга техникийг танилцууллаа.


3.3. Тодорхойлох статистик

Түүврийн бүтэц

Дүн шинжилгээг илүү нарийвчлан хийхийн тулд суурь болон эцсийн судалгаанд хоёуланд нь хамрагдсан сурагчдад анхаарал хандуулсан. Түүнчлэн энэхүү түүврийн хариултуудыг Anchoring Vignettes (AV) аргачлалаар засварласан болно.


Судалгаанд 13-19 насны (дундаж нас = 15.7) 785 оролцогч хамрагдсан ба үүнээс 39.4% буюу 309 нь эрэгтэй, 60.6% буюу 476 нь эмэгтэй байв.

Зураг 3. Оролцогчдын нас




Оролцогчдын 76% нь 13-16 настай. Хамгийн бага насны оролцогч нь 13 настай бол хамгийн ахмад нь 19 настай. Оролцогчдын насны медиан нь 15 нас байв.

Зураг 4. Оролцогчдын оршин суугаа байршил



Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 79.7% нь сумын төвд өөрийн гэрт эсвэл айлд амьдарч байсан. Мөн судалгаанд оролцогчдыг 56.1% нь эцэг эхийн хамт амьдардаг байв.

Зураг 5. Оролцогчдын засаг захиргаа



Судалгаанд төслийн зорилтот 5 аймаг болох Говьсүмбэр, Өвөрхангай, Завхан, Ховд, Сүхбаатар аймгуудын оролцогчид хамрагдсан.

Хүснэгт 57. Аймаг болон бүлэг

Бүлэг	Аймаг					Нийт
	Говьсүмбэр	Ховд	Өвөрхангай	Завхан	Сүхбаатар	
Хяналтын	25 (7.9%)	76 (24.1%)	92 (29.1%)	71 (22.5%)	52 (16.5%)	316
Үндсэн	31(6.6%)	183 (23.3%)	235 (29.9%)	184 (23.4%)	127 (16.2%)	467

Хүснэгт 58. Сургалтын статус болон аймаг

Бүлэг	Аймаг					Нийт
	Говьсүмбэр	Ховд	Өвөрхангай	Завхан	Сүхбаатар	
ESEL сургалтад хамрагдсан	30 (6.1%)	126 (25.9%)	146 (29.6%)	112 (22.7%)	79 (16%)	493
ESEL сургалтад хамрагдаагүй	26 (8.9%)	57 (19.5%)	89 (30.5%)	72 (24.7%)	48 (16.4%)	292

Table 59. Эцэг эхийн боловсрол, хувиар

Боловсрол	Эцгийн боловсрол		Эхийн боловсрол	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Бага сургууль (4/5-р анги төгссөн)	134	19.0	101	13.1
Дунд (8/9-р анги төгссөн)	152	21.5	131	17.0
Бүрэн дунд (10-12-р анги төгссөн)	290	41.0	341	44.2
Мэргэжлийн боловсрол	6	.8	10	1.3
Коллеж	7	1.0	17	2.2
Их сургууль	57	8.1	105	13.6
Бусад (жишээ нь, насан туршийн боловсролын төв)	1	.1	13	1.7
Боловсролгүй	10	1.4	54	7.0
Мэдэхгүй	50	7.1	101	13.1

Энэхүү хэсэгт бид дараагийн дүн шинжилгээнд ашиглах AV тохируулгатай шинэчилэн сайжруулсан өгөгдлийн тодорхойлох статистикийг авч үзлээ.

3.4. Хүчин төгөлдөр байдлын тест (Найдварт чанар, Хүчин зүйлийн шинжилгээ, Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ)

Кронбах Альфа шинжилгээний хариу
Хүснэгт 60. Кронбах Альфа найдварт чанарын статистик

	Найдварт чанар (Cronbach's alpha)
Энтрепренершипт суурилсан хувь хүний үр чадварын мэдлэг	0.625
ESEL үр чадвар ба сэтгэлгээ	0.895
Амьдралын хүсэл эрмэлзлэл	0.428

Уг статистик шинжилгээний үр дүнгээс харахад судалгаанд оролцогчдын энтрепренершипийн мэдлэг, ESEL үр чадвар болон сэтгэлгээг үнэлэх зорилготой хийсэн тоон судалгаа нь найдварт чанарын шалгуурт нийцэж байна. Гэхдээ Амьдралын хүсэл эрмэлзлэл сэдвийн асуултууд болон хариултууд нь судалгаанд оролцогчдод ойлгомжгүй байсан нь ажиглагдсан.

Хүчин зүйлийн шинжилгээ ба үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ

Хүснэгт 61. Хүчин зүйлийн шинжилгээ

	КМО болон Bartlett's Test
Энтрепренершипт суурилсан хувь хүний үр чадварын мэдлэг	.407 (Sig.= 000)
ESEL үр чадвар ба сэтгэлгээ	.922 (Sig.= 000)
Амьдралын хүсэл эрмэлзлэл	.629 (Sig.= 000)

Энтрепренершипт суурилсан хувь хүний үр чадварын мэдлэгийн асуулгын хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Бид Энтрепренершипийн суурь ойлголтын талаар асуултуудыг нэг бүлэгт хамаарах боломжтой эсэхийг шалгах зорилгоор гол буюу үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ (ҮБХ) ашиглан хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Үүний үр дүнгээс харахад асуултууд 11 бүлэгт хуваагдсан ба эдгээр нь анхдагч тоон мэдээллийн 61%-ийг эзэлж байгаа тул найдвартай шинжилгээ хийхэд хангалттай гэж үзсэн.


Хүснэгт 62. Энтрепренершилийн суурь ойлголт

Энтрeнepнepшuлuйн cууpь oйлгoлт (Асуулт, хариулт)		Бүрдэл хэсэг										
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Энтрeнepнep гэж хэн бэ?			0.577									
Аль нь нутгийнхаа иргэдэд үнэ цэнийг бүтээж буй үйл ажиллагаа вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Боломжийн үнэтэй, чанартай хоолны үйлчилгээ хүргэх					0.679						
	Дэлгүүрээ орой эрт хаах										0.682	
	Кофе шопдоо илүү олон төрлийн уух зүйлсээр үйлчлэх											
	Илүү олон найз нөхөдтэй болох											
	Бүтээгдэхүүн/үйлчилгээгээ илүү хүртэмжтэй болгох						-0.87					
Аль нь амжилттай энтрeнepнepийн шинж чанар вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Урам зоригтой	0.692										
	Эрсдэлтэй зүйл бараг хийдэггүй								0.633			
	Хүсэл тэмүүлэлтэй						0.825					
	Хөдөлмөрч						-0.73					
Аль нь энтрeнepнep хүний үүрэг вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Санхүүжилт босгох	0.657										
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зохион байгуулж, хэрэгжүүлэх			-0.57								0.77
	Шинэ ажлын байр бий болгох									0.716		
	Зах зээлийн өрсөлдөөнөөс зайлсхийх											
	Зорилгодоо хүрэхийн тулд ёс зүйгүй шийдвэр гаргахыг зөвшөөрөх			0.504								
Энэ зураг дээр ямар төрлийн бизнесийг харуулж байна вэ?											-0.53	
Аль нь таны бизнест эрсдэл болох вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Кафе ажиллуулах зөвшөөрөл авч чадахгүй байх					0.813						
	Цүнх оёход шаардагдах даавууны нийлүүлэлт багасах				0.643							
	Үйлчлүүлэгчдийн тоо өсөх			0.653								
	Дэлгүүрийнхээ өөр нэг салбарыг нээх хэрэгцээ гарах								0.887			
	Мэдэхгүй				0.569							
Хэрэв та рестораны эзэн бол таны өрсөлдөгч хэн бэ?												

Хүснэгт 63. Энтрепренершилийн суурь ойлголтын бүрдэл хэсэг

Бүрдэл хэсэг	Энтрпренер гэж хэн бэ?	Аль нь нутгийнхаа иргэдэд үнэ цэнийг бүтээж буй үйл ажиллагаа вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)			Аль нь амжилттай энтрпренерийн шинж чанар вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)				Аль нь энтрпренер хүний үүрэг вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)					Аль нь таны бизнесэст эрсдэл болох вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)				Хэрэв та нэвтрүүлсэн эзэн бол таны өрсөлдөгч хэн бэ?	
		Боломжийн үнэтэй чанартай үйлчилгээ хүргэх	Дэлгүүрээ орой эрт хаах	Бүтээгдэхүүн/үйлчилгээгээ илүү хүртээмжтэй болгох	Урам зоригтой	Эрсдэлтэй зүйлс бараг хийдэггүй	Хүсэл тэмүүлэлтэй	Хөдөлмөрч	Санхүүжилт босгох	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг зохион байгуулж, хэрэгжүүлж	Шинэ ажлын байр бий болгох	Зах зээлийн өрсөлдөөнөөс зайлсхийх	Зорилгодоо хүрэхийн тулд ёс зүйгүй шийдвэр гаргалайг зөвшөөрөх	Энэ зураг дээр ямар төрлийн бизнесийг хариулж байна вэ?	Кафе ажиллуулах зөвшөөрөл авч чадахгүй байх	Цүнх өсөхөд шаарагдах даавуучин нийлүүлэлт багасах	Үйлчилүүлэгчидийн тоо өсөх		Дэлгүүрийнхээ өөр нэг салбарыг нээх хэрэгцээ гарах
1																			
2																			
3														Урвуу хамаарал					
4																			
5																			
6								Урвуу хамаарал											
7																			
8																			
9																			
10																			
11																			


Зураг 6. Скри график, Эргүүлэлтийн матриц (Энтрепренершипийн суурь ойлголт)



Үр дүнгээс харахад энтрепренерүүдийн урам зориг ба хөрөнгө босгохтой холбоотой асуултууд нэг бүлэгт хамаарч болохоор байгаа бол зорилгодоо хүрэхийн тулд ёс зүйгүй шийдвэр гаргах болон хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэхтэй холбоотой асуултууд нь өөр өөр бүлэгт хамаарч байна. Энэ нь дээрх асуултуудын хоорондын хамаарал сул байгаа ба нэг ойлголтыг бүрэн илэрхийлэх зорилгыг хангаж чадахгүй гэдгийг илэрхийлж байна.

Бизнес төлөвлөлт болон Санхүүгийн мэдлэгийн талаарх асуултуудыг нэг бүлэгт багтааж болох эсэхийг тодруулахын тулд гол бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ хийсэн. Үр дүнгээс харахад эдгээр асуултууд 4 бүлэгт хуваагдаж байгаа ба нийтдээ түүхий өгөгдлийн 58%-ийг эзэлж байгаа нь найдвартай шинжилгээ хийхэд хангалттай юм.

Зураг 7. Скри график, Эргүүлэлтийн матриц (Бизнес төлөвлөлт ба Санхүүгийн мэдлэг)




Хүснэгт 64. Бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэгийн бүрэлдэхүүн хэсэг

Бизнес төлөвлөлт болон санхүүгийн мэдлэг		Бүрэлдэхүүн			
		1	2	3	4
Бизнес төлөвлөгөө гэж юу вэ?		.517			
Танд яагаад бизнес төлөвлөгөө хэрэгтэй вэ?		.705			
Бизнес төслийн төлөвлөгөөнд юуг оруулах ёстой вэ?		.714			
Бизнесийн үйл ажиллагаандаа санхүүгийн бүртгэлээ үнэн зөв бүртгэхийн давуу талууд нь юу вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Ашиг, орлого, алдагдлаа тооцоолох		.839		
	Ажилтны цалин хөлсийг тодорхойлох			.697	
	Шинэ тоног төхөөрөмж худалдаж авч чадахаа тооцоолох			.778	
	Илүү их бүтээгдэхүүн зарж борлуулах				.836

Үр дүнгээс харахад санхүүгийн бүртгэлийг үнэн зөв хөтлөхийн ач холбогдол, ажилчдын цалинг тооцоолох болон шинэ тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой анхдагч 3 асуулт нэг бүлэгт багтсан байгаа нь эдгээр асуултууд харилцан уялдаатай, судалгааны зорилготой нийцэж байгааг илтгэж байна.

Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгсэл зэрэг сэдвүүдийн хувьд мөн гол бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ хийж эдгээр асуултуудыг нэгтгэж болох эсэхийг шалгасан. Шинжилгээний үр дүнгээр дээрх асуултууд тусдаа 4 бүлэгт хуваагдсан ба нийт түүхий өгөгдлийн 61%-ийг эзэлж байсан тул найдвартай шинжилгээ хийхэд хангалттай гэж үзсэн.

Зураг 8. Скри график, Эргүүлэлтийн матриц (Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгсэл)



Хүснэгт 65. Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгслийн бүрэлдэхүүн хэсэг

Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгсэл		Бүрэлдэхүүн			
		1	2	3	4
Доорх нөөцөөс танд аль нь цайны газар ажиллуулахад хэрэг болох вэ?					.614
Аль нь олон нийтийн хангагдаагүй хэрэгцээг судлах үр дүнтэй арга вэ?				.745	
Зардлын тооцооллыг хийхэд хамгийн тохиромжтой програм аль нь вэ?				.681	
Фэйсбүүк, Инстаграм, Тик Ток зэрэг олон нийтийн сүлжээг (сошиал медиа) та бизнестээ ашиглах нь ямар давуу талуудтай вэ? (Зөв хариулт бүрийг сонгоно уу)	Бизнесээ сурталчлах	-.737			
	Хөгжилтэй бичлэг үзэх				.743
	Маркетингийн зардлаа багасгах			.756	
	Ашгаа тооцоолох			.592	

Эдгээр үр дүнгээс харахад асуултууд хоёр үндсэн бүлэгт хуваагдаж байгаа ба нэг асуулт сөрөг хамааралтай байв. Уг тохиолдлыг эс тооцвол бүлэг доторх асуултууд хоорондын уялдаа хамаарал хангалттай сайн байгаа тул асуултын ерөнхий бүтэц нь зорилтот дүн шинжилгээ хийхэд найдвартай болохыг илэрхийлж байна.

ESEL үр чадвар ба сэтгэлгээний асуулгын хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

8 хэсгээс бүрдэх ESEL үр чадвар болон сэтгэлгээний асуулгад хийсэн хүчин зүйлийн шинжилгээнээс харахад хэсэг тус бүр түүхий өгөгдлийн 30-аас дээш хувийг эзэлж байгаа тул нийгмийн асуудлыг шинжлэх регрессийн шинжилгээний зөвшөөрөгдөх түвшинд хүрсэн гэж үзэж байна. Асуулгын хэсэг бүр тусдаа бүлэг болсон нь тухайн бүлэг доторх асуултууд хоорондын уялдаа холбоо болон нийцтэй байдал сайн байсныг харуулж байна. Энэ нь судалгаанд оролцогчид асуултыг зохих ёсоор ойлгож, хариулсан гэдгийг илтгэж байна. Иймд ESEL үр чадвар ба сэтгэлгээний асуулга нь судалгааны зорилгод нийцсэн найдвартай тоон мэдээллийг амжилттай цуглуулсан гэж дүгнэж болно.

Хүснэгт 66. Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээний үр дүн

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Гол бүрдүүлэгчийн ачаалалсан (хуримтлагдсан хувь)	Бүрдэл	Ялгах арга: Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ
Өөрийгөө танин мэдэх	30.6	1	0.536
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	32.2	1	0.565
Бүтээлч байдал ба инноваци	36.7	1	0.605
Харилцааны үр чадвар	31.2	1	0.556
Багаар ажилллах үр чадвар	37.2	1	0.606
Тунгаан бодох үр чадвар	38.1	1	0.608
Өсөн дэвших сэтгэлгээ	32.9	1	0.573
Энтрепренерийн сэтгэлгээ	34.9	1	0.589

Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнгээс харахад Зорьсон зорилго ба боломжууд хэсгийн 2 болон 6 дугаар асуултаас бусад ихэнх асуултуудыг нэг бүлэгт нэгтгэж болох ба уг хоёр асуулт бусад асуулттай нягт уялдаагүй буюу тухайн бүлгийн агуулгатай хангалттай нийцэхгүй байж болзошгүйг харуулж байна. Асуултуудын хамаарлын дундаж 0.539 байсан нь бүлэг доторх асуултууд дунд зэргийн нийцтэй гэсэн үг юм. Гэсэн хэдий ч 1 дүгээр асуулт сөрөг хамааралтай байснаас үзэхэд уг асуулт бусад асуулттай уялдаагүй байх магадлалтай.

Бие даах чадвар ба төлөвшил хэсгийн асуултуудын хувьд хамаарлын дундаж 0.575 байсан ба нэг бүлэгт нэгтгэх боломжтой байна. Энэ нь тухайн хэсгийн асуултууд хоорондын уялдаа хамаарал, нийцтэй байдал харьцангуй сайн байгаа ба найдвартай, зорилгодоо нийцсэн гэдгийг илтгэж байна.

Хүснэгт 67. Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

	Гол бүрдүүлэгчийн ачаалалсан (хуримтлагдсан хувь)	Бүрдэл	Ялгах арга: Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ
Зорьсон зорилго ба боломжууд (3,4,5-р асуултуудыг нэг бүлэг болгон нэгтгэсэн)	20.4	1	0.539
Өөрийн чадварт итгэх байдал	34.9	1	0.575

Найдварт чанарын статистик шинжилгээний үр дүн: Дүгнэлт

Кронбах Альфа болон Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ ашигласан шинжилгээний үр дүнгээс харахад ESEL үр чадвар болон сэтгэлгээний асуулгаар цуглуулсан тоон мэдээллийн найдварт чанар хангалттай өндөр байна. Мөн энтрепренершипд суурилсан хувь хүний үр чадварын мэдлэг болон Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хэсэгтэй холбоотой тоон өгөгдөл нь найдвартай. Эдгээр үр дүнгээс харахад уг судалгаагаар зорилтот үнэлгээг үр дүнтэй хийснээс гадна цаашдын дүн шинжилгээнд ашиглах найдвартай өгөгдлийг цуглуулж чадсан байна.

Энэхүү хэсэгт Кронбах Альфа, Хүчин зүйлийн шинжилгээ болон Үндсэн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээг ашиглан найдварт чанарыг судлан, үр дүнг тайлагнав.



Бүлэг 4.

ХАРЬЦУУЛСАН ДҮН ШИНЖИЛГЭЭ

4.1. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт

Дүн шинжилгээнд хяналтын бүлгийн 316 оролцогч болон үндсэн бүлгийн 467 оролцогчийн өгөгдлийг ашигласан. Шударга байдлыг хангах үүднээс үндсэн бүлэгт дахин түүвэрлэлт хийн гурван хүн тутмын нэгийг хасаж, хяналтын бүлэгтэй адил 316 оролцогчийг хамруулсан. Үүний дараа суурь болон эцсийн судалгааны үр дүнг харьцуулав.

ESEL мэдлэгийн үр дүн


ESEL мэдлэгийн хувьд суурь болон эцсийн судалгааны хооронд статистик шинжилгээ хийхэд ач холбогдол бүхий ялгаа харагдсан ба сургалтын дараа ESEL мэдлэг эрс сайжирсан байв ($U = -21.53$; $p < 0.01$). ESEL мэдлэгийн тархалт хэвийн бус ($p < 0.000$) байсан тул Mann-Whitney U тестээр ялгааг шинжилсэн ба үр дүнгээс харахад тухайн сургалт ESEL-ийн мэдлэгт ихээхэн эерэг нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 68. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (ESEL мэдлэг)

ESEL мэдлэг	Бүлэг	Дундаж	Mann-Whitney U	P утга
Энтрепренершипийн тухай суурь ойлголт	Суурь	2.22	-21.532	0.000
	Эцсийн	6.88		
Бизнес төлөвлөлт ба санхүүгийн мэдлэг	Суурь	1.77	-17.448	0.000
	Эцсийн	3.17		
Нөөцийг үр ашигтай хуваарилах, төлөвлөгөө хэрэгжүүлэх, дижитал хэрэгсэл	Суурь	0.91	-15.318	0.000
	Эцсийн	1.99		
ESEL мэдлэг	Суурь	4.90	-21.535	0.000
	Эцсийн	12.04		


Дараах графикт ESEL мэдлэгийн суурь болон эцсийн судалгааны үр дүнг хүйсээр харьцуулан харуулав.

Зураг 9. ESEL мэдлэгийн дундаж оноо, хүйсээр



Эцсийн судалгааны үр дүнгээс харахад эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын ESEL мэдлэг статистик ач холбогдол бүхий ялгаатай байсан. Эмэгтэй оролцогчдын дундаж оноо ($M = 12.5$) эрэгтэй оролцогчдын дундаж онооноос ($M = 11.3$) илүү өндөр байсан ба р-утга нь 0.000 байсан нь ESEL мэдлэг эзэмшихэд жендэр чухал үүрэг гүйцэтгэдэг гэдгийг харуулж байна.

Зураг 10. ESEL мэдлэгийн дундаж оноо, насаар



Эцсийн судалгааны үр дүнгээр ESEL мэдлэгийн хувьд хоёр насны бүлэг хооронд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. 16-19 насны оролцогчид ($M=12.6$) 13-15 насны оролцогчдоос ($M=11.6$) илүү өндөр оноотой байсан ба p -утга нь 0.001 байв. Сонирхолтой нь суурь судалгаанд энэхүү ялгаа ажиглагдаагүй бөгөөд энэ нь арай ахмад настай оролцогчид сургалтаас илүү их ашиг тус хүртсэн болохыг харуулж байна.

ESEL үр чадвар болон сэтгэлгээний үр дүн


ESEL үр чадвар болон сэтгэлгээний үр дүн нь оролцогчид ESEL сургалтын дараа мэдэгдэхүйц сайжирсныг харуулж байна. Суурь болон эцсийн судалгааны үр дүнг харьцуулан үзэхэд ерөнхийдөө оролцогчдын ESEL Үр чадвар болон сэтгэлгээ сайжирсан байна ($U = -2.419$; $p < 0.05$). ESEL мэдлэгийн тархалт хэвийн бус ($p < 0.000$) байсан тул Mann-Whitney U тестийг ашигласан.

Бусад дүн шинжилгээнүүд оролцогчдын нийгэм, соёлыг танин мэдэх үр чадвар, бүтээлч байдал ба инноваци болон харилцааны үр чадвар сургалтын дараа мэдэгдэхүйц сайжирч байгааг харуулсан нь ESEL сургалт эдгээр үр чадваруудад эерэг нөлөө үзүүлсэн болохыг баталж байна.

Хүснэгт 69. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (ESEL үр чадвар ба сэтгэлгээ)

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Бүлэг	Дундаж	Mann-Whitney U	P утга
Өөрийгөө танин мэдэх	Суурь	2.09	-.014	0.989
	Эцсийн	2.11		
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	Суурь	1.97	-4.784	0.000
	Эцсийн	1.86		
Бүтээлч байдал ба инноваци	Суурь	2.13	-2.629	0.009
	Эцсийн	2.08		
Харилцааны үр чадвар	Суурь	2.18	-4.493	0.000
	Эцсийн	2.09		
Харилцааны үр чадвар	Суурь	1.94	-.797	0.425
	Эцсийн	1.95		
Тунгаан бодох үр чадвар	Суурь	1.98	-.781	0.435
	Эцсийн	2.01		
Өсөн дэвших сэтгэлгээ	Суурь	1.77	-.257	0.797
	Эцсийн	1.79		
Энтрепренерийн сэтгэлгээ	Суурь	1.69	-.024	0.981
	Эцсийн	1.72		
ESEL үр чадвар ба сэтгэлгээ	Суурь	3.67	-2.419	0.016
	Эцсийн	1.95		

Зураг 11. ESEL үр чадвар ба сэтгэлгээ, хүйсээр



Суурь судалгааны үр дүнгээс харахад эмэгтэй оролцогчдын ESEL үр чадвар болон сэтгэлгээний оноо ($M=1.9$) эрэгтэй оролцогчдын онооноос ($M=2.0$) өндөр байсан ба ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан ($p=0.006$). Гэхдээ сургалтад хамрагдсаны дараа уг ялгаа байхгүй болсон байна. Түүнчлэн эцсийн судалгааны үр дүнгээр насны бүлгүүдийн хооронд мөн ялгаа ажиглагдаагүй.

Амьдралын хүсэл эрмэлзлэлийн үр дүн


Амьдралын хүсэл эрмэлзлэл хэсгийн дүн шинжилгээ үндсэн бүлгийн оролцогчид сургалтанд хамрагдсаны дараа мэдэгдэхүйц сайжирсан болохыг харуулж байна. Тодруулбал сургалт дууссаны дараа Амьдралын хүсэл эрмэлзлэл хэсгийн оноо сайжирсан байна ($U = -6.721$; $p < 0.001$; $M_{\text{суурь}} = 1.9$, $M_{\text{эцсийн}} = 1.7$).

Түүнчлэн Амьдралын хүсэл эрмэлзлэл хэсгийг үзүүлэлт бүрээр нягтлан үзэхэд Хүсэж буй зорилго болон боломжуудын оноо мэдэгдэхүйц өссөн байгаа нь оролцогчид сургалтанд хамрагдсаны дараа ирээдүйн зорилго болон боломжийг илүү өөдрөгөөр харах болсныг илтгэж байна.

Хүснэгт 70. Суурь болно эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт (Амьдралын хүсэл эрмэлзлэл)

ESEL мэдлэг	Бүлэг	Дундаж	Mann-Whitney U	P утга
Зорьсон зорилго ба боломжууд	Суурь	1.9	-15.489	0.000
	Эцсийн	1.5		
Өөрийн чадварт итгэх байдал	Суурь	1.8	-4.889	0.000
	Эцсийн	1.9		
Амьдралын хүсэл эрмэлзлэл	Суурь	1.9	-6.721	0.000
	Эцсийн	1.7		

Зураг 12. Амьдралын хүсэл эрмэлзлэл, хүйсээр



Суурь судалгааны үр дүнгээс харахад Амьдралын хүсэл эрмэлзлэл хэсэгт эмэгтэй оролцогчид ($M = 1.8$) эрэгтэй оролцогчдоос ($M = 1.9$) илүү өндөр оноотой байсан. Гэхдээ сургалтад хамрагдсаны дараа Амьдралын хүсэл эрмэлзлэл нийтлэгээрээ сайжирч, хүйсийн ялгаа байхгүй болсон нь эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын аль аль нь сургалтын үр шимийг тэгш хүртсэн болохыг илэрхийлж байна.

4.2. ESEL үр чадварын дүн шинжилгээ (AV ашигласан өөрийн үнэлгээний оноо)

Anchoring Vignettes аргыг ашиглан хийсэн статистикийн шинжилгээнд дараах ялгаанууд ажиглагдсан:


- **Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар:** Үндсэн бүлгийн оролцогчид хяналтын бүлгээс илүү сайн үзүүлэлттэй байсан ($U = 45120$; $p = 0.027$; $M_{\text{үндсэн}} = 3.0$, $M_{\text{хяналт}} = 3.2$).
- **Харилцааны үр чадвар:** Мөн үндсэн бүлгийн оролцогчид хяналтын бүлгээс илүү сайн үзүүлэлттэй байсан ($U = 44816$; $p = 0.017$; $M_{\text{үндсэн}} = 2.9$, $M_{\text{хяналт}} = 3.1$).
- **Өсөн дэвших сэтгэлгээ:** Үндсэн бүлгийн оролцогчид хяналтын бүлгээс илүү сайн үзүүлэлттэй байсан ($U = 46221$; $p = 0.092$; $M_{\text{үндсэн}} = 2.8$, $M_{\text{хяналт}} = 2.9$).
- **Тунгаан бодох үр чадвар:** Сонирхолтой нь хяналтын бүлэг үндсэн бүлгээс илүү сайн үзүүлэлттэй байсан ($U = 45979$; $p = 0.073$; $M_{\text{үндсэн}} = 2.5$, $M_{\text{хяналт}} = 2.3$).

ESEL ESEL үр чадварууд болон сэтгэлгээний үзүүлэлтүүдэд урвуу хэмжигдэхүүнийг ашигласан тул бага оноо нь илүү сайн үр дүнг илтгэнэ.

Хүснэгт 71. ESEL үр чадвар болон сэтгэлгээний AV тохируулгатай онооны үр дүн, бүлгээр

ESEL үр чадвар, сэтгэлгээ	Бүлэг	Дундаж	Mann-Whitney U	P утга
Өөрийгөө танин мэдэх	Хяналт	2.7	47829	0.342
	Үндсэн	2.8		
Нийгэм соёлыг танин мэдэх үр чадвар	Хяналт	3.2	45190	0.027
	Үндсэн	3.0		
Бүтээлч байдал ба инноваци	Хяналт	3.1	49228.5	0.742
	Үндсэн	3.1		
Харилцааны үр чадвар	Хяналт	3.1	44816	0.017
	Үндсэн	2.9		
Багаар ажилллах үр чадвар	Хяналт	2.5	48821.5	0.595
	Үндсэн	2.5		
Тунгаан бодох үр чадвар	Хяналт	2.3	45979	0.073
	Үндсэн	2.5		
Өсөн дэвших сэтгэлгээ	Хяналт	2.9	46221	0.092
	Үндсэн	2.8		
Энтрепренерийн сэтгэлгээ	Хяналт	2.5	47248	0.225
	Үндсэн	2.6		

Зураг 13. Харилцааны үр чадвар болон тунгаан бодох үр чадвар, хүйсээр



Харилцааны үр чадвар

Дүгнэлт

Үндсэн бүлгийн оролцогчдын суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалт нь тэдний ESEL мэдлэг, ур чадвар, амьдралын зорилго болон амьдралд хандах өөдрөг үзэл мэдэгдэхүйц сайжирсныг харуулж байна.

- ESEL мэдлэгийн хувьд эмэгтэй оролцогчид болон 16-19 насны оролцогчид өндөр үзүүлэлттэй байв.
- Амьдралын зорилго болон ESEL ур чадварын хувьд суурь судалгаагаар хүйсийн ялгаа ажиглагдсан. Гэхдээ сургалтад хамрагдсаны дараа энэ ялгаа буурч, ур чадварын түвшин болон амьдралын зорилгын үзүүлэлтүүд бүх бүлэгт сайжирсан.

Мөн AV-засварласан оноог ашиглан ESEL ур чадварт дүн шинжилгээ хийхэд үндсэн бүлгийн оролцогчид нийгэм, соёлыг танин мэдэх ур чадвар, харилцааны ур чадвар, өсөн дэвших сэтгэлгээ зэрэг хэсгүүдэд хяналтын бүлгээс илүү өндөр үзүүлэлттэй байсан.

Дээрх үр дүнгүүд тус сургалт нь гол ур чадварыг сайжруулахад, мөн оролцогчдын амьдралын зорилгод хандах үзэл бодол өөрчлөгдөхөд хэрхэн нөлөөлснийг харуулж байна.

Энэхүү хэсэгт AV тохируулгатай суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн гол үзүүлэлтүүдийг танилцууллаа.

4.3. Регрессийн шинжилгээ

ESEL ур чадвар болон сэтгэлгээнд нөлөөлөх янз бүрийн хүчин зүйлсийг үнэлэх зорилгоор регрессийн шинжилгээ хийсэн. Энэхүү шинжилгээнд хамаарах хувьсагч нь **ESEL ур чадвар ба сэтгэлгээ** байсан бол үл хамаарах хувьсагчид нь дараах байв:

- Үндэстэн ястан
- Оршин суугаа газар
- ESEL сургалтад хамрагдсан эсэх
- Амьдралын хүсэл эрмэлзлэл
- Эцэг эхтэйгээ амьдардаг эсэх
- Эцгийн боловсрол
- Эхийн боловсрол
- Нас
- Хүйс
- Сум (оршин байгаа нутаг)
- ESEL мэдлэг
- Аймаг (бүс нутаг)
- Үндсэн болон хяналтын бүлэг

Энэхүү шинжилгээний зорилго нь ESEL үр чадвар, сэтгэлгээг хөгжүүлэхэд дээрх хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох мөн эдгээр хувьсагчид болон үр дүн хоорондын ерөнхий хамаарлыг судлах байв. Шинжилгээний үр дүн нь хүн ам зүйн болон бусад холбогдох хувьсагчдыг тохируулсны дараа оролцогчдын үр чадвар, сэтгэлгээг төлөвшүүлэхэд хүчин зүйл бүрийн нөлөөллийг ойлгох боломжийг бидэнд олгоно.

Хүснэгт 72. Регрессийн тооцоолол болон загварын хураангуй

Загварын хураангуй ^a				
Загвар	R	R квадрат	Тохируулсан R квадрат	Std. Тооцооллын алдаа
1	.519 ^a	.270	.255	.288966264
a. Үл хамаарах хувьсагч: (Тогтмол) угсаатны бүлэг, нас, аймаг, эцэг эхтэйгээ амьдардаг эсэх, амьдралын хүсэл эрмэлзлэл, эцгийн боловсрол, эхийн боловсрол, хүйс, оршин суугаа байршил, сум, ESEL мэдлэг, сургалтын статус				
b. Хамаарах хувьсагч: Үр чадвар ба сэтгэлгээ				

- ESEL үр чадвар ба сэтгэлгээ болон дараах үзүүлэлтүүдийн **хоорондын хамаарал**: Оршин суугаа газар, ESEL сургалтад хамрагдсан эсэх, амьдралын хүсэл эрмэлзлэл, эцэг эхтэйгээ хамт амьдардаг эсэх, эцгийн боловсрол, эхийн боловсрол, нас, хүйс, сум, ESEL мэдлэг, аймаг, хяналтын эсвэл үндсэн бүлэг гэх мэт үзүүлэлтүүдийн хоорондын хамаарал 0.519 байна. Энэ нь дунд зэргийн хамааралтай байгааг илтгэж байгаа бөгөөд эдгээр хүчин зүйлс нь хамтаараа ESEL үр чадвар ба сэтгэлгээний төлөвшилд нөлөөлж байгааг харуулж байна.
- **ANOVA шинжилгээний** үр дүнгээр ($F = 18.343$, $P = 0.000$) үл хамаарах хувьсагчид нь ESEL үр чадвар болон сэтгэлгээнд статистикийн хувьд ач холбогдолтой нөлөө үзүүлж байгаа нь нотлогдсон ба энэ нь эдгээр хувьсагчид тухайн үр чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй болохыг илтгэж байна.
- **R Square = 0.270** буюу тухайн загварт ашигласан үл хамаарах хувьсагчид ESEL үр чадвар болон сэтгэлгээний өөрчлөлтийн 27 хувийг тайлбарлаж байгаа ба эдгээр хүчин зүйлс тодорхой хэмжээнд чухал хэдий ч бусад хэмжигдээгүй хүчин зүйлс мөн төлөвшилд нөлөөлж болохыг харуулж байна.

Хүснэгт 73. Регрессийн шинжилгээ, ANOVA

ANOVA ^a						
Загвар		Sum of Squares	df	Дундаж квадрат	F	Sig.
1	Регресс	16.848	11	1.532	18.343	.000 ^b
	Үлдэгдэл	45.592	546	.084		
	Нийт	62.440	557			
a. Хамаарах хувьсагч: ESEL үр чадвар, сэтгэлгээ						
b. Үл хамаарах хувьсагч: (Тогтмол) угсаатны бүлэг, нас, аймаг, эцэг эхтэйгээ амьдардаг эсэх, амьдралын хүсэл эрмэлзлэл, эцгийн боловсрол, эхийн боловсрол, хүйс, оршин суугаа байршил, сум, ESEL мэдлэг, сургалтын статус						

Хүснэгт 74. Регрессийн шинжилгээ, Коэффициентүүд

Коэффициентүүд ^a					
Загвар		Стандартчилаагүй коэффициентүүд		t	Sig.
		B	Std. Error		
1	(Тогтмол утга)	1.802	.211	8.547	.000
	Амьдарч буй байршил	-.004	.008	-.498	.619
	ESEL сургалтын статус	-.021	.030	-.715	.475
	Амьдралын хүсэл эрмэлзлэл	.398	.034	11.635	.000
	Эцэг, эхтэйгээ амьдардаг	.040	.026	.058	.122
	Эцгийн боловсрол	-.003	.007	-.018	.673
	Эхийн боловсрол	.009	.007	.061	.166
	Хүйс	-.019	.026	-.028	.453
	Нас	-.021	.011	-.073	.052
	ESEL мэдлэг	-.019	.004	-5.396	.000
	Аймаг	.015	.011	.053	.161
	Угсаатны бүлэг	-.018	.030	-.610	.542
a. Хамаарах хувьсагч : ESEL үр чадвар ба сэтгэлгээ					

Регрессийн шинжилгээний үр дүнд дараах тэгшитгэл гарсан ба энэ нь ESEL үр чадвар болон сэтгэлгээний оноог урьдчилан таамаглахад ашиглагдана:

ESEL Үр чадвар, Сэтгэлгээ = 1.802 - 0.019 * (ESEL мэдлэг) + 0.398 * (Амьдралын хүсэл эрмэлзлэл) - 0.021 * (Нас)

Коэффициентүүдийн тайлбар:

- **ESEL мэдлэг:** ESEL мэдлэг 1 нэгжээр нэмэгдэхэд ESEL Үр чадвар, Сэтгэлгээний оноо 0.019-р буурна. Энэ нь ESEL мэдлэг өндөр байх тусам үр чадвар, сэтгэлгээ сайжирдаг болохыг харуулж байна.
- **Амьдралын хүсэл эрмэлзлэл:** Амьдралын хүсэл эрмэлзлэлийн оноо нэг нэгжээр нэмэгдэхэд ESEL үр чадвар, сэтгэлгээний оноо

0.398 нэгжээр нэмэгддэг. Энэ нь амьдралын хүсэл эрмэлзлэл өндөр байх тусам сэтгэлгээ болон үр чадвар сайжирдаг болохыг харуулж байна.

- **Нас:** Нас нэгээр нэмэгдэхэд ESEL үр чадвар, сэтгэлгээний оноо 0.021 нэгжээр буурдаг. Энэ нь насаар ах оролцогчид ESEL үр чадвар, сэтгэлгээний оноо бага байх магадлалтайг харуулж байна.
- ESEL мэдлэг болон амьдралын хүсэл эрмэлзлэл нь ESEL үр чадвар, сэтгэлгээнд эерэгээр нөлөөлдөг бол нас нь бага зэрэг сөрөг нөлөөтэй байна. Учир нь ESEL үр чадвар, сэтгэлгээний **оноо бага байх тусам сайн үр дүнг илтгэхээр кодлосон** тул мэдлэг болон тэмүүлэл нэмэгдэхийн хэрээр ESEL сэтгэлгээ сайжирдаг байна.

Энэхүү хэсэгт регрессийн шинжилгээний үйл явц болон үр дүнг танилцууллаа.

4.4. Өгөгдлийн шинжилгээний дүгнэлт

- **ESEL мэдлэгийн ахиц:** ESEL мэдлэгийн хувьд үндсэн болон хяналтын бүлэг хооронд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. ESEL сургалтын хөтөлбөрт хамрагдсан оролцогчид хамрагдаагүй оролцогчдоос илүү өндөр ESEL мэдлэгтэй байсан.
- **Амьдралын хүсэл эрмэлзлэл, ESEL Үр чадвар, сэтгэлгээнд ялгаа байгаагүй:** Үндсэн болон хяналтын бүлгүүдийн хооронд Амьдралын хүсэл эрмэлзлэл, ESEL үр чадвар болон сэтгэлгээний хувьд ялгаа ажиглагдаагүй. Энэ нь сургалт эдгээр хэсгүүдэд шууд нөлөө үзүүлээгүй гэсэн үг юм. Гэхдээ ESEL мэдлэгийн ахиц ажиглагдсан хэвээр байв.
- **ESEL үр чадвар, сэтгэлгээнд үзүүлэх нөлөө:**
 - **ESEL мэдлэг болон нас** нь ESEL үр чадвар болон сэтгэлгээг сайжруулахад эерэг нөлөө үзүүлсэн буюу насаар ах болон илүү ESEL мэдлэгтэй оролцогчдын сэтгэлгээ болон үр чадвар илүү сайжирсан гэсэн үг юм.
 - **Амьдралын хүсэл эрмэлзлэл** нь ESEL үр чадвар болон сэтгэлгээнд сөрөг нөлөөтэй байсан ба энэ нь хүлээлт өндөртэй хүүхэд, залуус өөрсдийн үр чадварт илүү өндөр шаардлага тавьж, өөрсдийгөө шүүмжилж, үр чадвар болон сэтгэлгээгээ доогуур үнэлдэг байх магадлалтайг харуулж байна.

Амьдралын хүсэл эрмэлзлэлийн сөрөг нөлөө нь өндөр хүсэл тэмүүлэлтэй хүүхэд, залуучууд өөрсдөдөө илүү өндөр шаардлага тавьж, улмаар ESEL үр чадвараа сайжруулах хэрэгцээгээ илүү ихээр мэдрэхэд хүргэдэг байх магадлалтай.

- **Цаашдын судалгаанд зориулсан зөвлөмжүүд:**
 - Судалгааны арга, аргачлал ялангуяа судалгааны асуулгыг дахин үнэлэхийг зөвлөж байна. Хэт урт асуулт болон ойлгомжгүй хэллэг нь оролцогчдыг ядрааж, судалгааны ерөнхий үр дүнд нөлөөлөх эсвэл төөрөгдөлтэй хариулт өгөхөд хүргэх эрсдэлтэй.

ФБЯ-ын үр дүн нь ESEL сургалтын бодит амьдрал дээрх үр нөлөө болон хэрэглээний талаар үнэ цэнтэй ойлголтыг өгсөн юм:

- **ESEL сургалтын талаарх эерэг үзэл бодол:**

- Багш болон сурагчид ESEL сургалтын уян хатан байдал болон ач холбогдлын талаар эерэг сэтгэгдэлтэй байсан. Багш нарын хувьд хөтөлбөр янз бүрийн сурагчдын хэрэгцээнд нийцсэн байдалд сайшаалтай хандаж байсан бол сурагчид сургалтад өндөр идэвхи, сонирхолтой оролцож байсан.

- **Сурагчдын зан байдалд үзүүлэх нөлөө:**

- ESEL сургалт сурагчдын багаар ажиллах ур чадвар, харилцааны ур чадвар, хариуцлагатай байдал, цагийн менежмент болон манлайлал зэрэг чухал зан чанарт эерэг нөлөө үзүүлсэн. Ялангуяа эмэгтэй сурагчдын хувьд эдгээр ур чадвар нь мэдэгдэхүйц сайжирсан.

- **Агуулга ба бүтэц:**

- Сургалтын агуулгыг үр дүнтэй гэж үзсэн бөгөөд хичээлийг хувь хүний давуу тал, хэрэгцээнд нийцүүлэхэд анхаарсан байсныг тодотгосон. Цаашид хөтөлбөрийн зорилтот хүн ам зүйн хүрээг өргөжүүлж, албан ёсны сургалтын хөтөлбөрт тусгаж, илүү өргөн хүрээнд ашиглах санал дэвшүүлсэн.

- **Багт суурилсан сургалт:**

- Оролцогчид багийн ажиллагааг дэмжих сургалтын хэлбэрт сайшаалтай байсан боловч цагийн хуваарийн таарамжгүй байдал болон үл ойлголцолтой холбоотой бэрхшээлүүд байсныг хэлсэн.

- **Багшийн заах арга барил болон хандлага:**

- Багш нарын харилцааны ур чадвар, оролцогчдыг идэвхижүүлэх арга барил болон эерэг хандлагыг өндрөөр үнэлсэн ба тэдний дэмжлэг, хошин мэдрэмж зэрэг нь сургалтын эерэг орчныг бүрдүүлж, сурагчдын сэтгэл ханамжид нөлөөлсөн.

- **Эзэмшсэн болон ашигласан ур чадвар:**

- Сурагчид багаар ажиллах, үр дүнтэй харилцах, төсөл төлөвлөлт, санхүүгийн удирдлага зэрэг чухал чадваруудыг эзэмшсэн ба сургалтын явцад эдгээр ур чадварыг практикт хэрэгжүүлснээр зан байдал болон гүйцэтгэл сайжирсан.

- **Төсөл санаачлах болон бичил төслийн тэтгэлгийн үйл ажиллагааны оролцоо:**

- Олон оролцогчид Пич уралдаанд идэвхитэй оролцож, бичил тэтгэлэгийн санхүүжилт авсан нь бизнесийн санаа бүхий төслөө хэрэгжүүлэн практик туршлагатай болох боломжийг олгож, сурагчдын урам зоригийг дээшлүүлж, энтрепренер ур чадвар болон нийгмийн харилцааг хөгжүүлэхэд түлхэц болсон.

- **Өргөжүүлэх хүсэлт:**

- о Оролцогчид хөтөлбөрийн цар хүрээг өргөжүүлэх ихээхэн хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн ба санхүүжилтийг нэмэгдүүлж, хамрах хүрээг тэлэхийн чухлыг илэрхийлж, уг хөтөлбөр хувь хүний үр чадварыг хөгжүүлэх, нийгмийн харилцааг төлөвшүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн гэдгийг онцолсон.

ESEL сургалтын хөтөлбөр нь мэдлэг олж авах, зан байдал өөрчлөгдөх болон багаар ажиллах, харилцааны болон манлайллын үр чадваруудаа хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй байсан. Тус сургалт ESEL мэдлэг болон өөрийгөө танин мэдэх боломжийг нэмэгдүүлж байсан хэдий ч ESEL үр чадвар болон сэтгэлгээнд үзүүлэх шууд нөлөө бага байлаа. Чанарын судалгааны үр дүнгээс харахад хөтөлбөрийн амжилт нь сурагчдыг татан оролцуулах, багаар ажиллах үр чадварыг хөгжүүлэх, олж авсан мэдлэг үр чадвараа практикт хэрэгжүүлэх зэрэгт оршино. Хөтөлбөрийг өргөжүүлж, судалгааны хэрэгслүүдийг сайжруулах нь хөтөлбөрийн үр нөлөөг нэмэгдүүлэх, ирээдүйд хүрэх боломжийг нэмэгдүүлэх болно.



5. ДҮГНЭЛТ

5.1. Үндсэн болон хяналтын бүлгийн харьцуулалтын дүгнэлт

Энэхүү судалгаанд 13-19 насны 785 оролцогчид хамрагдсан бөгөөд дундаж нас нь 15.7 байв. Судалгааны үр дүнд дараах гол дүгнэлтүүдийг гаргалаа:

- **ESEL мэдлэг:** Үндсэн бүлгийн оролцогчид хяналтын бүлэгтэй харьцуулахад ESE мэдлэгийн хувьд илт давуу талтай байсан ба энэ нь бүлгүүдийн гол ялгаа байв.
- **ESEL Ур чадвар ба Сэтгэлгээ:** ESEL ур чадвар, сэтгэлгээ болон Амьдралын хүсэл эрмэлзлэлийн хувьд хяналтын бүлэг болон үндсэн бүлгийн хооронд ямар нэг ач холбогдол бүхий ялгаа илрээгүй.
- **ESEL Мэдлэг, Нас, Амьдралын хүсэл эрмэлзлэлийн нөлөө:** Регрессийн шинжилгээгээр ESEL мэдлэг, амьдралын хүсэл эрмэлзлэл болон нас нь ESEL ур чадвар, сэтгэлгээнд чухал нөлөө үзүүлдгийг харуулсан ба уг харилцааг дараах тэгшитгэлээр илэрхийлж болно:

$$\text{ESEL ур чадвар, сэтгэлгээ} = 1.802 - 0.019 \times (\text{ESEL Мэдлэг}) + 0.398 \times (\text{Амьдралын хүсэл эрмэлзлэл}) - 0.021 \times (\text{Нас})$$

$$\text{ESEL ур чадвар, сэтгэлгээ} = 1.802 - 0.019 \times (\text{ESEL мэдлэг}) + 0.398 \times (\text{Амьдралын хүсэл эрмэлзлэл}) - 0.021 \times (\text{Нас})$$

- ESEL мэдлэг болон нас нэмэгдэх тусам ESEL ур чадвар, сэтгэлгээ сайжирна.
- Харин амьдралын хүсэл тэмүүлэл нэмэгдэх тусам ESEL ур чадвар, сэтгэлгээний оноо өсөх ба энэ нь илүү өндөр амжилтанд хүрэх зорилготой залуучууд өөрийн ур чадвараа илүү хөгжүүлэх хэрэгтэй гэж үздэг болохыг харуулж байна.
- Тоон үр дүн: Тус сургалт нь энтрепренерийн сэтгэлгээ болон харилцааны ур чадварыг мэдэгдэхүйц ахиц үзүүлэхэд нөлөөлсөн.

5.2. Суурь болон эцсийн судалгааны үр дүнгийн харьцуулалтын дүгнэлт

- **Мэдлэг болон Ур чадварын ахиц:** Сургалтад хамрагдсаны дараа үндсэн бүлгийн оролцогчдын мэдлэг болон ур чадвар сайжирснаас гадна амьдралын зорилго болон боломжуудад илүү өөдрөг хандлагатай болсон нь илт ажиглагдсан.
- **Эмэгтэй оролцогчид ба насаар ах оролцогчид:** Эмэгтэй оролцогчид болон 16-19 насны хүүхэд, залуучууд ESEL мэдлэгээрээ бусад бүлгээс илүү өндөр үзүүлэлттэй байсан. Гэсэн хэдий ч сургалтын дараа ESEL ур чадвар болон амьдралын хүсэл эрмэлзлэл хоорондох хүйсийн ялгаа илрээгүй.
- **AV тохируулга хийсэн ESEL ур чадварын оноо:** Үндсэн бүлэг нь хяналтын бүлэгтэй харьцуулахад Нийгэм, соёлыг танин мэдэх, Харилцааны ур чадвар болон Өсөн дэвших сэтгэлгээ хэсэгт илүү өндөр үзүүлэлттэй байсан.

5.3. Тоон болон чанарын судалгааны тойм

- **Зан чанарын өөрчлөлт:** ФБЯ-аас гарсан чанарын судалгааны үзүүлэлтүүд нь тоон судалгааны үр дүнг баталсан бөгөөд сурагчдын харилцааны ур чадвар, хариуцлага, цагийн менежментийн чадварууд сайжирч, амьдралын зорилго болон боломжуудад илүү өөдрөг хандлагатай болсон байна.
- **Багаар ажиллах ба ур чадвараа хөгжүүлэх:** Багш нар болон сурагчид сургалтын хөтөлбөрт ялангуяа багаар ажиллах болон харилцааны ур чадваруудад эерэг сэтгэгдэлтэй байсан. Мөн тус сургалтыг өөрийгөө танин мэдэх, санал бодлоо үр дүнтэй

илэрхийлэх, санхүүгийн үр чадваруудыг хөгжүүлэхэд үр нөлөөтэй гэж дүгнэв.

- **Сурагчдын оролцоо ба үе тэнгийнхнээсээ суралцах:** Сурагчдад баг төвтэй сургалтын хэлбэр таалагдсан бөгөөд багийн ажлын үед тулгарсан бэрхшээлүүдийг багийн ажиллагаа сайжруулах боломж гэж үзжээ. Энэ нь өөрийн болон үе тэнгийн харилцааг бэхжүүлэхэд нөлөөлсөн байна.

5.4. Хөтөлбөрийг сайжруулах санал

- **Сургалтын арга барилыг өргөжүүлэх ба тохируулах:** Уг сургалт нь танхимын болон зайны сургалтыг хослуулан хэрэгжүүлсэн нь амжилттай байсан ба ялангуяа сургуулиас гадуурх хүүхэд, залуучуудад тохиромжтой байв. Иймээс онлайнаар эсвэл гар утас ашигласан сургалтыг зохион байгуулах зэргээр хосолсон буюу холимог сургалтын загваруудыг өргөжүүлэх нь хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- **Багшийн Дэмжлэгийг Сайжруулах:** Давтан сургалт болон үе тэнгийн менторшип зэргээр багшийг тасралтгүй хөгжүүлснээр сургалтын чанар ялангуяа хөдөө орон нутаг болон нөөц боломж хомс бүс нутагт сургалтын чанарыг сайжруулахад нөлөөлнө.
- **Насан туршийн үр чадварт анхаарах:** Хөтөлбөр нь энтрепренерийн сэтгэлгээ, харилцааны үр чадвар зэргийг сайжруулсан ч санхүүгийн мэдлэг, бизнес төлөвлөлт болон дижитал хэрэгслийн тухай хөтөлбөрт тусгаснаар хүүдэд, залуучуудыг цаашдын бодит амьдрал дээрх сорилт болон ажил мэргэжлийн боломжуудад бэлтгэх болно.



6. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

6.1. Бодлогын санал, зөвлөмж

Эцсийн үр дүнгийн судалгааны үр дүнд үндэслэн дараах санал зөвлөмжүүдийг санал болгож байна. Үүнд:

- **ESEL сургалтыг үндэсний сургалтын хөтөлбөрт тусгах:** ESEL үр чадваруудыг илүү өргөн хүрээгээр тогтмол хүргэхийн тулд сургалтыг үндэсний боловсролын хөтөлбөрт тусгах нь хувь хүний үр чадварын хөгжлийг стандартчилан хэрэгжүүлэхэд тусална.
- **Залуучуудын бизнес эрхлэлтийг дэмжих:** Бичил тэтгэлэгт санхүүжилтийн хөтөлбөрүүд болон менторшип хөтөлбөр зэргээр залуучуудын энтрепренерийн сэтгэлгээг бодлогоор дэмжсэнээр залуучууд өөрсдийн санаагаа амжилттай бизнес болгон хөгжүүлж орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулна.
- **Хүйсийн тэгш байдлыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх:** Эрэгтэй болон эмэгтэй оролцогчдын эерэг өөрчлөлтүүдийг амжилттайгаар дэмжин хөгжүүлсэн нь боловсрол болон эдийн засгийн боломж дахь хүйсийн ялгаатай байдлыг бууруулах жендэрийн мэдрэмжтэй стратеги чухал болохыг харуулж байна.

6.2. Цаашдын судалгааны чиглэл

- **Урт хугацааны үр нөлөөний үнэлгээ:** Цаашдын судалгаагаар урт хугацааны (longitudinal) арга ашиглан карьерийн амжилт, орлогын түвшин, ерөнхий амьдралын чанар зэрэгт ESEL сургалтын үзүүлсэн урт хугацааны үр нөлөөг судлах хэрэгтэй.
- **Нийгмийн сүлжээний үүрэг:** Цаашдын судалгаагаар хүүхэд, залуучууд хэрхэн нийгмийн сүлжээг ашиглан өөрийн үр чадваруудаа бодит амьдрал дээр ашиглаж, сургалтын нөлөөллийг хэрхэн бэхжүүлж байгааг судлах хэрэгтэй.
- **Өргөжүүлэх болон давтах:** Нийгэм эдийн засгийн ижил төстэй асуудалтай өөр өөр бүс нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, давтах боломжийг судлах нь чухал. Соёлын ялгаа, ложистикийн болон нөөцийн хязгаарлагдмал байдал зэргийг ойлгох нь хөтөлбөрийг үр дүнтэй нутагшуулах болон янз бүрийн нөхцөлд хэрэгжүүлэхэд тусална.

